бүгд батлагдаад явсан. Сүүлийн өдөр тийм юм ярьж болохгүй ээ. Өмнө нь тэгээд хуулиа санаачлаад хэлэлцүүлэх, зөндөө хууль санаачилж хэлэлцсэн. Ер нь тэр хувийн хэвшилтэй холбоотой асуудал бол бас анхаарах ёстой асуудал. Бусад нь бол яригдаагүй. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуудлууд биш байна. Ажлаа сайн хийцгээх хэрэгтэй. Ажлаа хийгээгүй байж ингэж яриад байж болохгүй.

Ингээд хуулийн төслүүд эцэслэн батална. 21 хуулийн төсөл, түүнтэй хамт ... өмнө нь ярьж байхгүй яасан юм бэ. Тэгээд Их хурал руугаа тэгдэг. Одоо болно. Хэлэлцэх асуудалтай огт холбоогүй, гэнэт сэрсэн юм шиг чуулганы хаалтын өдөр, завсарлах өдөр ингээд юм ярьж болохгүй. Гэнэт сэрч болохгүй. Сонгууль болохоор гэнэт сэрч болохгүй. Ажлаа 4 жил хийж, ярьж байхгүй яасан юм.

Ингээд 21 хуулийн төслийг эцэслэн батална. Түүнтэй хамт дагалдаж өргөн барьсан, холбогдуулан боловсруулсан 113 хууль нийтдээ батална гэсэн үг. Хуулийн төсөл батлагдана. Энэ хуулийн төслүүд эцэслэн батлагдаж байж чуулганы хуралдаан завсарлах учиртай. Эцэслэн батлах санал хураалтыг Байнгын хороод хуралдаж дуусаад, ирцийн шаардлага хангасан үед эцэслэн батлах санал хураалт явуулахаар шийдвэрлэе.

Энэ асуудлуудын дараа хуулийн төслүүдийг эцэслэн батална гэж тооцоолох хэрэгтэй. 113 хууль. 21 хуультай хамт өргөн мэдүүлсэн 92 хуулийг батална.

Хэлэлцэх асуудалдаа орё.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг

Улсын Их Хурлын гишүүн Жамьяанхорлоогийн Сүхбаатар танилцуулна. Сандагийн Бямбацогт гишүүн. Бямбацогт гишүүн бас алга байна. Нямаагийн Энхболд дарга. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга танилцуулъя.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Энхболд төслийн бүсчлэлийн тогтолцоо гэсэн 2 дугаар бүлгийн 2.1 дэх хэсгийн томъёоллын агуулгыг алдагдуулахгүйгээр найруулгын шинжтэй засвар хийж, төслийн 1 дүгээр хавсралт буюу улсын тусгай хамгаалалт авах газар нутгийн хэмжээ нь шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй байгаатай холбогдуулан холбогдох ямаар дахин нягтлуулж өөрчлөх, бүсүүдэд хамаарах аймгуудын хуваарийг уян хатан өөрчлөх болон бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үе шатыг өөрчилж болох зохицуулалтыг тус тус хасах, төслийн 2 дугаар хавсралт буюу шалгуур үзүүлэлтийн авто замын урттай холбогдох хэсэгт тоо баримтыг

нийцүүлж өөрчлөх, төслийн зүйл, хэсэг, заалтын хоорондын нийцлийг хангах, тоон мэдээллийг дахин нягтлах чиглэх чиглэлээр 17, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Хангайн, Баруун, Говийн бүсэд Арцсуурь боомт, Шивээ хүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн өндөр хурдны авто замын бүсэд ноогдох хэсгийг барих талаар зарчмын зөрүүтэй 1 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Туваан гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Ажлын хэсэг гэж юу ч хийдэггүй ажлын хэсэг. Хамаг юм хасаад хаячихсан. Эрдэнэбаяраа худлаа ярьж болохгүй шүү. Энийг батлахгүй шүү.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Бүсчилсэн хөгжлийн талаар бас намууд тодорхой хөтөлбөр гаргаж, энэ бүсийг хөгжүүлэх талаар өөр өөрийн үзэл баримтлалын дагуу мөрийн хөтөлбөртөө тусгасан байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол Их Хурлын гишүүн бүсчилсэн хөгжлийн талаар бас тодорхой зүйлүүдийг энэ сонгуулийн хугацаанд ярьж явах ёстой.

Тэгэхээр Шадар сайд Хүрэлбаатар намайг энэ бүсчилсэн хөгжлийн талаар ажиллахгүй юм уу, бусад сум, аймгаас санал авахгүй юм уу гэж янз янзаар ярьж байх шиг байна лээ. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжил гэдэг чинь бол энэ тодорхой нам хөтөлбөр гаргаад, тэр

хөтөлбөрийн дагуу парламентад ялсан Засгийн газар тэр хөтөлбөрөө хэрэгжүүлээд явдаг. Өнөөдрийн цөөнх бол энэ дээр сонгууль дээр л санал бодлоо уралдуулна уу гэхээс өнөөдрийн энэ зүйлд санал бодлоо тусгаад л явна. Тэгэхээр нэг зүйлийг хэлэхэд бол яг тийм хувь хүний характераар, хувь хүний үзэл бодлоор энэ хөгжлийн талаар хөгжлийн эсрэг бас ярих нь буруу юм л гэдгийг бас Хүрэлбаатар сайдад хэлье гэж бодлоо.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд олон олон төрийн өндөр албан тушаалууд хашиж байсан. Сангийн сайдыг хэд хэдэн удаа хийж байсан. Төсвийн байнгын хорооны даргаар ажиллаж байсан. Энэ хугацаандаа тэгээд тухайн аймаг, сумаа хөгжүүлдэг бол Увс аймгийг их сайхан хөгжүүлчихээр сайхан хугацаа өнгөрлөө л дөө. 20 хэдэн километр байдаг өөрийнхөө сум руу байтугай, 3км, 7км дутуу Түргэн, Сагил сум руу зам тавихгүй л өнөөдрийг хүрсэн байна шүү дээ. Яах вэ, тэгээд авто замын зам тавьдаг компанитай болохлоор л тавих юм шиг байна л даа. Би тэгж л бодож байгаа. Тэгэхээр энэ бүсийн хөгжил дэвшил гэдэг бол бид нар тодорхой бодлого гаргаж байгаа. Түүнийхээ төлөө явна. Мэдээж өнөөдрийн энэ дээр дэмжээд, бүсчилсэн хөгжлийн чинь энэ тогтоолын төслийг бол дэмжээд явна. Ер нь аливаа нам улс төрийн сонгуульд ялж гарч ирж болно. Урд талын хийсэн намынхаа үйл ажиллагааг бас тодорхой зөв саналуудыг нь аваад, зарим нэгэн үзэл баримтлал таарахгүй тэр саналуудыг урагшаа аваад явах нь зүйтэй л гэж би үздэг.

Тийм учраас өнөөдрийн энэ тогтоолын төсөл бол олон олон зөв зүйлийг агуулсан ийм тогтоолын төсөл байгаа. Тэгээд дэмжээд явна. Цаашидаа эндээс хамгийн сайныг нь дараагийн парламентад илүү сайжруулаад, илүү зөв болгоод, намын хөтөлбөрүүдтэй уялдуулаад явах нь зүйтэй гэж би үзэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ сүүлийн өдөр жоохон хэрүүл маргаанаа багасгамаар байна шүү нөхөд өө. Энэ бүсчилсэн хөгжлийн талаар бид нар их олон жил ярьж байгаа юм. Тэгээд ямар ч байсан нэг тогтоол батлаад, сонгуулийнхаа системийг бид нар ингээд болдоггүй бүтдэггүй байсан энэ зүйлээ 5 бүс болгож хуваагаад, ингээд энэ маань бас бодитой амьдрал дээр явахаар ийм нөхцөл байдал үүсэж байгаад бол дэмжиж байна. Энэ тогтоолын төслийг бол дэмжиж байна.

Ялангуяа бид бүхэн бол энэ Хангайн тойрог гэж яриад байгаа 1 дүгээр тойрог байна. 1 хэсэг Монгол Улсын эзэнт улсын нийслэл Хархорум гэж байсан. Одоо бол Хархорин. Бүх зам Хархорин ордог байлаа шүү дээ. 800-хан жилийн өмнө. Энэ байдлыг энэ тойрогт нэр дэвшиж байгаа бид бүхэн бол хийнэ. Алтан гурвалжин, Алтан дөрвөлжин болох бүрэн боломжтой. Арвайхээр, Цэцэрлэг, Баянхонгор, Хархорин гээд энийг ингээд холбоод үзэхээр бол ерөөсөө үнэхээр нэг их сайхан Алтан гурвалжин, Алтан дөрвөлжин Монгол Улсын эзэнт гүрэн яаж цэцэглэж хөгжиж байлаа, Дэлхийн бүх зам Хархорин ордог байсан энэ зүйлийг сэргээж хийнэ хэдүүлэ. Одоо л нэг зөв замаар орох гэж байна. 70-аад жил бол 200-аад жил, нийтдээ 300-аад жил бол Монголчуулыг хэсэглэн бутаргах, хуваах, жижиглэх талын нэг тараах ийм бодлого байсан. Энэ ч үргэлжилсээр байгаад өнөөг хүрсэн байна. Нэг сайн юм нь бид бүхэн нэгдэж нягтарч улс орноо зөв хөгжүүлэх. Манай Улаанбаатар маань ч хэцүү болчихлоо шүү дээ. Энэ хөрсний бохирдол, агаарын бохирдол, энэ түгжрэл гээд. Тийм учраас олон газрууд нийслэлээ нүүлгэдэг, хотоо нүүлгэж байсан. Орхоны хөндий эртний түүх дурсгалтай Монголчуудад ээлтэй олон соёл иргэнилийн өлгий болсон тэр нутаг руугаа бас Монгол Улсын нийслэл маань удахгүй нүүж очно гэдэгт бол эргэлзэхгүй байна.

Тэгээд энэ ажил дараагийн 4 жилд бол нэлээн тууштай, шуурхай, сайн явна

гэж бодож байна. Тэгээд манай нөхдүүд бас дутуу дулимаг юм их хийх юм. Сэтгэлийн хөөрлөөр. Ингээж хандаж болохгүй. Судалгаа тооцоон дээр ингээж ажиллах ёстой гэж бодож байна. Тэгээд тэр тусмаа энэ тогтоолыг батлахад 2 гараа өргөөд дэмжиж байна. Манай аавын нутаг байгаа. Би чинь ааваараа бол Түшээт ханы Түшээт гүний хошууны одоогийн Хархорин сумын та нар инээх юм байхгүй. Жинхэнэ хаанаас нь ч юугаар ч харсан тэр нутгийн гаралтай ийм байгаа. Ер нь бид нар тэгээд л нэг янз бүрийн жижиг сажиг тэр нь тийм, энэ нь ийм гээд л нэг угсаа гарал 2-ын хооронд юм яриад л ингээж байхаа болимоор байгаа юм. Ерөөсөө Монгол хүн бол Монгол хүн. Хүн бол хүн шүү дээ. Монголын төлөө цохилох зүрхтэй, зоригтой байх хэрэгтэй. Тэгээд ийм Баруун хүрээний эд Шанх багийн хүн л дээ манай аав. Ер нь энэ коминтерн коммунистуудын үед хэлмэгдэж байсан юм ч бий. Гэхдээ тэр яах вэ тэгээд Монголын түүх тийм л байдгаас хойш. Одоо бас энэ хэлмэгдүүлэлт ахиад битгий яваасай гэж бодож байна. Нэг намыг удаан хугацаагаар олон жил бариулах нь бас буруу юм байна шүү. Ер нь бас ээлжилж солбиж явах нь.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Их хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа юм. Одоо бид бүхэн 2001 онд энэ бүсчилсэн хөгжлийн бодлогоо батлаад 23 жил өнгөрсөн.

Харамсалтай нь энэ талаараа олигтой юм хийж чадаагүй. Тэгээд нэг шалтгаан нь бол энэ Улсын Их Хурлын тойргийг бүсүүдээ дагуулж баталж өгөөгүйтэй холбоотой юм болов уу гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ удаагийн 2024 оны сонгууль бол энэ бүсчилсэн байдлаар хуваарилсан байдлаар энэ Их Хурлын тойргуудыг баталсан учраас энэ бодлого нь явна гэж ингээж харж байгаа

юм. Тэгэхээр бүс гээд бүсчилсэн хөгжил дээр манайхан хөдөө, орон нутгийн 21 аймгаа 7 бүс болгоод, төвдөө Улаанбаатарын бүс гэж нэрлэж байх шиг байна. Тэгэхээр энэ дээр хэд хэдэн чухал асуудлууд байгаа юм. Яг энэ бүсчилсэн хөгжлийн бодлогыг Улсын Их Хурлын тогтоол гараад, Засгийн газрын шийдвэр гараад, ард иргэдэд танилцуулаад асуугаад, саналаа хэл гээд явахаар ойлголт алга. Ямар ч ойлголтгүй байна. Тэгэхээр бид бүхэн энэ тогтоолын төслөө батлаад араас нь сайн сурталчилж ингээж хөгжих гэж байгаа шүү, ийм бодлого төр барих гэж байгаа шүү гэдэг байдлаараа нэлээн танилцуулгыг энэ Их Хурлын Тамгын газар, хүрээлэн, гишүүд маань бас танилцуулмаар байгаа юм. Яаж хөгжих гээд байгаа, яаж улсын бодлого явах гэж байгаагаа ойлгохгүй иргэн олон байна. Тэгэхээр сурталчилгаа муу байна гэсэн үг.

Манай төвийн бүсийн хувьд бол нэр нь ч гэсэн төвийн бүс, төв цэг. Тэгээд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хамгийн суурь хэсэг болсон энэ хатуу дэд бүтэц буюу авто зам, төмөр зам хамгийн нягтаршил сайтай ийм бүс байгаа.

Тэгэхээр энэ дээр бол хөгжих нөхцөл нь бүрдчихсэн. Тэгэхээр энэ дээр 2 зүйл яримаар байгаа юм. Юу гэхлээр бид нар Дарханы зам дээрээ бас муулаад яах вэ нэлээн хугацаа алдчихлаа. Цаашиаад энэ Дархан, Сэлэнгийн хоорондох зам яг хуучнаараа 2 эгнээтэй нарийн зам байгаа. Маш нарийнхан зам. Тэгэхээр бид нар бүсчилсэн хөгжил ярьж байгаа бол, улс хоорондын бүсийн асуудал ярьж байгаа бол энэ Дархан, Сэлэнгийн зам бол зайлшгүй өргөн, 4 эгнээтэй зам болох ёстой. Тэгэхээр бид нар энэ дээр урьдын алдаагаа давтаж Дарханыхаа 2 эгнээ замыг битгий хуулаасай гэдэг ийм хүсэлтийг хэлээд байгаа.

Тэгэхээр энэ дээр бас Зам, тээврийн яам зөвшөөрч, яг тэр дагуу явна гэж байгаа юм. Тэгтэл бас яг энэ Дарханаас

хойш гарч байгаа замуудын эгнээг бас ингээд хуулаад шинэчлэх байдалтай юмнууд явж байгаа. Энэ дээр нэлээн иргэд санаа зовж байгаа шүү гэдгийг бас энэ даширамд хэлье. Ингээд манай төвийн бүс бол хөдөө аж ахуй, ялангуяа хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл дээр нэлээн түлхүү хөгжих, Монголчуудыг хоолтой байх уу, хоосон хонох уу гэдгийг шийдэх ийм бүс байгаа. Тэгэхээр.../минут дуусав/

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуусангүй. Сонгуулийн сурталчилгааны маягтай ард түмэнд таалагдах гэсэн үгнүүд л хэллээ. Санал хураалтаа орно. 16 саналтай. Байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нэг.Монгол Улсын бүсчилсэн үзэл баримтлал бол батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсгийн “долоон” гэснийг хасаж, мөн хэсгийн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсыг эдийн засгийн” гэснийг “Монгол Улсыг” гэж, мөн хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг “Бүсүүдэд дараах аймаг, хотууд хамаарна” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт 65,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсгийн “Монгол Улсын бүсчлэлтэй уялдуулан” гэснийг, мөн хэсгийн “уян хатан” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн “тогтоож,” гэснийг “тогтоох бөгөөд” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. 65,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.1 дэх заалтын “Улаанбаатар хотын засаглалын” гэснийг, 3.7.25 дахь хэсгийн “50.0 тн багтаамжтай” гэснийг, 3.7.27 дахь заалтын “5” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. Хасна гэсэн. 60,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.2 дахь заалтын “Төрийн” гэсний дараа “зарим” гэж, 3.7.28 дахь заалтын “шинэчилж” гэсний өмнө “олон улсын стандартад нийцүүлэн” гэж нэмж, “3.1.29.Цэцэрлэг хот-Баянхонгорхот чиглэлийн авто зам барина.” гэж нэмж, 3.5.3 дахь заалтын “тахилгат хайрхан уулс, хүн чулуун хөрөгт” гэснийг “байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлд” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.17 дахь заалтын “3.6 сая” гэснийг “5.4 сая” гэж, 3.2.6 дахь заалтын “4.2 сая” гэснийг “5.8 сая” гэж, 3.3.10 дахь “1.5 сая” гэснийг “3.1 сая” гэж, 3.4.10 дахь заалтын “672.4 мянган” гэснийг “1.5 сая” гэж, 3.5.10 дахь заалтын “1.7 сая” гэснийг “3.0 сая” гэж, 3.6.13 дахь “2.2 сая” гэснийг “3.0 сая” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. 58,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсгийн “дараах үе шатаар хэрэгжүүлэх бөгөөд эдийн засгийн нөхцөл байдал, төсөл хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, эрэмбэтэй уялдуулан тухай бүр тодотгол хийж болно.” гэснийг “дараах үе шаттай хэрэгжүүлнэ.” гэж өөрчилж, мөн хэсгийн “(2041-2050 он хүртэлх)” гэсний дараах “гэсэн үе шатаар хэрэгжүүлнэ” гэснийг хасах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын 5.1 дэх хэсгийн “удирдах,” гэснийг, 6.1.3 дахь хэсгийг бүхэлд нь хасаж, 6.1 дэх хэсгийн “Төрөөс бүсчилсэн хөгжлийн бодлого” гэснийг “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. 55,6-гийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” хэсгийн “Шалгуур үзүүлэлт” баганад “Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал” гэж, “Хэмжих нэгж” баганад “МВт” гэж, “2030” баганад “30” гэж, “Шалгуур үзүүлэлтийн тайлбар” баганад “Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй цугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.” гэж, “Мэдээллийн эх үүсвэр” баганад “Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт 54,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар хавсралтын “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж тохиолдол бүрд, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн мөрний “2050” баганын “386” гэснийг “40” гэж, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “2050” гэсэн баганын “487” гэснийг “394” гэж, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “2040” гэсэн баганын “464” гэснийг “685” гэж, “1.Хангайн бүс” гэсэн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2030” гэсэн баганын “330” гэснийг “210” гэж, “2050” гэсэн

баганын “642” гэснийг “0” гэж, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “2030” гэсэн баганын “471” гэснийг “752” гэж, “2040” гэсэн баганын “834” гэснийг “645” гэж, “2050” гэсэн баганын “525” гэснийг “0” гэж, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “2040” гэсэн баганын “145” гэснийг “249” гэж, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн “Хүчин чадал нэмэгдсэн боомтын тоо” гэсэн мөрний “2040” гэсэн баганын “1” гэснийг “2” гэж өөрчилж, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах төмөр замын урт” гэсэн мөрний “2040” гэсэн баганад “116” гэж, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах улсын чанартай автозамын урт” гэсэн хэсгийн “2050” гэсэн баганад “218” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. 56,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс”, “2.Баруун бүс” “3.Хойд бүс” “4.Төвийн бүс” “5.Зүүн бүс” “6.Говийн бүс”, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгүүдийн “Шинээр байгуулагдах үйлдвэр технологийн паркийн тоо” гэсэн мөрний “Шинээр байгуулагдах” гэсний дараа “хүнд үйлдвэрийн” гэж тус тус нэмж, “2.Баруун бүс”, “4.Төвийн бүс”, “5.Зүүн бүс”, “6.Говийн бүс”, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгүүдийн “Шинээр байгуулагдах үйлдвэр технологийн паркийн тоо” гэсэн мөрөнд “Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэж харгалзах мөрөнд нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. 56,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар хавсралтын “2.Баруун бүс”, “3.Хойд бүс”, “4.Төвийн бүс”, “5.Зүүн бүс”, “6.Говийн бүс” гэсэн хэсгүүдийн “Тусгай хамгаалалт авсан газар нутгийн хэмжээ” гэсэн мөрний “хариуцах байгууллага” баганын “Засгийн газар” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус, мөн дээрх

бүсүүд болон “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, тээвэр логистикийн төв” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” гэсэн баганын “Засгийн газар” гэснийг “Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус, “2.Баруун бүс”, “4.Төвийн бүс”, “5.Зүүн бүс”, “6.Говийн бүс”, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгүүдийн “Шинээр байгуулагдах үйлдвэр технологийн паркийн тоо” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” баганын “Засгийн газар” гэснийг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Хариуцах байгууллага” баганын “Засгийн газар” гэснийг “Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд санал хураалт.

Анандбазар гишүүн хаачих нь вэ. Та 2 Хаачих нь вэ. Санал хураалт явж байна. Байнгын хороо руу гялс ороод ирээрэй.

13.Төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн “Тусгай хамгаалалт авсан газар нутгийн хэмжээ” гэсэн мөрний “Суурь түвшин” баганын “10.9” гэснийг “3.8” гэж, “2030” гэсэн баганын “3.6” гэснийг “3.8” гэж, “2040” гэсэн баганын “2050” гэсэн баганын “1” гэснийг “0.8” гэж тус тус, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “14.5” гэснийг “12,6” гэж, “2040” гэсэн баганын “2050” гэсэн баганын “1” гэснийг “0,8” гэж тус тус, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” нь баганын “4.5” гэснийг “3.5” гэснийг “3.8” гэж “2040” гэсэн баганыг нь “0.5” гэснийг “2050” гэсэн баганыг нь “0.3” гэснийг “0.8” гэж тус тус, “4.Төвийн бүс” хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганыг “2.8” гэснийг “1.8” гэж, “2030” гэсэн баганыг “0.5”

гэснийг “0.6” гэж “2040” гэсэн баганыг “0.7” гэснийг “2050” гэсэн баганыг “0.1” гэснийг “0.5” гэж тус тус, “5.Зүүн бүс” хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганыг “6.4” гэснийг “5.1” гэж, “2030” гэсэн баганын “1.7” гэснийг “1.4” гэж, “2040” гэсэн баганын “2050” гэсэн баганын “1.0” гэснийг “0.8” гэж тус тус, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “6.2” гэснийг “5.7” гэж, “2030” гэсэн баганын “1.5” гэснийг “2.4” гэж, “2040” гэсэн баганын “0.7” гэснийг “2050” гэсэн баганын “0.9” гэснийг “0.3” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. 54,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 2 дугаар хавсралтын “1. Хангайн бүс”, “2 Баруун бүс”, “4.Төвийн бүс”, “5.Зүүн бүс”, “6.Говийн бүс”, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгүүдийн “Цахилгаан дамжуулах шугамын урт” гэсэн мөрний “Шалгуур үзүүлэлтийн тайлбар” баганын “Цахилгаан станц, шугамын дамжуулах чадвар нэмэгдсэн байна.” гэснийг “Шинээр барих “ахилгаан дамжуулах шугамын урт” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт 56,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 1 дүгээр хавсралтын 3 дугаар бүлгийн “3.1.Хангайн бүс”, “3.2.Баруун бүс”, “3.6.Говийн бүс” гэсэн хэсгийг тус бүр доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Арцсуурь боомт-Шивээ хүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн өндөр хурдны авто замын бүсэд ноогдох хэсгийг барина.”

Тайлбар: Энэ саналтай холбогдуулан “Төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай авто замын урт” гэсэн мөрний “2050” гэсэн баганын “119” гэснийг “342”, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн мөн

мөрний “2050” гэсэн баганын “386” гэсний “765” гэж, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “2050” гэсэн баганын “496” гэсний “639” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг. Санал хураалт. Асуулт байхгүй. Санал хураалт.. Пүрэвдорж гишүүн ээ суугаарай. 53,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1. Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсгийн хүснэгтийн “татагдах” гэснийг “таталцах” гэж, “Турав.Бүсүүдийн хөгжлийн зорилго, зорилтууд” бүлгийн “Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилго нь” хэсгийн “үндэслэж” гэснийг “үндэслэнэ” гэж, “илрүүлж” гэснийг “илрүүлнэ” гэж, “тодорхойлж” гэснийг “тодорхойлно” гэж, “сэргээж” гэснийг “сэргээнэ” гэж, “дэмжиж” гэснийг “дэмжинэ” гэж, “нэвтрүүлж” гэснийг “нэвтрүүлнэ” гэж, “хэрэгжүүлж” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж тус тус, “хуваарилж” гэснийг “хуваарилна” гэж, “дэмжиж” гэснийг “дэмжинэ” гэж, “хөгжүүлж” гэснийг “хөгжүүлнэ” гэж, “байгуулж” гэснийг “байгуулна” гэж тус тус, “тэлж” гэснийг “тэлнэ” гэж, “бууруулж” гэснийг “бууруулна” гэж, мөн хэсгийн “хөгжүүлнэ” гэсний өмнөх “бүс нутгийг” гэснийг “бүсүүдийг” гэж өөрчлөх.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.Баруун бүс”, “3.3.Хойд бүс”, “3.4.Төвийн бүс”, “3.6.Говийн бүс” гэсэн хэсгүүдийн зорилгын “бүс” гэсний дараах “нутаг” гэснийг тус тус хасах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал хураалт. Шуурхай явуулахгүй бол юм багтахгүй байна. Найруулгын санал дээр чинь дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ шүү дээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолтын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

11.11 цаг.

Дараагийн асуудал орно.

Үндсэн хуулийн цэцийн 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Дашбалбарын Гангабаатар танилцуулна.

Д.Гангабаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг уншиж сонсгоё.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай. Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим. 14 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр, илтгэгч, Д.Гангабаатар, Л.Өлзийсайхан, Э.Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлтээ хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Ч.Анар, Ш.Ербул болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 10 дахь заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндэслэл.

Нэг.Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтоох зорилт бүхий Цагдаагийн албаны тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалт цагдаагийн албан хаагч нь аливаа үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, үйл ажиллагааг нь сурталчлах, дэмжлэг үзүүлэхийг хориглохоор хуульчилсан байна. Үйлдвэрчний эвлэл нь иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаагаа явуулах иргэдийн сайн дурын нэгдэл бөгөөд тэдний үйл ажиллагаа нь ажилчдын хөдөлмөрлөх эрхийг хамгаалах хүрээнд захиргаа, ажил олгогчтой хэлэлцээ хийх, тодорхой шаардлага тавих, хөдөлмөрлөх эрхийг хохироосон шийдвэрийг түдгэлзүүлэх болон өөрчлөх, хүчингүй болгох, цуцлахыг шаардах, шүүх, хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх байгууллагад гишүүнийхээ эрх ашгийг төлөөлөн хамгаалах зэрэг хамтын үйл ажиллагаа зохион байгуулахаар чиглэгддэг болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх заалтад Монгол Улсын иргэн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй, 10 дахь заалтад нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхлын үүднээс олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй гэж заасан. Цагдаагийн албаны тухай хуулийн дээрх

заалтаар цагдаагийн алба хаагчийг үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэхийг хориглосноор тэдний хөдөлмөрлөх эрхээ хамгаалах буюу хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах хүрээнд эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болгон хуульчилсан байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтад заасан өөрсдийн ашиг сонирхлын үүднээс сайн дураараа эвлэлдэн нэгдэх үндсэн эрхийг зөрчсөн байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим болон хүний эрхийн талаарх хэм хэмжээг тусгасан 2 дугаар бүлгийн зохицуулалтын дагуу дээрх эрхийг үндэсний буюу нийтийн аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгын хүрээнд зөвхөн хуулиар хязгаарлаж болох бөгөөд энэхүү хязгаарлалт нь зорилгодоо нийцсэн буюу тухайн нөхцөлд тохирсон хэмжээ хэтрээгүй байдлаар хуульчлагдсан байх ёстой.

Хэрэв эдгээр нөхцөлийг хангаагүй бол хүний эрхийн зөрчил болох ба Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтаар холбогдох зохицуулалтаар хэт өргөн хүрээнд энэхүү үндсэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болгон хуульчилсан зорилгодоо нийцээгүй хэмжээ хэтэрсэн буюу тохирсон байх зарчмыг алдагдуулсан гэж үзэхээр байна.

Хоёр.Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт хүн бүр эрх ашигаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй гэж тус тус заасан.

Мөн иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор

өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй, 2 дахь хэсэгт энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт хийж болохгүй.

Зэвсэгт хүчний болон цагдаагийн бүрэлдэхүүнд багтах этгээд энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд хууль, ёсны, хязгаарлалт тогтооход энэ зүйлд саад болохгүй, 3 дахь хэсэгт энэ зүйлийн аль ч заалт эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрх чөлөөний тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1948 оны конвенц нэгдэн орсон улсын хувьд түүнд заасан баталгаанд харшлах хууль тогтоомж гаргах буюу хуулийг эдгээр баталгаанд хохирол учруулахаар хэрэглэх эрх үл олгоно гэж заасан бол Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын фактын 8 дугаар зүйлд, эдийн засаг, нийгэм, соёлын эрх хүрээнд хүрээнд үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан хэм хэмжээ тусгажээ.

Харин дээр дурдсан эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрх ашгийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1948 оны 87 дугаар конвенцын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт энэхүү конвенцод заасан баталгааг зэвсэгт хүчин цагдаагийн байгууллагын хувьд ямар хэмжээгээр хэрэглэж болохыг үндэсний хууль тогтоомжид тодорхойлно гэж заажээ.

Мөн тус байгууллагаас хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны өвөрмөц тогтолцоо, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг ухамсарлаж олон улсын хөдөлмөрийн стандартын дагуу хууль сахиулах байгууллагын албан хаагчийн эрхийг хүндэтгэхийг гишүүн орнуудад уриалсан байна.

Үүнээс үзэхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрх, тэр дундаа хөдөлмөрлөх эрхээ хамгаалах, хөдөлмөрийн ажлын нөхцөлөөр хангуулах хүрээ дэх цагдаагийн алба хаагчдын эвлэлдэн нэгдэх эрхийг хуульд заасан тодорхой үндэслэлээр зорилгодоо нийцсэн байдлаар хуулиар хязгаарлаж болохыг олон улсын гэрээ конвенцоор хүлээн зөвшөөрсөн боловч бүрмөсөн хориглосон хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжоор тогтоохыг хүлээн зөвшөөрсөн дэмжсэн агуулга тусгагдаагүй байна.

Энэ хүрээнд гадаад орнуудын хууль тогтоомжийг харьцуулсан судалгаанаас харахад зарим улсад цагдаагийн байгууллага үйлдвэрчний эвлэлтэй байхыг зөвшөөрдөг байна. Ийнхүү зөвшөөрсөн улс орнууд нь хуулиар тодорхой зохицуулалтыг тусган тухайн үйлдвэрчний эвлэл нь цагдаагийн албан хаагчдын цалин хөлс авах, хөдөлмөрлөх эрхийг хамгаалах чиглэлээр гол төлөв үйл ажиллагаа явуулахаар заажээ. Дээр дурдсан үндэслэлд холбогдох эрх зүйн эх сурвалж зэргээс үзэхэд цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хүрээ дэх эвлэлдэн нэгдэх эрхийг шууд хориглох бус, үндэсний буюу нийтийн аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор тодорхой үйл ажиллагааг шаардлагатай үед хязгаарлах үндэслэлийг нарийвчлан хуульчлах нь зүйтэй байгааг тэмдэглэж байна.

Холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг судлан үзэхэд цагдаагийн алба хаагчийн эвлэлд нэгдэх эрхэд хангалттай хязгаарлалт тогтоосон гэж үзэхээр байна.

Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар цагдаагийн албан хаагч нь төрийн тусгай албан хаагчид хамаарах бөгөөд тус хуулийн 39 дүгээр зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн холбогдох заалтаар тэднийг аливаа ажил хаялт болон төрийн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн

бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцохыг хориглохоор нарийвчлан тусгасан нь хууль ёсны хязгаарлалт болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын холбогдох хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

Нэг.Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба хаагчид дараах зүйлсийг хориглоно” гээд 69.1.8 дахь заалтад “нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэгэн нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх” гэж заасны “...үйлдвэрчний эвлэлийн ..., үйлдвэрчний эвлэлийн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол ... -ын үүднээс ... олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.” гэснийг зөрчсөн байна.

Хоёр.Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын “нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх” гэсний “үйлдвэрчний эвлэлийн” гэснийг мөн “нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа” гэсний “үйлдвэрчний эвлэлийн “гэж заасныг тус тус Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Гурав.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу

хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Ж.Эрдэнэбулган, Гишүүд Б.Буяндэлгэр, Д.Гангабаатар, Л.Өлзийсайхан, Э.Энхтуяа.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Мөнхцэцэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбат Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцод нэгдэн орсонтой холбогдуулан түүнд заасан хариллах хууль тогтоомжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “Цагдаагийн албан хаагчид дараах зүйлийг хориглоно.” гээд 69.1.8 дахь заалтад “нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах дэмжлэг үзүүлэх” гэж заасны “... үйлдвэрчний эвлэлийн ...,” гэсэн нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхлын үүднээс олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэн нэгдэх эрхтэй ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “Цагдаагийн албан хаагчид дараах зүйлийг хориглоно.” гээд 69.1.8 дахь заалтад “нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүн дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх” гэж заасны “... үйлдвэрчний эвлэлийн ...,” гэсэн нь Монгол Улсын үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 10 дахь

заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол ...-ын үүднээс ... олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.” гэснийг зөрчигдсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн байнгын хорооны санал, дүгнэлтийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 57,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя санал хураалт тогтоолыг баталъя 55,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг тараасан байгаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.25 цаг.

Дараагийн асуудалд орно. Байнгын хороо хуралдчихсан уу. Дархан цаазтай газарт авах асуудал. Бейсен гишүүнийг дагуулж очоод Үнэнбат санал бүртгүүлчих.

Дараагийн асуудал цаадах чинь Бейсен гишүүн. Сайн байна. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдаж, нөлөөлж болохгүй шүү.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн,

Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Малын гартай түүхий эдийг боловсруулдаг үйлдлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэрчний бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ганболд хэрэгжих хугацааг ердийн журмаар хэрэгжүүлэх мөн тогтоолын төслийн хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс асуулт асуугаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Туваан, Энхтүвшин нар тогтоолын төслийг дэмжиж үг хэлсэн болно.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх

Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Бямбацогт гишүүнээр тасаллаа. Наянтайн Ганибал.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Батсуурийн Даваадалай Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх, Загджавын Мэндсайхан Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх, Жаргалсайханы Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, Мэндбаярын Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Цэрэнпунцагийн Амгалан тус яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Батбаярын Эрхэмбаяр тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Чойжилсүрэнгийн Эрдэнэбат Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал, Түгджавын Баярсайхан Арьс, шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал.

Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Мэдээж энэ

ХАА-н салбарыг олон жил урт хугацаатай хөгжүүлэх энэ бас тогтоолыг оруулж ирж байгаад бол бас дэмжиж байгаа. Гэхдээ аливаа тогтоол аливаа үйлдвэрлэлийг дэмжсэн шийдвэр болгон буцаагаад МАА-н салбар, мөн ХАА-н салбартаа бас нөлөөлдөг. Ер нь Монгол Улсын хувьд бол 2 үндсэн том салбар байгаа. Үүний 1 нь бол МАА-н салбар, нөгөө нь газар тариалангийн салбар. Тэгэхээр энэ 2 салбар бол Монгол Улсад яг өөрсдөө хөдөлмөрлөж, малчид маань, газар тариаланчид маань өөрсдөө хөдөлмөрлөж, энэ түүхий эдийг одоогийн хэллэгээр түүхий эд гэж хэлэх юм даа. Өөрсдөө бий болгодог. Хөдөлмөрлөж. Яах вэ тэр байгалийн баялаг бол газар доор байдаг. Тэгэхээр хүний хөдөлмөрлөж бий болгосон энэ бүтээгдэхүүнүүдийг дараа нь эцсийн бүтээгдэхүүн буюу хүний цууд хэрэглээнд аваачих гэж байгаа үйлдвэрүүд маань хамгийн зөв холбоотойгоор зохион байгуулахгүй бол хохирогч нар их гардаг. Монголын МАА-н салбар дээр малчид маань үндэсний хөнгөн үйлдвэрлэлийн золиос болж байгаа ийм тохиолдлууд бол их гарч байгаа. Сая газар тариалангийнхан дээр бас шийдвэр гарсан. Гурилыг гаднаас оруулж ирэх гээд үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжээгүй шийдвэр гарсан. Үүний дараагийн золиос нь бол манай тариаланчид байгаа. Тэгэхээр энэ 2 ингээд та хэдийн оруулж ирж байгаа юм. Мөн газар тариалан дээр гаргаж байгаа шийдвэрүүд гээд ингээд ийм нэг Монгол Улсад урт хугацааны бодлого байхгүй, түр хугацаагаар асуудлыг шийдэх гэж оролдож байгаа нэг ийм оролдлогын асуудлууд гарч ирээд байгаа юм. Ер нь аль ч үйлдвэрлэгч нар хамгийн хямдхан бүтээгдэхүүнээр өөрсдийнхөө бүтээгдэхүүнийг хийвэл илүү их ашиг орлого олно. Илүү их ашиг орлого олох зорилготойгоор гаргаж байгаа үйлдвэрлэлээ хамгаалсан олон тарифын болон техникийн мөн хөнгөлөлттэй зээлийн гээд энэ олон зохицуулалтууд нь буцаагаад түүхий эд үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгч нараа хохироохгүй байх нь л хамгийн чухал. Бид нар энэ дээр бол хэд

хэдэн асуудлууд байгаа. Сая арьс ширний асуудал бид нар энэ 10 жилийн хугацаанд энийгээ дахин сэргээж чадахгүй байсаар байгаад өнөөдрийг хүргэлээ. Сая ноолуур дээр бид нар бас яаран сандран шийдвэр гаргасан. Түүний бас золиосонд бас тодорхой хэмжээнд баруун аймгийнхан маань, малчид маань өртлөө. Тэгэхээр энэ бүх бодлогуудыг маш сайн судалгаатай хийх ёстой.

Г.Занданшатар: Судалгаагүй хийж байгаа гэж байна. Судалгаатай хийж байгаа юм уу. Хэн хариулах юм.3 номер. Батсуурийн Даваадалай.

Б.Даваадалай: Ганибал гишүүний асуултад хариулъя. Ялангуяа энэ цагаан алт үндэсний хөдөлгөөнийг энэ тогтоолыг оруулж ирэхэд бас салбарын яамдууд мэргэжлийн холбоодууд яг салбар салбарын ялангуяа энэ арьс нэхий, ноос, ноолуур гэсэн 3 салбар дээр бас нэлээн дэлгэрэнгүй судалгаа хийсэн. Тэгээд өнөөдөр бас ажлын хэсэгт судалгаан дээр ажилласан, манлайлж ажилласан хүмүүс бүгд ирсэн байгаа. Тэгээд нийтдээ яах вэ, ерөнхий мэдээлэл өгөхөд энэ салбарт 2,2 их наяд төгрөгийн санхүүжилт хийхэд үйлдвэрлэлээ 2 дахин нэмэгдүүлэх боломжтой гэсэн иймэрхүү урьдчилсан тооцоо гарч байгаа юм. Үүнийхээ 700 орчим тэрбум төгрөгийг улсын төсвөөс, үлдсэн 1.5-ыг банкны эх үүсвэрээс ашиглаад, тэгээд харьцангуй бага хүүтэй, тодорхой хэмжээгээр урт хугацаатай зээлийн санхүүжилтээр дэмжээд өгвөл бас нэг тодорхой үр дүн гарах болов уу гэсэн ийм ерөнхий тооцоонууд гарч байгаа. Зүгээр тооцоо судалгааны хувьд бол бас нэлээн Засгийн газраас гаргасан энэ хориооллыг дэмжих бодлого, дээрээс нь Их Хурал дээр яригдаж байгаа бусад хуулиудтай уялдуулах замаар ер нь үйлдвэрлэл чиглэлийг дэмжих чиглэлээр энэ тогтоолыг оруулж ирж байгаа юм гэсэн хариултыг танд өгье. Нэмэлт асуулт байвал бас лавлах зүйл байвал хариулъя гэж бодож байна.

Г.Занданишатар: Ганибал гишүүн 1 минут.

Н.Ганибал: Энэ манай малчдын өнөөдөр түүхий эдийнх нь үнэ, түүнийг борлуулаад зах зээл дээр гаргаж байгаа нийт үнэ нь өнөөдрийнхөө зах зээлийнхээ хэрэглээгээ дийлэхгүй болчихсон. Шууд утгаар нь хэлэх юм бол үр ашиггүй болчихсон. Хэрвээ бид нар эрсдэлээ даван туулъя гээд тэжээл бэлдээд жилийн 4 сар малаа тэжээхэд тэжээл авсан мөнгөө зарсан хүн нь нөхөж чадахаа байчихсан ийм МАА-тай болсон. Цаашидаа бид нар яг иймэрхүү байдлаар зөвхөн малчдын эрх ашгийг биш үйлдвэрлэлийнхээ эрх ашгийг нэгд тавиад байх юм бол цаашидаа бид нар МАА-н салбар дээр түүхий эд бэлтгэх тэр хүн чинь байхгүй болно. Тэр бүтээгдэхүүн чинь багасна л гэсэн үг шүү дээ онолоороо. Махан дээр бол нэн ялангуяа хамгийн хүндээр дуусаж байгаа. Ноолуур бол энэ зах зээлийнхээ жамаар явж байгаа ганцхан бүтээгдэхүүн. Бусад.../минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ тогтоолыг дэмжиж байгаа. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлээ дэмжих асуудал байгаа. Тэгэхээр харин ч жоохон оройтож орж ирэв үү гэж ингэж бодож байгаа. Тэгэхээр яг яс юман дээр Монгол улсад ер нь өнөөдөр хэн нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэл явуулж байна вэ гэвэл малчид явуулж байгаа юм. Юу гэж хэлэх гэж байна гэхээр хурга байдаг юм уу, тугал гараад л бие нь томрохынхоо хэрээр мах нэмэгдэж байгаа. Арьс сунаж байгаа, ноос ноолуур нь ургаад явж байгаа. Энэ үйлдвэрлэлийг эрхэлж байгаа, өөрөөр хэлбэл мини үйлдвэрлэл ЖДҮ-лэлийг жинхэнэ эрхэлж байгаа хүмүүс бол малчид. Тэгэхээр Монгол Улсад өнөөдөр хамгийн их нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүс нь бол малчид. Тэгэхээр малчид руу бас чиглэсэн нэлээн сөрөг зүйлүүд нэлээн яригдаад байгаа.

Юу гэхлээр малчдыг муулж байгаа юм. Малын тооны араас хөөцөлдөж байна л гэнэ, Малаа суурин болгосонгүй, МАА-гаа суурин болгосонгүй л гэнэ. Тэгэхээр яг яс юман дээр тэдний орлого талд нь бол доголдол гарчхаад байгаа юм. Ямар доголдол гэхээр тэдний үйлдвэрлэж бүтээсэн малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн үнэгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ өнөөдрийн оруулж ирж байгаа тогтоолын төсөл бол энэ малчдын бэлтгэсэн түүхий эдийг үнэ оруулах ажил учраас, асуудал учраас 2 гараа өргөөд дэмжиж байгаа юм. Бид нар энэ малчидтай маш их уулзаад явдаг. Ярьж байгаа ерөөсөө 2 асуудал тутмын нэг нь малын түүхий эдийг ярьж байгаа юм. Түүхий эд үнэгүй болчихлоо. Хог хаягдал болчихлоо, жалгын нэгээр хаягддаг боллоо гэж санаа зовж ярьж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг шийдэх Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд бид нар бол энэ улс төржихгүй шийдвэрлэх асуудлуудын дотор бол энэ малын гаралтай түүхий эдийн асуудлыг оруулах ёстой гэж ингэж би боддог.

Тэр улс төржилт гэдэг дээр нь тэр Дарханы арьс ширний цогцолборыг би ярьж байгаа юм. Хэн гэдэг хүн хийж байснаас нь болоод зогсоогоод, тас эсрэг үйлдэл хийгээд явчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр Монгол Ардын намын малчдын түүхий эд, Ардчилсан намын малчдын түүхий эд гэж байхгүй. Ганцхан Монгол малчдын махаа идэж бий болгосон түүхий эд байгаа. Тэгэхээр энэ салбар дээр бол бид хэд үүнээс хойш бас бодлогодоо оруулаад, улс төржихгүйгээр ингээд аваад явах ийм шаардлага байгаа юм. Дарханы арьс ширний цогцолбор гээд л ярьж байгаа юм. Залгуулаад л Эмээлтийнх гээд л ярьчихаж байгаа юм. Нэг ийм асуудлууд яриад байгаа. Энэ дээр хойшдоо анхаарна биз.

Тодорхой нэг асуулт асууя. Хөдөө аж ахуйн яамныхан байгаа байх. Энэ 6 төрлийн ХАА-н гаралтай урамшуулал байгаа. Энэ дотор арьс ширний, ноосны, хамгийн сүүлд орсон сарлагийн хөөврийн урамшууллуудын асуудал зогсох юм

яригдаад байгаа. Тэгэхээр энэ дээр зогсоохгүй биз дээ. Үргэлжлүүлнэ биз дээ гэдэг дээр нэг тодорхой хариулт авчихъя.

Г.Занданишатар: 4. Загджавын Мэндсайхан. Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн бодлогын зөвлөх.

З.Мэндсайхан: Туваан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ хөнгөн үйлдвэрийг дэмжих бодлого малчдын маань яг бий болгож байгаа тэр түүхий эдийг үнэ цэнтэй болгох, бодит үнэ цэн дээр нь авчрах, хөдөө аж ахуйн салбарыг үйлдвэрлэлтийн салбар дээр тулгуурлаж бүтээмжийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, цаашидаа бид нар малчдынхаа орлогыг нэмэгдүүлэх чиглэл дээр бодит арга хэмжээ болно энэ хөтөлбөр маань. Үүнтэй холбоотойгоор тэр малчдад олгогддог 6 төрлийн урамшуулал зогсохгүй. Харин илүү боловсронгуй болоод, цахим арилжаа буюу биржийн арилжааны системтэй уялдаад, малчид маань падаан бүрдүүлдэг биш, цаашидаа хэдэн ширхэг арьс, хэдэн тонн ноос, ноолуур үйлдвэрт тушаасан байна тэрнийхээ бүртгэлийн системийг дамжуулаад урамшууллаа аваад явдаг энэ боловсронгуй системийг энэ хөтөлбөрийн хүрээнд бас шийдэж өгөх юм байгаа юм. Үе тутам энэ жил бүрийн улсын төсөвт суугаад явж байгаа гэдгийг бас танд хэлье. Урамшууллын асуудал ол цаашидаа зогсохгүй.

Г.Занданишатар: Энэ асуулт нь ийм байгаад байгаа байхгүй юу. Асуудал нь. Сарлагийн хөвөрнийн урамшуулал өгнө гэсэн тэгээд малчид тэрийгээ авахгүй байна. Яаж авах юм бэ. Хөдөө аж ахуйн яам журам заавраа тодорхой болгоогүй байна. Сарлагийн хөвөрнийн. Ноосны урамшууллаа малчид аваагүй байна. Ингээд 2-ын хооронд урамшуулал өгч байгаа ч юм шиг, өгөөгүй ч юм шиг ингэж байхаар больчихооч ээ. Хэн нь аваад байдаг юм. Дунд нь аягүй бол ахиад цохиод байдаг юм уу гээд ийм асуултууд малчдыг асууж байна лээ л дээ.

Мэндсайхан. Хот хөдөөгийн бодлогын зөвлөх.

З.Мэндсайхан: Энэ малчдын хувьд энэ асуудлыг нэлээн хөндөж тавьж байгаа. Ноосны урамшууллын хувьд энэ сард багтаагаад улсын төсөв дээр бол урамшуулалд нь суучихсан байгаа. Сайдын багцад. Ноосны холбооноос энэ бүртгэлээ эцэслээд 2023 оныхыг энэ оны 6 сард нь багтааж олгохоор яам бол ажиллаж байгаа юм байна лээ. Сарлагийн хөвөрнийн үед урамшууллын тогтолцоо нь энэ жилээс эхэлж хэрэгжих юм байна лээ. Гарсан шийдвэрийнх нь хэрэгжилт нь энэ жил. Тэгэхээр ирэх оноос эхлээд олгогдоод явна гэсэн үг. Энэ оны эцсээс эхэлнэ.

Г.Занданишатар: Өнгөрсөн оныхыг аваагүй юм. Тэгээд энэ оныхыг оо ирэх оноос гэхэд яам тэгвэл заавраа гаргаагүй байгаа юм уу.

З.Мэндсайхан: Үгүй ээ, үгүй. Энэ оноос энэ хавар л сарлагийн хөвөр бэлтгэл нь орж байгаа байхгүй юу дарга аа. Тэгэхээр урамшууллынх нь тооцоолол нь одоо гарч ирнэ гэсэн үг.

Г.Занданишатар: Тэрийгээ тодорхой болгож малчдад мэдэгдэхгүй бол тийм эргэлзээтэй байдалд орчихсон асуугаад байна лээ шүү. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Ерөнхийлөгчөөс МАА-н бүтээгдэхүүнийг боловсруулалтыг дэмжих гэдэг бодлогын баримт бичиг орж ирж байгаад дэмжиж байгаа. Тэгэхдээ эндээс бас нэг сонирхолтой нэг зүйл харагдаад байгаа юм. Ерөнхийлөгчөөс удаа дараа ХАА-г дэмжих, боловсруулалтыг нь дэмжих, үйлдвэрлэлийг нь дэмжих гэдэг ийм бодлогууд удаа дараа орж ирж, тэр хүнс болоод бусад бүхий л салбарыг хамраад яваад байх шиг байгаа юм. Саяхан Засгийн газраас орж ирсэн газар тариалантай холбоотой, үр тариатай холбоотой бодлогыг та бүхэн санаж байгаа байх. Монголд тариа тарьж

бараг хэрэггүй. Гурил үйлдвэрлэж ч хэрэггүй. Үйлдвэрлэл ч хэрэггүй, гаднаас авчихъя гэдэг. Тэгэхээр ийм хууль өргөн барьж байгаа хүмүүс болоод та бүгд энэ дээр ямар байр суурьтай байгаа юм. Энэ бодлого чиглэлийн хувьд Монголын төрийн бодлого нийцээж байгаа юм уу. Нэг нь анхан шатны үйлдвэрлэлийг нь дэмжье, боловсруулалтыг нь дэмжье гэж нэг талаасаа бодлого орж ирээд том хөтөлбөр, заримыг нь хувьсгал гэдэг нэр бүхий том зүйлүүд яваад байх юм. Энийг Их Хурал дэмжээд, батлаад гаргасан. Нөгөө талдаа Монголд тэр ХАА-н бүтээгдэхүүн чинь үйлдвэрлэж хэрэггүй, боловсруулагдаж хэрэггүй, бэлнээр нь авчихъя, гурил хэлбэрээр нь авчихъя. Тэгэхээр энэ чинь нэг ийм бодлогын ялгаа энэ Засгийн газраас орж ирж байгаа Ерөнхийлөгчөөс өргөн барьж байгаа энэ 2 бодлогод чинь яагаад ийм их том ялгаа яваад байгаа юм бэ. Энэ дээр бас нэг хариулдаг, байр суурь илэрхийлдэг газар байвал бас хариулж өгөөч.

Тэгээд төгсгөлд нь сонгууль болж байна. Одоо үндсэндээ өнөөдөр ингээд чуулганы түр хаалт хийгдэх гэж байх шиг байна. Малчидтай холбоотой баахан л олон юм баталж байгаа. Ер нь аливаа ажил чинь өөрөө 4 жилийн, 8 жилийн Засгийн газрын үр дүн энд яригдаж байна. Тийм их бодлого, хөтөлбөр, цаас гаргаснаараа биш, яг тухайн иргэд дээр үйлдвэрлэгч дээр, бизнес эрхлэгч дээр ямар үр дүн очив гэдэг тэр үр дүн чухал. Одоо энэ 8 жилийн дараа эргээд харахад нөгөө арьс ширний боловсруулалт маань хаачив. Нэг л их гоё гоё юм боловсруулна, парк барина, тэнд ч парк барина, энд ч парк барина. Яг үнэндээ бүгд цаасан дээр. Нөгөө ноолуур гээд ярьж байна. Лав л 10-аад жилийн өмнө л 100 гаруй мянган төгрөг байсан. Тэгэхэд доллар одоогийн талаар л байсан. 100 гаруй мянгаар өгчихвөл хөөрхий малчдад баярлаад л явж байна. Бүх зүйл нь үнэгүй. Жилээс жилд хэрвээ валюттай харьцуулбал, үнэ ханишийн өөрчлөлттэй харьцуулбал жилээс жилд үнэ унаад байдаг. Сонгуулийн үндсэндээ 4 жилийн, 8 жилийн төгсгөлийн өдөр малчдыг

дэмжсэн гэсэн нэр бүхий асар олон хуулийг өнөөдөр батлаад, одоо сонгуульд гараад бүх юм ингээд гоё болно гээд л хэлээд л явах нь л дээ. Нөхцөл байдал. Ийм л харамсалтай л 4 жил, харамсалтай я бодит ажлын үр дүн ярих юм бол ширхэгчлэн хэдүүлээ ингээд тоолж болно. Тэр арьс, шир, ноос, ноолуур, юу байдаг юм мах шөл, сүү юу байдаг юм. Энэ дотор үнэ цэн нэмэгдсэн нэг ч зүйл байхгүй. Тэгэхээр ийм л бодлогын нэг ийм баруун, зүүн 2 гар нь эсрэг татсан ийм бодлогууд орж ирсэн. Засгаас орж ирж байгаа, Ерөнхийлөгчөөс орж ирж байгаа бодлогууд нь бие биеэ үгүйсгэсэн нэг ийм л нөхцөл байдлууд байгааг.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэлчихлээ дээ. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих энэ цагаан алт үндэсний хөтөлбөрийг дэмжиж байгаа. Малчдын орлогыг нэмэгдүүлмээр байгаа юм. Бид ерөөсөө малчдаа халамжилдаг, хайрладаг, орлого нэмэгдүүлэх талд нь анхаарахгүй явж ирсэн. Малчдын орлого нэмэгдээд арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн, яс тос, гэдэс гүзээ, цус, сэвс үнэ цэнтэй болчих юм бол малчид төр засгаас юм нэхээд байхгүй, хараад байхгүй. Энэ асуудлыг шийдэх гэж бас олон жил ярьсан. Сая бас Цогтгэрэл гишүүн хэлж байна. Олон парк ярьсан, Хэрэгжсэн зүйл байхгүй ээ гэж. Ганицхан парк хэрэгжиж байгаа. Ховд аймагт Баруун бүсэд шинэ Ховд үйлдвэр технологийн парк. Бусад Эмээлтийн парк байхгүй. Сайншандын парк байхгүй, Дарханы Аж арьс ширний парк байхгүй, цогцолбор бүгд царцсан зогссон.

Тэгвэл баруун бүсэд малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж 2017 онд баригдаж эхэлсэн. Одоо шиглалтад орох гэж байна. 2022 онд Үйлдвэр технологи паркийн тухай хууль

санаачилж, Их Хурлаар батлуулсан. 2023 оноос баруун бүсэд Ховд аймагт малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн дэд бүтцийг 50 гаруй тэрбум төгрөгөөр хийгдээд, бүтээн байгуулалтын ажил явагдаж байгаа. Энд баригдсан үйлдвэрээс гарч байгаа бүтээгдэхүүнүүдийг 10 жилийн хугацаанд татвараас хөнгөлөх, чөлөөлөх хууль хэрэгжээд эхэлчихсэн байгаа. Ийм байдлаар үндсэндээ малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих хууль батлагдсан. Энэ хууль дээр дутуу байсан нэг зүйл нь энэ үйлдвэрүүд барих гэж байгаа хувийн хэвшлийнхнийг дэмжих хөшүүрэг байхгүй байсан. Одоо энэ хөтөлбөр батлагдсанаараа тэр хувийн хэвшлийнхэн үйлдвэрүүд барина. Дэд бүтцийн тэр цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, зам талбай, хашаа хороо бүгдийг нь төрд бариад өгчихн. Тэр дээр хувийн хэвшлийнхэн үйлдвэрээ барина. Хувийн хэвшлийнхэнд үйлдвэр барихад нь хөнгөлөлттэй зээл өгөх гэж байгаа юм.

Тэгээд асуух гэж байгаа асуулт гэхээр энэ хөнгөлөлттэй зээл маань ямар хэмжээтэй байх вэ. Хэзээнээс өгч эхлэх вэ. Хэдий хэр удаан хугацаатай байх вэ. Зээлийн хүү нь хэд байх вэ. Энэ дээр тодорхой нэг хариулт өгөөч. Хувийн хэвшлийнхэн хүсэж байгаа.

Араас нь дахиад энэ хөтөлбөрийг дагаад бид нар бас зарим үлдсэн татваруудаас хөнгөлөх, чөлөөлөх асуудал үлдсэн байгаа. Энийг бас орж ирсэн байх гэж харж байгаа. Энэ дээр ямархуу байдлаар шийдье гэж шийдэл гарч байгаа вэ. Энийг бас нэг хариулаад өгөөч.

Ингээж бид нар бас малчдаа орлоготой болгохын тулд тэр жалганд хэвтэж байгаа хонины арьсыг, хог дээр үнэ цэнгүй болчихсон малын гаралтай түүхий эдийг үнэ цэнтэй болгох, малчдын орлого хамгийн багадаа 2-5 дахин нэмэгдэх боломж бүрдэнэ гэж

харж байгаа. Тэр ясаар нь тэжээл хийчихдэг, цусаар нь тэжээл хийчихдэг, хонины толгой шийр хүртэл хэдэн төгрөгийн үнэтэйг ард иргэд бас мэддэг болсон. Энэ дээр л бас нэг тодорхой юм хийж малын гаралтай түүхий эдээ л үнэ цэнтэй болгох. Шинэ хоршоо хөдөлгөөн бол малчдыг малаа эрүүлжүүлэх, малаа түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх талд нь бас анхаарч байгаа. Тэгвэл нөгөө талд нь бид нар малын түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг төрөөс иж бүрнээр нь дэмжсэнээрээ тэр боловсруулах үйлдвэрүүдтэй болж болох гэж байгаа юм. Тэгэхгүй бол нэг саалиа бэлдэхээр саваа бэлдсэн юм уу. Сааль нь бэлэн болчихсон байхад сав нь байхгүй байгаад байгаа юм. Тэгвэл малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг баруун бүсэд Ховд аймагт барьж байгаатай адилхан жишиг болгож энэ бүс нутаг бүрдээ дэмжмээр байгаа юм. Ингээж байж 70 сая малаас гарч байгаа түүхий эд маань хаягдахгүй, хог дээр хэвтэхгүй, малчид маань банканд зээлтэй биш, банканд хадгаламжтай, орлого нь хэд дахин нэмэгдсэн амьдрах бололцоо бүрдэх юм.

Тийм болохоор энэ дээр бас манай иргэдэд бас нэг тодорхой ойлголт мэдээлэл өгөх үүднээс ажлын хэсэг саяын зээлийн хүү нь хэд байх юм, хугацаа нь ямар байх юм, хувийн хэвшилд ямархуу нөхцөлөөр яаж олгох юм, хэзээнээс олгож эхлэх вэ энийг хариулж өгөөч.

Г.Занданшатар: Загджавын Мэндсайхан сайд хариулъя 4.

З.Мэндсайхан: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Энэ хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бодлого бол ерөөсөө шууд малын гаралтай түүхий эд болох ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн, сүү цагаан идээ гээд бүх бүтээгдэхүүнээ л бид нар зах зээлийн бодит үнэ цэнд нь хүргэх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нь дэмжлэг болгоно.

Гол асуудал бол яг шинээр үйлдвэр барих болон технологийн хөрөнгө оруулалт хийхэд нь зориулж илүү хөнгөлөлт үзүүлж, санхүүжилт гаргаж ажиллая гэж байгаа. Нийтдээ 1,5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг арилжааны банкнаас гаргая гэж байгаа юм. Нийтдээ эргэлтийн хөрөнгө 900 орчим тэрбум. Хөрөнгө оруулалтын чиглэлээр 610 орчим, 15 орчим тэрбумыг гаргана. Улсын төсөвт тодорхой үе шаттайгаар энэ төсөл маань 4 жил хэрэгжинэ. Улсын төсөвт 682 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс гаргахаар суулгаж өгсөн байгаа. Үүнээсээ зээлийн хүүгийн татаасанд 305 орчим тэрбум нь гарах юм байгаа юм. Эргэлтийн хөрөнгийн зээл буюу түүхий эд бэлтгэлийн зээлд зориулж гаргаж байгаа хүү зээлийн хүү маань 5 хувь, Засгийн газраас төлөх нь бол 12 хувь байя. Хөрөнгө оруулалтын зээл бол 6 хувийн хүүтэй байя гэдэг ийм урьдчилсан байдлаар арилжааны банкнууд бол Монгол банктэй зөвшилцөлцөж энэ хүүгийнхээ босгыг гаргаж ирсэн байгаа. Тэгэхээр энэ бол нөгөө шинэ хоршоо хөдөлгөөн дээр гарч байгаа малчдад олгож байгаа, хоршоологчид олгож байгаа зээлийн хүүтэй ижил хувьтай байгаа. Малчдад зориулаад сонгууль дөхлөө гоё, гоё юм гаргаж байна гэж. Энэ гоё юм гарах ёстой болоод л гаргаж байгаа л даа. Энэ хөнгөн үйлдвэрлэлээ дэмжиж, хөдөө аж ахуйн салбарыг бид нар босгож ирж, цаашидаа хөдөөгийн иргэдийнхээ, малчдынхаа бий болгож байгаа баялгийг үнэ цэнтэй болгохын тулд энэ хөтөлбөрийг санаачилж оруулж ирж байгаа. Бүх энэ хөтөлбөрүүд мэргэжлийн холбоод, мэргэжлийн байгууллагууд, салбарын яам болон энэ салбарын экспертүүдтэй хамтарч гаргаж, тооцоолол хийж гаргаж өгсөн хоорондоо уялдаатай хөтөлбөр байгаа гэдгийг бас хэлье ээ. Баярлалаа

Г.Занданишатар: Батсуурийн Даваадалай. 3 номер.

Б.Даваадалай: Нэмэлтээр бас зарим нэг мэдээллийг өгье гэж бодож байна. Ер нь энэ тогтоолын хүрээнд 4 асуудал шийдэх гэж байгаа юм.

1 дүгээрт эрх зүйн орчин. Тухайлбал нэг жишээ хэлэхэд манайд хөнгөн үйлдвэрлэл гэдэг тухайлбал ийм тухай хууль байхгүй. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын. Хөнгөн үйлдвэрлэл гэж юуг хэлэх юм гэдэг тал дээр бид нар үүнээсээ авхуулаад энэ салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах тал дээр анхаарах гэж байгаа юм.

2 дахь асуудал. Малын гарал үүсэл. Нөгөө малчдын гар дээрээс үйлдвэрлэгч хүрч шат дамжлага болгоныг мөшигөх тогтолцоог нэлээн оруулж ирж байгаа.

3 дахь асуудал бол малын эрүүл мэнд. Энэ дундаа ялангуяа био комбинатын асуудлыг бид нар бас нэлээн анхаарч байгаа. Малын эрүүл мэндийн асуудал дээр бас анх онцгой анхаарч байгаа.

4 дэх асуудал бол ерөөсөө энэ санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудал байгаа юм. Сая Мэндсайхан зөвлөх хэлчихлээ. Тодруулаад хэлбэл зөвхөн хөрөнгө оруулалт дээр гэхэд салбарынхантай зөвлөлдөөд үзэхэд ноолуур дээр ээрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалт гэхэд 200 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэдэг ийм тооцоо гарч байгаа юм. Ноосны угаах, самнах, ээрэх, сүлжих үйлдвэр дээр гэхэд 290 тэрбэм төгрөгийн гээд гэх мэтчилэн энэ тоонуудыг бас нэлээн ул суурьтай мэргэжлийн холбоодуудаас нь бас авч ийм хэмжээний санхүүжилт хийхэд үйлдвэрлэлийн хэмжээ 4 жилийн дараа 2 дахин нэмэгдэх ийм боломжтой гэж үзэж байгаа юм.

Түрүүн бас Цогтгэрэл гишүүн асууж байх шиг байна. Зөвхөн цаас болоод үлдэх үү гэж. Хүнсний хувьсгал дээр бас нэмэлт ямар үр дүнгүүд гарч байгаа талаар бас хэлье. Аль болох энэ тогтоолууд дээр үр дүнтэй болох тал

дээр нь анхаарч байгаа юм. Тухайлбал 2023 онд 832 тэрбум төгрөгийн зээл гарсан. Хүнсний үйлдвэр, хүнсний хувьсгалын хүрээнд. Хүнсний 11 шинэ үйлдвэр бий болсон. 800 ажлын байр бий болсон. Энэ салбарын нийт хүчин чадвар, үйлдвэрлэлийн хүчин чадал 7 орчим хувиар өсөх төлөвтэй байгаа гэх мэтчилэн бас тодорхой үр дүнгүүд гарч байгаа гэдгийг бас нэмэлтээр хэлье ээ.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Энэ чинь анхны хэлэлцүүлэг. Хэлэлцэх эсэх дээр үгээ хэлээд, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан юм.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

1.Тогтоолын төслийн 5 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд. Санал хураалт явуулна. Санал хураалт.

Адъяаа гишүүн дэмжихгүй л байгаа юм уу. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Саяын санал хураалт дээр дэмжиж саналаа өгсөн боловч эсрэг гарчихлаа төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр дахин санал хураалгах горимын санал гаргаж байна.

Г.Занданишатар: Энийг хасахгүй байж болохгүй юм уу? Хасахгүй төслөөрөө л үлдэнэ л дээ. Цаашаа явбал явах л юм байна. Ганболд гишүүн ээ, хасах юм уу энийг хасахгүй юм уу.

Идэрбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Ажлын байран дээр улс төржиж болохгүй. Үндэсний үйлдвэр дээр улс төржиж болохгүй. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Идэрбат гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн Хавсралтад тусгагдсан “Хэрэгжих хугацааг” доор дурдсанаар өөрчлөх:

“Хавсралтын 2 дахь хэсгийн 2.2.1 дэх мөрийн “2027” гэснийг “2028” гэж, 3 дахь хэсгийн 3.1.2 гэсэн мөрийн дараах “дугаарлаагүй” мөрийг “3.1.3” гэж дугаарлаж, уг мөрийн “2029” гэснийг “2028” гэж, 3.1.7 дахь мөрийн “2029” гэснийг “2028” гэж, 3.5.4 дэх мөрийн “2029” гэснийг “2028” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд. Санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Тэгээд сая бас манай Туваан гишүүн зөв хэллээ. Ер нь энэ үндэсний үйлдвэрлэлийн асуудлаар түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах асуудлаар улс төржиж болохгүй ээ гэж. Ерөөсөө ажилгүйдэл, ядуурал, ажлын байрны

тухай их ярьдаг. Ажилгүйдэл ядуурал юунаас болж байна ажлын байр байхгүйгээс болж байна. Ажлын байрыг хэн болгох вэ. Үндэсний үйлдвэрлэгчид бий болгож байна. Үндэсний үйлдвэрлэлээ дэмждэггүй ийм тогтолцоог л 30 жил ерөөсөө татвар, зээлийн бодлого бүх юмаараа унагааж ирсэн. Ийм учраас энэ үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж байж хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж байж ХАА-н үйлдвэрлэлийг дэмжиж байж малчид ч орлоготой болно, ард иргэд ч ажлын байртай болно. Үндэсний үйлдвэрлэл ч сэргэнэ, экспорт ч нэмэгдэнэ, импорт ч багасна, валютын ханиш тогтворжино, төгрөгийн ханиш, үнийн өсөлт ч саарна шүү дээ. Хамгийн үндсэн нь энэ малын гаралтай түүхийг эдээ боловсруулах энэ хөтөлбөрт байгаа шүү дээ. Энэ асуудлыг бол хаа хаанаа ингэж тууштай дэмжиж байж л энэ улс орон сэргэх юм байгаа юм.

Ингээд эцсийн зөвшилцөл нь дараагийн асуудалдаа орёе.

Улс төржихгүй гэсэн юм. Тэгээд ер нь хамгийн гол санаачилсан нь манай Тэмүүлэн, Гочоогийн Ганболд гишүүн, Бямбацогт гишүүн, Чинзориг гишүүн, Тогтохсүрэн гишүүн гээд ер нь хангайн бүсийн гишүүд, хамгийн гол дэмждэг хүн нь Жигжидийн Батжаргал гишүүн. Манай энэ төвийн бүсийн манай энэ ХАА-н асуудлыг бол маш тууштай явуулж байж манай Жигжидийн Батжаргал гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат нарын энэ хэдэн гишүүд л ХАА-г сэргээх, малчдыг дэмжих энэ олон хуулиудыг баталж байгаа юм даа манай Тэмүүлэн гишүүн байна.

11.57 цаг.

Ингээд “Улсын тусгай хамгаалалтын газар нутгийн ангиллын өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Содномын Чинзориг сайд танилцуулна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Байгаль орчны тэнцвэрт байдал, байгалийн унаган төрх, түүх, соёлын, үнэт өвийг хадгалах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол бүхий Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газар болгон улсын тусгай хамгаалалтад авахаар холбогдох судалгаа хийж үндэслэлийг боловсруулан танилцуулж байна.

Энэхүү тогтоолын төсөлд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газар болгохоор улсын тусгай хамгаалалтад авах суурь судалгаа үндэслэлийг шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран боловсруулж, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн холбогдох тогтоол, шийдвэрийг гаргуулсан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Байгал орчин, аялал жуулчлалын яамны цахим хуудсанд тогтоолын төслийг нээлттэй байршуулсан болно.

Булган уулыг дархан цаазат газар болгосноор байгалийн өвөрмөц тогтоц, унаган төрх, түүх соёлын дурсгалууд, ховор амьтан, ургамал гол мөрний урсгал бүрэлдэх эх, ойн сан бүхий газраар хамгаалагдах юм. Дархан цаазат газар болгосноор хамгааллын менежментийг Монгол улсын Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолын дагуу дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээтэй уялдуулан орон тоог тогтоох, цалингийн санд өөрчлөлт оруулах замаар Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа хариуцан

хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн болно.

Тогтоол батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 1995 оны “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” 26 дугаар тогтоол, тогтоолын холбогдох хавсралтуудад өөрчлөлт орох болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Та бүхнийг “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн 3.4-д байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлэлийг хангах, байгаль түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг

дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ гэж, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол Улс 2024 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 25 хувийг улсын тусгай хамгаалалтад авах зорилтод дэмжлэг үзүүлнэ хэмээн тодорхойлсон хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрын ангиллын дээшлүүлэн дархан цаазат газар болгон улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Тогтоолын төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-parliament.mn цахим сайтад байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооны саналаар “Улсын тусгай хамгаалалтын газар нутгийн ангиллын өөрчлөлтийг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг

үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гадаа байгаа гишүүд ороорой. Санал хураалт. Гадаа байгаа гишүүдийг оруулаарай. Энэ гишүүд хаашаа явчхаад байна. Асуудлаа батлуулахаар л гараад явчихдаг. Баруун жигүүрийн гишүүд хаачсан байна. Гишүүдээ оруулъя. Сүхбаатар гишүүн суудал асууя.

Байнгын хорооны саналаар “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Бат-Амгалан гишүүнээ суугаарай. Санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Их Хурлын дарга аа, миний карт дутуу орчихсон байж байгаад санал хураалтад дэмжсэн санал өгсөн тэнд гараагүй байна. Дахиж санал хураалгаад, хүчингүйд болгоод өгөөч.

Г.Занданишатар: Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна. Санал хураалт. Үгүй ээ, энэ дэлгэцэн дээр байгаа нэрийг яагаад таслаад байгаа юм бэ. Энэ дэлгэцэн дээр нэрээ дуустал гаргах ёстой шүү дээ. Энхтайваны Бат-Амгалан гишүүн.

Э.Бат-Амгалан: Би уг нь сая дэмжиж санал өгсөн юм. Энэ төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хурааж өгнө үү.

Г.Занданишатар: Сараа гишүүн ирлээ. Батлут гишүүн яачхав. Энхтайваны Бат-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Чиний карт уншигдаагүй байгаа юм болов уу. Бат-Амгалан гишүүн санал гарчхаад эсрэг л гараад байна даа. Карт чинь

уншигдаагүй байх шиг байна. Картаа сугалж байгаад дахиад уншуул. 51,3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ингээд горимын санал дэмжигдэж өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулна. Санал хураалт. Бат-Амгалан гишүүн ээ. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо шилжүүлж байна.

12.09 цаг.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо бас хуралдаж байна. Хөөе Чинзориг сайд хаачих нь вэ. Гишүүдийг дуудна шүү. 1 цагаас хуулийн төсөл эцэслэн батлах санал хураалт явуулна. 21 хууль, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн, дагалдуулж боловсруулсан 113 хууль хэлэлцэнэ. Засгийн газрын гишүүд бүгд байх ёстой шүү. 14 цагаас хуулийн төсөл эцэслэн батална. 14 цагт яг бэлэн байж байх ёстой шүү. Гялс та 3 орчхоод ир. Үгүй ээ, үгүй энэ танилцуулга явж байх хооронд эднийх зүгээр орчхоод л гараад ирэх юм.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Оюунчимэг алга байгаа учраас Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 28, 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус байнгын хороо Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу төрийн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу баригдсан нийтийн номын сан, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатын тусламж үйлчилгээ, боловсрол, соёлын болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай олон улсын стандартад нийцсэн барилга, байгууламжид ноогдох үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглалтад оруулах шийдвэр гарснаас хойш эхний 5 жилийн хугацаанд чөлөөлж болох зохицуулалт нэмэх зэрэг зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг Байнгын

хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд Нийслэлийн бүтээн байгуулалттай холбогдуулан Тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд багтаж буй газарт төсөл хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газар эрх зүйн зохицуулалтын хүрээнд Хууль, тогтоомжийн тухай хууль болон бусад хуультай уялдуулан хуулийн дагуу шийдвэрлэх боломж байгааг тэмдэглэж хэлсэн болно.

Мөн ажлын хэсгээс Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын нэг болох Хот, тосгоны өөрийн удирдлагын үйл ажиллагаанд баримтлах зарчимд 6.1.9 “төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих” гэсэн санал дэмжигдсэнтэй холбогдуулан Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны

танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сүхбаатар гишүүнд баярлалаа. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Байхгүй байна. Бейсен гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа би асуулт гэхээсээ илүү үг хэлье. Энэ өнөөдөр 2020-2024 оны парламентын чуулганы сүүлчийн өдөр. Энэ парламентын хугацаанд багтааж Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчилсэн найруулгаар оруулж ирж эцэслэн батлуулж байгаад юуны өмнө энэ хуулийг санаачилсан хотын удирдлагууд энд сууж байна. Мөн манай Хан-Уул дүүргийн Засаг дарга Алдаржавхлан, хотын дарга Нямбаатар түүний баг хамт олонд бас би Налайхчууд, Багануурчуудынхаа, мөн Орхон, Дархан хотын иргэдийн өмнөөс бас талархал илэрхийлмээр байгаа юм.

Энэ хотын асуудал олон жил яригдсан юм. Олон жил яригдаж, олон парламентын үед бие даасан хот болох асуудлыг ярьж ярьж энэ бүрэн эрхийн хугацаанд өнөөдөр ингээд эцэслэн шийдэх гэж байна. Мэдээж хууль батлагдах нэг хэрэг. Цаашид засаж залруулах, хуулийн хийдлийг нийцлийг хангуулах олон асуудлууд гарна. Тэрийг бол тухайн тухайн үед нь засаад явна гэж бодож байгаа. Тийм учраас Налайх, Багануур дүүргүүд улсын зэрэглэлтэй хот болсноор цаашидаа зүүн бүсэд бие даан хөгжих, улсын зэрэглэлтэй статус нэмэгдэх төсөв санхүүгийн бие даасан байдлыг хангах гээд олон эерэг давуу талууд гарах юм. Тийм учраас энэ бүрэн эрхийн хугацаанд бас энэ хуулийг санаачилж, хэлэлцэх асуудалд оруулж, хаврын чуулганы төлөвлөгөөнд оруулж ингээд үндсэндээ бас энэ хаврын

чуулгандаа багтааж баталж байгаа бас Улсын Их Хурлын гишүүддээ, Улсын Их Хурлын даргадаа бас талархал илэрхийлэх гэсэн юм.

Энэ бол Налайхчууд, Багануурчуудын хувьд өнөөдөр бас түүхэн шийдвэр гарсан түүхэн өдөр гэж би хэлж болохоор байгаа юм. Тийм учраас орон нутгаас сонгогдсон төлөөлөгч гишүүнийхээ хувьд бас орон нутгийнхаа ард иргэдийн нэрийн өмнөөс энэ парламентад бас 3 дүүрэгтэй холбоотой олон асуудлуудыг, ипотекийн 3 хувийн орон сууцын зээлийг, төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг гээд олон хуулиудад орон нутгийн алслагдсан байдлыг тусгасан хуулийн асуудлуудыг шийдэж өгсөнд бас талархал илэрхийлье. Тойргоос сонгогдсон гишүүний хувьд энэ дээр бас сэтгэл өндөр байна гэдгийг энэ парламентад хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан үг хэлье.

Ц.Туваан: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль орж ирсэн. Энэ дээр бол зайлиггүй амьдрал дээр шийдэх маш олон асуудлууд шийдлээ хүлээж байсан. Энэ бол үнэн. Тодорхой хэлэх юм бол энэ Дархан хотын Дархан-Уул аймгийн иргэдийн асуудал. Иргэд нь бол маш олуулаа хот болгож өгөөч, залуучууд нь хот болгож өгөөч ээ гэдэг асуудлыг тавьдаг. Яагаад вэ гэхээр энэ дээр 100-аас дээш мянган хүн амтай Монгол Улсын 3 том хүн амь суурьшсан суурьшлын 1. Тэгээд хажууд нь дахиад хажууд нь ч юу байх вэ, бараг дотор нь зэрэгцээд Дархан сум гээд нэг асуудал байгаад ингээд болохгүй байна гэдэг асуудлыг олон удаа тавьсан. Тэгээд энэ асуудал өнөөдөр бас Их Хурлаар орж шийдэгдэж байгаа, шийдэгдэх шийдлээ олсонд нь бол баяртай байна.

Дараагийн нэг асуудал нь энэ тосгодууд байгаа юм. Жишээлбэл төвийн бүс дээр гэхэд нийтдээ 7 тосгон байгаа.

Энэ дээр Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон, Хэрх тосгон гээд, тэгээд өөр Сэлэнгэд Шаамарын Дулаанхаан, Ерөөгийн Бугант гээд, Сайханы Номгон, Орхонтуулын Рашаант, Төв аймгийн Заамар дээр хүртэл Хайлааст гээд энэ хүмүүс юу ярьж байна гэхээр бид нарын энэ нэг ийм завсрын байдалтай байгаа байдал нь төрийн захиргааны үйлчилгээг тухайн тосгоны иргэд авч чадахгүй байна. Сургуулийн асуудал, эмнэлгийн асуудал, Засаг захиргааны төрийн үйлчилгээний асуудлуудыг авч чадахгүй байна гэдэг асуудлуудыг нэлээн тавьж ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар иргэдийн авах төрийн үйлчилгээ, төрийн захиргааны асуудлууд яг яаж шийдэгдэж байгаа тал дээр нэг товчхон хариулт авчихмаар байна. Юу юу нэмэгдэж байгаа юм гэдэг асуудал дээр.

2 дугаар асуудал нь бол Улаанбаатар хот Төв аймагт бүслэгдэн оршиж байгаа. Бид нар бүсчилсэн хөгжлийн бодлого их ярьж байгаа. Тэгсэн мөртөө дотроосоо энэ газар нутгийн маргаантай асуудлыг бол маш ихээр гаргаж ярьдаг. Улаанбаатар хотыг тойрсон 7 сумын асуудал энэ газар нутгийн маргаантай асуудал байгаа. Энэ асуудал дээр энэ хууль батлагдсанаар ямар шийдэл гарах юм бэ. Тухайлах юм бол энэ дээр жишээлэх юм бол Төв аймгийн Эрдэнэ сум Налайхын иргэдийн газрын асуудал давхардалтай 2 талаасаа олгоод явчихдаг. Үл хөдлөхийн болон гэрчилгээний асуудлаа авах боломж байдаггүй, ингээд иргэд хохироод байдаг. Яг ингээд 2 давхардалтай гэрчилгээ олгочихсон асуудал дээр бол нөгөө бизнесээ өргөжүүлэх, үл хөдлөхийн гэрчилгээгээ авах энэ асуудлууд орхигдоод ирдэг. Үүнтэй холбоотой яг адилхан асуудал Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг, Аргалант, тэгээд Баянчандмань, Батсүмбэр гээд энэ сумдууд дээр байгаа. Энэ хууль чинь батлагдсанаар энэ асуудлууд эерэг талдаа яаж гарах юм бэ

гэдэг нэг асуултыг бас товч авчихмаар байна.

Тэгээд ер нь бол энэ хууль батлагдсанаар Багануур, Налайх гээд яг энэ Төв аймгийн сумдуудтай хиллэж оршдог энэ асуудлууд байгаа. Иргэд нь одоо яг нуулгүй хэлэхэд нэг нь Төв аймгийн нутагт малаа маллаад нөхөр нь байж байдаг, эхнэр нь хүүхдүүдээ аваад бас сургууль соёл, эрүүл мэнд, төрийн үйлчилгээгээ авах гээд энэ Налайх, Багануур луу нэлээн орчихдог. Тэгэхээр энд байгаа хүмүүсийн төрийн үйлчилгээ авах энэ байдал дордохгүй байх гэж ингэж найдаж байгаа юм. Энэ хууль батлагдсана харин улам баталгаажсаад явчих байх гэж ингэж бодож байна. Тэгэхээр саяын асуусан 2 тодорхой асуултдаа хариулт авъя.

Г.Занданшатар: 3 номер. Сайнзориг. Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч хариулъя.

П.Сайнзориг: Туваан гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль нь бол анх бол 1993 онд батлагдсан ийм хууль байгаа. Үүнээс хойш нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал нэлээдгүй өөрчлөгдсөн. Эргээд энэ суурин газарт амьдрах иргэдийн үйл ажиллагааг зөв зохистой зохицуулах, эргээд энэ суурин газрууд бие дааж хөгжих энэ эрх зүйн статусаа зөв болгох юм бол бас тэнд байгаа иргэдийн нийгмийн болон төрийн үйлчилгээг авах тэр дэд бүтцийн үйлчилгээг сайжруулах энэ асуудал дээр бас онцгой байгаад байгаа юм. Тэгээд энэ удаагийн бас хууль дээр тосгоны асуудал бол үндсэндээ бие даасан зөвлөлтэй байна. Тосгоны Захирагчаа бол иргэд өөрсдөө сонгоод, төсвөө батлах, эргээд тухайн тэр засаг захиргааны нэгжээс шилжүүлж ирсэн чиг үүргүүд буюу анхан шат дээрээ тэр сум юм уу, аймгаас шилжүүлж өгч байгаа чиг үүргүүдийг би дааж хэрэгжүүлэх ийм бололцоо нь бол бүрдэж байгаа. Энийгээ бол бид нар бас тодорхой энэ хууль дээр бол

баталгаажуулж өгсөн гэдэг зүйлийг бас танд хэлье.

Тэгээд мэдээж бас тодорхой тооны өөрийн удирдлагын байгууллага бүтэц зохион байгуулалтын хувьд хуульд бас хот нийтийн аж ахуйгаа бие дааж авч явах ийм чиглэлтэйгээр тосгонууд цаашидаа хөгжинө гэж бид нар харж байгаа. Харин зүгээр энэ засаг захиргааны нэгжийн хоорондох тэр газар нутгийн хилийн цэсийн маргааныг бол энэ хуулиар шийдээгүй. Энэ бол цэвэр газрын тухай хуулийн асуудал байж байгаа. Энэ газрын хуулийг бас тодорхой болгоод тэр дээр нэг төвөгтэй зүйлүүд нь энэ нутаг дэвсгэрийн нэгжийн тэр орон нутгийн ИТХ нь саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж байдаг. Тэгэхээр аль аль орон нутгууд нь бол нэгдсэн саналд хүрэхгүй ийм нөхцөлүүд байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр Газрын тухай хуулийн юу гэдэг юм орон нутаг хоорондын маргааныг хэрхэн яаж шийдэх вэ, дүгнэлт гаргах вэ гэдэг зүйлүүдийг маш товч тодорхой болгоод бас цаашидаа Газрын хуулийг багц хуулийг өргөн барьж шийдэх байх. Өмнө нь бол Засгийн газрын өргөн барьсан Газрын тухай хуулиар бол уг асуудлыг шийдэхээр орж ирж байсан. Тэгээд Засгийн газраас бас дахиж татаж сайжруулах ажлууд байгаа гэж татан авсан байгаа. Тэгэхээр энийг бол цаашидаа бид нар бас илүү их анхаарч явна. Зүгээр тосгон болон хотын хувьд бол эдэлбэр газартай байгаа. Засаг захиргаа нэгжийн хэд хэдэн нэгжийг дамнасан байдлаар зохион байгуулж болно. Тэр нэгж дээр байгуулж болж байгаа. Тэгэхээр тодорхой түвшинд бол мэдээж энэ бүх зүйлүүдийг төлөвлөлтийн дагуу Улсын Их Хурал эцэслэн шийдэх ийм зохицуулалттай энэ хуулийн төслүүд бол гарч байгаа.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Энэ юу байгаа юм. Тэр мэдээж газар нутгаа багасгая гэж санал өгдөг төрийн захиргаа буюу сум байхгүй.

Тэгэхээр нөгөө талаас нь нэг нь ихэсгэе гэж байгаа юм шиг, нэг нь багасгая гэж байгаа учраас энэ асуудал чинь шийдлээ олохгүй. Тэгэхээр энийг нэлээн гаргалгаатай шийдэж өгмөөр байна. Энэ чинь ерөөсөө хууль дээр бараг шийдэхгүй гэж бичсэнтэй адилхан үг байхгүй юу. Мэдээж нэг сум байлаа гэхэд юу гэж л газар нутгаа бид нар багасгахыг Иргэдийн хурлаараа зөвшөөрч байна гэсэн шийдвэр гарах вэ дээ. Тэгэхээр энэ дээр дараа дараагийн юмнууд дээр маш сайн гаргалгааг нь заавал гаргасан юм яахгүй бол энд 2 талаас давхардаж газрын гэрчилгээ, газар олголт хийгдсэн иргэд чинь өнөөдрийг хүртэл маш олноороо хохирсоор байгаа шүү. Энэ тоо буурахгүй байгаа шүү гэдэг асуудлыг л анхаарахыг хүсье.

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоны талаар ярих гэсэн юм. 2200 хүн амтай, цэргийн ангитай, хуучин Цагааннуурын дамжлага бааз гээд байсан. Одоо энэ Цагааннуурын боомт тэр Цагааннуурын Улаан байшинтын боомт Цагааннуур тосгоны харьяа байдаг. Ирээдүйд ер нь бүсчилсэн хөгжлөөрөө үйлдвэрлэлийн бүс болох бүрэн боломжтой. Гэтэл энэ эрх зүйн байдлын тухай хуулиар зарим юун дээр нь буруу шийдсэн асуудал байгаа. Ногооннуур сумын харьяат болгочихсон. Тэгээд газрын асуудал наад зах нь хүүхэд төрлөө гэхэд гэрчилгээ авахад 60-аад километр газар яваад Ногооннуур сум руу явдаг. Энэ асуудлыг тусад нь болгож өгөхгүй бол яг тэр Цагааннуур тосгоны төвд нь Цагааннуурын чөлөөт бүсийн захиргаа нь бас байж байдаг. Энэ асуудлыг шийдэж өгөхгүй бол тэр газрын маргаан, малчдын асуудал, тэнд байгаа ард иргэдийн тэр төрийн үйлчилгээний асуудал нэлээн хүндрэлтэй байгаа. Энийг яаж шийдэх гэж байна. Тэр талаар энэ хуулийн төсөлд орсон уу тодорхой хариу өгөөч.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ. Нийслэлийн Засаг даргын орлогч Пүрэвжавын Сайнзориг хариулъя.

П.Сайнзориг: Бейсен гишүүний асуултад хариулъя. Тосгонууд маань бол бас тодорхой эдэлбэр газартай байгаа. Энэ өөрөө засаг захиргааны нэгж дээр буюу тэр Ногооннуур сум дээр жишээ нь тус тусад нь оришиж байгаа бол газар нутгийн хувьд тэр тодорхой бас хил хязгаарыг нь тогтоож өгсөн. Тухайн аймгийн ИТХ-аас тогтоож өгсөн эдэлбэр газар дээрээ байх юм. Тосгон өөрөө бас иргэдэд төрийн болон нийгмийн тэр суурь үйлчилгээг хамгийн түрүүнд ойртуулж өгөх нэгж болж байгаагийн хувьд тухайн тэр сум юм уу аймгаас шилжүүлж өгсөн тэр эрхүүдийг хэрэгжүүлж болох нөхцөлүүд нь энүүгээр бүрдчихэж байгаа юм. Тэгэхээр магадгүй энэ газрыг ашиглах эрхийг юм уу эзэмших эрхийг олгох, магадгүй бусад сум дээр аймаг дээр байдаг тэр эрхүүдийг тухайн тэр шийдвэр гарсан тохиолдолд бол тосгон хэрэгжүүлээд явах тэр бололцоог нь Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны өөрчлөлтөөр орсон тэр 57.10 дугаар зүйлд заасны дагуу тухайн засаг захиргааны нэгж дээрх хот тосгонд шилжүүлж өгсөн эрхүүдийг хэрэгжүүлэх бүрэн бололцоо нь энэ хуулиараа нээгдэж байгаа гэдэг зүйлийг би бас танд хэлье.

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүн тодруулах юм уу. Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Тэр Цагааннуур тосгоны захирагч нь захирамж гаргах эрхгүй. Ногооннуур сумын захиргаа нь гаргадаг болгочихсон. Аймгийн удирдлага нь энэ буруутай үйл ажиллагаанаас болоод наад зах нь гэрчилгээ авахад тийшээгээ явдаг. Тэгээд газрын маргаантай. Малчдын уг нь газар нь тусдаа газрын кадастрын зураг нь гарчихсан газар байхгүй юу. Урьд нь тэгж хэрэгжиж байсан юмыг ингээд ямар хуулийн цоорхойгоор нь ингээд яагаад хаячихдаг юм мэдэхгүй. Энэ талаар тэр хуулийн төсөлдөө тодорхой тусгаж өгөөч. Энэ

Цагааннуурыг онцолж ярьж байгаа маань ирээдүйд энэ чинь хуучин Цагааннуурын дамжлага бааз байсан шүү дээ. 4 том дамжлага байсан. Нефть бааз, мал бааз, бараа бааз, хангамж гээд баруун 5 аймгийг хангаж байгаа том төв байхгүй юу. Бараг сумын дайтай. Гэтэл энэ асуудлыг тусад нь шийдэж өгөхгүй бол энэ ард иргэд төрийн үйлчилгээг хүлээж авч чадахгүй. Нөгөө талаар Цагааннуурын чөлөөт бүс нь тэдний харьяанд байдаг ийм хүндрэлтэй асуудал байж байгаа юм. Энийг тодорхой тусгаж өгөөч гэж та бүгдээс хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүн ерөнхийдөө саналаа бас илэрхийллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Санал хураалтыг түр хойшлууллаа.

12.29 цаг.

Дараагийнхаа асуудалд оръё.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан төсөл байна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулан анхны хэлэлцүүлгийг 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хийлээ.

Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан Хот, тосгоны өөрийн удирдлагын үйл ажиллагаандаа баримтлах зарчимд 6.1.9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих зарчмыг нэмэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Нийслэлийн хэмжээнд нийгмийн суурь хэрэгцээнд шаардлагатай нийтийн зориулалттай дэд бүтцийг бий болгоход эрчим хүч 6,6 их наяд төгрөг, сэргээгдэх эрчим хүч 720 тэрбум төгрөг, дулаан хангамж 1,4 их наяд төгрөг, ариутгах татуургын хангамж 3,3 их наяд төгрөг, аюултай хог хаягдал, хүнсний хангамж, их багтаамжтай нийтийн тээвэр зэрэгт 2040 он гэхэд нийт 110,7 их наяд төгрөг шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоо гарсан бөгөөд уг зардлыг төсвийн эх үүсвэрээр шийдвэрлэх боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах практик хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгараад байгааг харгалзан хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөлд аймаг, нийслэлд тодорхой салбарын төр, хувийн

хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх эрх хэмжээг бий болгож, улмаар хэрэгжилтийг хангах үүднээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрхэд өөрчлөлт оруулахаар тусгасан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар аймаг, нийслэл нь өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн бүс нутгийн хөгжлийг дэмжих, улс орны нийгэм, эдийн засагт эерэг үр дүн үзүүлэхүйц тодорхой төслүүдийг тодорхойлж бие даан хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж, хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг мөн хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүнд баярлалаа. Байнгын хорооны

санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Сарангэрэл гишүүнээс асуух юм уу. Чинзориг гишүүн асуух юм уу. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ хууль маань ингээд чуулган дуусах энэ завсрын хугацаанд хэлэлцэгдэж байгаа болохоор жоохон гишүүд ач холбогдол бага өгөөд байх шиг байна. Уг нь их чухал хууль юм байгаа юм. Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд өөрчлөлт орсноор энэ нэгжид өөрчлөлт ороод байгаа, бие даасан хотууд бий болоод байгаа энэ хотуудад төр, хувийн хэвшлийн чиглэлээр ер нь ямар томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бололцоо боломж эрхийг өгч байгаа юм бэ гэж. Тэгэхээр ер нь бол энэ хууль хэрэгжээд цаг хугацааны хувьд хэзээнээс хэрэгжих юм. Ингээд эхлэхээр одоогийн байдалдаа бол дүүргийн Засаг дарга, дүүргийн иргэдийн Хуралд цаашидаа шилжилтийн үе яваад ирэх жилийн 6 сарын 1-нээс гэдэг юм уу хотын захирагч хотын зөвлөлүүд энэ эрхийг хэрэгжүүлээд шилжүүлээд явна тийм үү. Би тэгж ойлгож байгаа. Тэгэхээр одоогийн байдлаар та бүхэн нэг жишээ болгоод ийм томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бололцоо боломжуудыг бий болгож байгаа юм. Тэгэхээр ер нь баталгааг нь хэн гаргах юм. Баталгаандаа орон нутгийнхаа өмч юмыг барьцаалах энэ тэрээ асуудал бий болох уу, үгүй юу. Аль эсвэл бонд босгох эрх бий болж байна уу гэдгийг л нэг тодруулж өгөөч та нар маань.

Нөгөө талаар энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, дагасан хуулиудад өөрчлөлт орж байгаатай холбогдуулаад ер нь цаг хугацааг та бүхэн тодорхой хэлж өгөөч. 2025 оны 1 сарын 1-ээс ер нь аль хуулийн заалтууд хэрэгжиж эхлэх юм. Төсөв хөрөнгөтэй холбоотой заалтууд хэзээнээс хэрэгжих юм. 6 сарын 1-ээс аль хуулиуд хэрэгжих юм. 2028 оноос ер нь бол би энэ хуулийн бүрэн агуулгаараа 2028 оноос хэрэгжиж

эхлэх юм байна гэж ойлгож байгаа. Зөв үү, үгүй юү гээд. Ийм цаг хугацааны асуудлуудаар орон нутгийн иргэд их асууж байгаа юм. Ингээд өнөөдөр хууль батлагдчихвал ерөөсөө маргаашаас хэрэгжээд эхэлчих юм шиг ойлгоод байх шиг байгаа юм. Үгүй. Энэ намрын орон нутгийн сонгууль бол хуучин хуулиараа дүүргийн иргэдийн хурал, Засаг дарга нь томилогддоогоороо томилогдоод явна. Тэгээд төсөв санхүүтэй холбоотой асуудлууд нь хэзээнээс хэрэгжих юм. Төр, хувийн хэвшилтэй холбоотой энэ хуультай холбоотой заалт нь хэзээнээс хэрэгжих бололцоо боломжийг нь үүсгэх юм гээд энэ тал дээр нэг Сайнзориг дарга, Номинчимэг дарга, Цолмон дарга, Алдаржавхлан дарга эд нар хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Пүрэвжавын Сайнзориг дарга хариулъя.

П.Сайнзориг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль маань бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг л одоо амьдруулж, зохицуулалтыг бий болгож байгаа ийм хууль байгаа. Мэдээж томоохон суурь шинэчлэлүүд өөрчлөлтүүд явж байгаа учраас бас шууд батлаад маргааши хэрэгжих боломжгүй. Энэ хууль маань бол 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс бол хэрэгжиж эхэлнэ. Төсөв, санхүү болонтодорхой засаг захиргааны нэгжийн чиг үүрэг шилжүүлэх асуудлууд нь бол 2026 оны 1 дүгээр сарын 1 буюу яг төсвийн цаглавартайгаа нийцүүлж шилжүүлэхээр ингэж орж байгаа. Ер нь алсдаа бараг хотын зөвлөлийн мөн чанараараа иргэд бас зөвлөлөө сонгох энэ сонгууль бол 2028 оноос бол жигдэрч явна гэсэн ийм цаг хугацааны дэс дараалалтайгаар энэ шилжилтийн асуудлуудыг бид харж, энэ хуулийн төсөл дээр тусгасан. Бас энэ хуультай дагаад бас чухал орж байгаа Төр, хувийн хэвшлийн түншилэлийн хууль бол нийслэл

бол улсын төсвөөс сүүлийн 3 жил дараалан санхүүгийн дэмжлэг аваагүй. Өөрөөр хэлэх юм бол бие дааж хөгжиж байгаа, өөрсдөө санхүүгийн эдийн засгийн хувьд бие дааж байгаа. Эсхүл 100 мянга түүнээс дээш хүн амтай аймаг дараах салбарт түншлэлийг хэрэгжүүлж гэж байгаа юм. Энэ нь эрчим хүч, дулаан, хог хаягдлын менежмент, гадаргын ус, саарал усны барилга байгууламжийн менежмент, цэвэр бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, хурдны зам, багтаамж ихтэй нийтийн тээвэр, тээвэр ложистикийн төв, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангаж чиглэсэн барилга байгууламж, 100 тэрбум төгрөг, түүнээс дээш өртөгтэй түншлэлийн гээд ийм чиглэлүүдээр орон нутгуудад бие дааж бас эдийн засгаа авч явах, хотуудад бие дааж авч явах энэ нөхцөл байдлыг нь бүрдүүлж өгч байгаа.

Энэ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бүх зүйлүүдийг шийдвэрлэх боломжгүй байгаа. Энэ хотын гэдэг юм уу суурин газруудын асуудлуудыг. Ийм учраас энэ дээр зөв үнэ тарифын бодлого буюу зарим зохицуулалтуудыг үнэ тарифыг чөлөөлж үе шаттай чөлөөлж өгөх юм бол хувийн хэвшил хөрөнгө оруулалтаа хийх энэ дэд бүтцийн салбаруудыг бас жоохон либералчлах бодлого бас үүний цаана явж байгаа. Энэ дээр хувийн хэвшилд хөрөнгөө оруулаад нөгөө талдаа хэрэглэгч нь байгаа ийм салбаруудад хувийн хэвшил бас хөрөнгө оруулалтаа нөх өгөх бололцоо байна гэж бид нар бас харж байгаа учраас эдгээр хуулийн төслүүдийг оруулж ирсэн. Энэ дээр хотод шаардлагатай инженерингийн дэд бүтцийн асуудлуудыг л шийдэх хамгийн том зорилго тавьж байгаа гэж хэлж болно.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. Нэмэлт хариулт авах уу. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд нэмж хариулъя.

Н.Энхболд: Энэ хууль бол Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дэмжигдсэнтэй холбогдож гарч ирсэн. Өөрөөр хэлбэл Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дэмжигдэхгүй бол энэ хууль байхгүй гэсэн үг 1 дүгээрт.

2 дугаарт сая Сайнзориг даргын хэлсэн тэр төслүүд дээр арга хэмжээнүүд хэрэгжинэ. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар яаралтай энэ журмаа гаргах ёстой байгаа юм. Тэр журмаа маш яаралтай гаргавал энэ хууль өөрөө Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль батлагдсан өдрөөс эхлээд хүчин төгөлдөр болно. Журмаа яаралтай гаргачихвал одоо 2025 оны төсөв дээр санал яваад эхэллээ шүү дээ. Тийм ээ. Тэгээд тэр төслүүд тэр төслүүдээ тэр журмын дагуу одоогоос ингээд оруулаад явбал тухайлбал зарим асуудлууд нь бид нарын ойлгож байгаагаар 2025 оноос эхлээд хэрэгжиж болох ийм л бололцоог нээж өгч байгаа юм. Хэрэгжих хугацаа нь бол хамт батлагдсан өдрөөсөө явна. Тэрийг нь ашиглаад Засгийн газар бушуухан журмаа гаргаад, одоо 2025 оны төсөв ярьж эхлэхдээ л энэ зүйлүүдийг холбогдох салбаруудын хот, тосгоны төсвийн төслүүдэд улсаас юу нь юм, орон нутаг өөрөө юу юм, хамтарсан юу байх юм гэдгээ нарийвчлаад тусгаад явах хэрэгтэй юм байгаа юм. Тэгж ойлгож болно тийм ээ, Сайнзориг оо. Тэрийг бүр зориуд тодруулж хэлж байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах ёстой. Гэхдээ энэ юу юм байна Энхболд дарга аа. Энэ нөгөө холбогдуулан боловсруулсан учраас өмнөх Хот, тосгоны хууль батлагдаагүй учраас санал хураалт явуулах боломжгүй юм байна шүү дээ. Тийм ээ. Санал хураалт нь явагдаагүй учраас. Тийм учраас санал хураалтыг хойшлууллаа.

Дараагийнхаа асуудалд оръё.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийг гүйцээн босгох чиглэлийг хуралдаанд даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан I зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж,

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй санал болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг гишүүнд баярлалаа. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу. Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй I саналын томъёолол байгаа. Уг санал хураалтыг түр хойшлууллаа.

12.43 цаг.

Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганболд нарын 6 гишүүнээс 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их хурлын гишүүн байна уу. Байхгүй байна. Монгол Улсын засаг

захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

12.45 цаг.

Дараагийнхаа асуудалд оръё.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Адьшаа нарын 4 гишүүнээс 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд

нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу. Байхгүй байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжжүүлээ.

12.46 цаг.

Дараагийнхаа асуудалд орёё.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV дугаар хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг хэн танилцуулах вэ. Засгийн газар танилцуулах ёстой. Хэлэлцэх асуудалдаа орно шүү. Гишүүд байж байгаарай.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV дугаар хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье. Хууль санаачлагчийн илтгэлийг Соёлын сайд Чинбатын Номин танилцуулна.

Ч.Номин: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай 1940 оны конвенц нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага бүрийн эрх ямба, дархан эрхийн асуудлуудыг зохицуулдаг бөгөөд Монгол Улс уг конвенцыг 1970 онд соёрхон баталсан.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1974 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын статусыг олгож, улмаар дээрх конвенцын XV дугаар хавсралтаар түүний эрх хямд дархан эрхийг шинээр баталгаажуулжээ.

Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1979 онд гишүүнээр элсэн орж, уг байгууллагатай идэвхтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн хэдий ч Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцыг 1974 онд орсон XV дугаар хавсралтыг нэмэлтээр соёрхон батлаагүй байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV дугаар хавсралтыг соёрхон баталснаар 1 дүгээрт Монгол Улс суурь конвенцуудын дагуу 1970 онд хүлээсэн үүргээ биелүүлэх, 2 дугаарт Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон түүний Монгол Улс дахь үйл ажиллагааг аливаа саад тотгоргүй илүү идэвхтэй өрнөх эрх зүйн суурь тавигдана. Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Номин сайдад баярлалаа. Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн зөвшилцөх, хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV дугаар хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасныг баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх төслийг дэмжиж, соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV дугаар хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Соёлын сайд Чинбатын Номин, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Жамбалдоржийн Соёлмаа, Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн газрын дарга Сумъяагийн Урангэрэл.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Эцэслэн батлах санал хураалт 39-өөс дээш гишүүнээр явуулах учраас үдээс хойш 14 цагт санал хураалт явуулна.

Санал хураалтыг 14 цаг болохоор хойшлууллаа.

12.54 цаг.

Дараагийн асуудалд орно.

Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА /Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлах эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Соёлын сайд Чинбатын Номин танилцуулна. Индэрт урьж байна.

Ч.Номин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд соёрхон батлахаар заасан. Хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон Соёлын эд зүйлийн тухай ЮНИДРУА-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Энэхүү конвенц нь хулгайлагдсан эсвэл хууль бусаар хилээр нэвтэрсэн соёлын эд зүйлийг эгүүлэн олгох болон буцаах талаар хувийн эрх зүйн хүрээнд улс хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөнгөвчлөх чиглэлд олон улсын эрх зүйн баримт бичиг юм.

Конвенц нь 5 бүлэг 21 зүйл, хавсралтаас бүрддэг бөгөөд өнөөдрийн байдлаар дэлхийн 54 улс конвенцод нэгдэн ороод байна. Хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийн тухай ЮНИДРУА-ийн конвенцод Монгол Улсын 1991 онд нэгдэн орсон Юнескогийн 1970 оны соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг

шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенцын дутуу эсхүл зохицуулагдаагүй үлдсэн зарим асуудлыг нарийвчлан тусгаж өгснөөрөө онцлог юм. Тухайлбал, хулгайлагдсан эсвэл хууль бусаар хилээр нэвтэрсэн эд зүйлийг нэхэмжлэх хугацаа, уугуул оршин суугчдын соёлын эд зүйлийг өмчлөх эрх, нөхөн төлбөр олгох нөхцөл, өмчлөх эрхийг тодотгох үйл ажиллагаа зэргийг нарийвчлан тусгасан байдаг.

Конвенцыг соёрхон баталснаар Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд хугацааны хөгжлийн бодлого болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалд соёлын өвийг хууль бус худалдаатай тэмцэх заасан зорилт арга хэмжээний хүрээнд соёлын эд зүйлсийг эгүүлэн олгох болон буцаах чиглэлд бусад улстай хамтран ажиллах боломжийг өргөжүүлэхээс гадна олон улсын эрх зүйн хүрээнд соёлын өвийн хууль бус худалдаатай үр дүнтэй тэмцэх урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин боловсронгуй болно гэж үзэж байна.

Конвенцыг соёрхон баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн хүрээнд сөрөг үр дагавар гарахгүй ба шинээр өөр хууль боловсруулахгүй бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй эсхүл хүчингүй болгохгүй болно. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн конвенцыг соёрхон батлах тухайн

төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасныг баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хууль санаачлагчаас хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан соёлын биет өв, бурхан шүтээн хулгайлах, хууль бусаар худалдах гэмт хэрэг буурахгүй байгаа болон түүх дурсгал, соёлын өв хадгалагдсан газар, хадны сүг зураг, бичээстэй газруудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Соёлын яам онцгой анхаарч Соёлын багц хуульд тусгах нь зүйтэй талаар үг хэллээ.

Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Санал хураалт Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай

хуульд заасны дагуу нийт гишүүдийн олонхоор шийдвэрлэх учраас тохиромжтой цаг хугацаанд санал хураалт явуулах дэгтэй.

Ажлын хэсгийн гишүүдийг протоколд тэмдэглүүлье. Чинбатын Номин Соёлын сайд, Бямбасүрэнгийн Даваацэрэн Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Соёлын яамны Хууль, эрх зүйн газрын дарга Содномжамцын Батцэцэг. Ажлын хэсэгт баярлалаа.

Санал хураалтыг 14 цагт явуулна. 14 цагт гишүүдэд зарлаарай. 14 цагт хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалттай.

14.59 цаг.

Дараагийн асуудалд орно.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд танилцуулна. Раднаасэд гишүүнийг индэрт урьж байна.

Ш.Раднаасэд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Занданшатар, Тогтохсүрэн, Учрал, Цогтбаатар нарын 2024 оны 5 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмыг баримтлан Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн шүүхийн цахимжилт, мэдээллийн аюулгүй байдал, программ хангамжийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Адьшаа Улсын Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн академи, түүнийг ажиглах, харьяаллын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараан хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Дашдоржийн Мөнхтуяа Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн

танхимын тэргүүн. Алга байна. Батцэрэн алга байна. Баярмаа алга. Лхагвадоржийн Энхбилиг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Цэвээнсүрэнгийн Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, Навагчамбын Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Доржготовын Ариунтуяа Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Содномцэрэнгийн Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Даваагийн Баянжаргал Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, Цоодолын Батболд Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийг хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Баатарсүрэнгийн Оюунгэрэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга, Дашпунцагийн Эрдэнэчимэг Улсын дээд шүүхийн Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал, Жаргалсайханы Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Даваадоржийн Бөхчулуун Улсын ерөнхий прокурорын газрын Бүртгэл мэдээллийн технологийн албаны ахлах прокурор, Лхагвын Данзанноров монголын өмгөөлөгчдийн холбооны тэргүүн.

Гишүүд асуулт, хариултгүй. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Харин дундын сайн хувилбар болоод бас шийдлээ гарчихсан байна лээ. Нөгөө 5 дугаар зүйл дээр. Тэгээд тэр асуудлаар 14 цагт санал хураалт явуулна. Ажлын хэсэгт баярлалаа. 13 цаг болсон учраас. 14 цагаас нэгдсэн санал хураалтууд явуулна. Санал хураалтын цаг 14 цагт гишүүд бүгд бэлэн байна шүү. Одоо 2 Байнгын хороо хуралдаж байгаа. Танайх хуралдсан уу.

13.04 цаг.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Н.Учрал, Д.Цогтбаатар нарын гишүүд 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг баримтлан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хорооноос боловсруулан 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Төсөлд нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудас эсхүл шүүхийн нээлттэй бусад платформд байршуулах, цаасан баримтыг цахим баримтаар хөрвүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах шүүх хуралдааныг шууд нэвтрүүлэхэд шаардлагатай программ хангамж, техник, тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой цаг хугацаа шаардлагатай.

Мөн шүүгчийн зэрэг дэвтэй холбоотой асуудлыг зохицуулахад шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг дараа жилийн төсөвт тусгах зэрэг асуудлыг харгалзан үзэж тэдгээртэй холбоотой хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслөөс ялгаатай тогтоох нь зүйтэй гэж үзэж уг хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Ганбат нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг хүсье.

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Байнгын хороо анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах буюу эхний хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасан байгаа. Санал хураалтыг 14 цагт явуулна. 14 цагт санал хураалтын

цагтай. Гишүүд Байнгын хороодын хурал завсарлаад цуглах ёстой.

Энхбилиг дарга аа, ер нь байна шүү дээ. Шүүхийн хэрэг болгон чинь өөрөө нэг case study байгаа байхгүй юу. Жишээ дээр суралцах жишээнүүд. Тийм учраас Банглорын зарчим чинь ер нь шүүгчийн сургалт бол тэнчээнээ тэр кэйс дээрээ суралцах зарчим дээрээ тулгуурлаж яваад байгаа юм. Үндсэн зарчимтайгаа л нийцүүлэх гэж байгаа юм тэр зарчимд. Тэгээд сая бол ингээд дундын хувилбар чинь ер нь зөв байх. Ингээд 14 цагт санал хураалт явуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

13.07 цаг.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 17 гишүүнээс 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Малчны тухай

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Туваан, Ганибал нар асуулт асууж, санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Цэвэгмидийн Мөнхнасан тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн. Асуулт алга байна.

Ингээд Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

13.11 цаг.

Дараагийн асуудалд оръё.

“Улсын тусгай хамгаалалтын газар нутгийн ангиллын өөрчлөлтийг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Тус Байнгын хороо тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Монгол

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Байнгын хороо “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасан байна. 14 цагт санал хураалттай Байнгын хороо дууссаны дараа. Санал хураалтыг 14 цагт болгож хойшлуулж байна.

13.13 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас зарчмын зөрүүтэй 1 саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримтлан уг саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны

эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна.

Г.Занданишатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна.

Ажлын хэсэг Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Бямбын Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Сандагийн Батхуяг Мал эмнэлгийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүн байхгүй байгаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Санал хураалтыг 14 цагт явуулна. Ажлын хэсэгт баярлалаа. 14 цагт Байнгын хороо дуусахаар санал хураалтад бэлтгэнэ.

13.16 цаг.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд

нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы нэгдсэн хуралдаанаар Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн холбогдох заалт дэмжигдсэнтэй холбогдуулан бусад хуультай нийцүүлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ц.Идэрбат, Ц.Туваан нар төслийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын

зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаар асуулт алга байна.

Тэгээд энэ хуулийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжих санал хураалт явуулна. Санал хураалтыг 14 цагт явуулна.

Байнгын хороод хуралдаж байгаа учраас 14 цагт санал хураалтын цагтай. Шинэ дэгээр.

13.19 цаг.

Дараагийн асуудалд орно.

Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлэлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны тайлан, санал,

дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хянан шалгах түр хорооны тайлан болон санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 25 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийлээ.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь 11,1 мянга гаруй хуудас баримт материалыг нотлох баримтаар цуглуулж, 1 сар гаруй хугацаанд хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулан, нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2024 оны 5 дугаар сарын 29-өөс 30-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд сонсголын үр дүнд үндэслэн дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

1.Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох бүртгэх үйл ажиллагааны талаар:

1/1.1997-2023 оны хооронд нийт ашигт малтмалын хайгуулын 14,299 тусгай зөвшөөрлийг олгосон байна. Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон газар 6.930,6 мянган га талбайд хүчин төгөлдөр 2767 тусгай зөвшөөрөл, үүнээс 1731 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 1036 хайгуулын тусгай зөвшөөрөл бүртгэлтэй

байна. Нийт тусгай зөвшөөрлөөр олгосон газар нь Монгол Улсын газар нутгийн 4,5 хувийг эзэлж байна. Ашигт малтмалын тухай хууль 1994, 1997, 2006 онуудад шинэчлэн батлагдаж байсан бөгөөд өнөөдөр 2006 онд батлагдсан шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж байна. 2006 оноос хойш Ашигт малтмалын тухай хуульд нийтдээ 43 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Ашигт малтмалын тухай хуулиар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг Засгийн газрын тогтоолоор болон хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар цахим хэлбэрээр зохион байгуулж олгож байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам, Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар баталдаг. Хамгийн өндөр үнийн санал өгсөн тохиолдолд 70 хүртэлх оноогоор үнэлж байгаа нь геологи хайгуулын мэргэжлийн аж ахуйн нэгжүүдийн ажлын туршилага, техникийн хүчин чадал, мэргэжлийн ур чадварыг үнэгүйдүүлсэн, тусгай зөвшөөрлийг арилжааны хэрэгсэл болгох үндсэн шалтгаан нөхцөлийг бүрдүүлж байна гэж дүгнэсэн.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцоод хамгийн өндөр үнийн санал өгч шалгарсан аж ахуйн нэгж зөрүү төлбөр төлөхгүй, тусгай зөвшөөрөл авахгүй орхиж явах тохиолдол нийтдээ 68 удаа гарсан бөгөөд энэ нь тухайн талбайд явагдсан сонгон шалгаруулалтыг хүчингүй болгох, хууль бусаар ашигт малтмал олборлох зорилгоор уг талбайг эзэнгүй байлгах гэсэн санаатай үйлдэл байж болохоор байна.

Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай давхцуулан ашигт малтмал хайх, олборлох тусгай зөвшөөрөл олгохыг хориглодог хуулийн зохицуулалттай. Нотлох баримтаар газрын удирдлагын системд бүртгэлтэй Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын мэдээллээр

нийтдээ 1094 нэгж талбарын 184,7 га газартай хайгуулын тусгай зөвшөөрөл, нийт 2151 нэгж талбарын 191,9 га талбай газартай ашиглалтын тусгай зөвшөөрөл давхцалтай байна гэж тогтоогдлоо.

Байгууллага хооронд мэдээлэл солилцох хамтын ажиллагаа хангалтгүй, төрийн байгууллагуудын хууль тогтоомж мөрдөөгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж нийтдээ 3245 иргэний газар өмчлөх эрх нь зөрчигдсөн. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хууль зөрчигдөхөөс гадна Газрын хэвлийн тухай хуулийн 20.3, Газрын тухай хуулийн 31.3, Ашигт малтмалын тухай хуулийн 14.1, 24.4.2, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 6.1.1 дэх заалтууд тус тус зөрчигдсэн байсныг тогтоолоо.

Улсын тусгай хэрэгцээний болон хуулиар хориглосон бусад газарт ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглодог хуулийн зохицуулалттай. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай байдлын талаарх мэдээлэл зөрүүтэй байна.

Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн давхцалтай газар нутгийг дараах байдлаар ангилан дүгнэсэн. Үүнд Ашигт малтмал, газрын тосны газрын ирүүлсэн мэдээллээр тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай 40 ашиглалтын, 1 хайгуулын тусгай зөвшөөрөл байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай 19 ашиглалтын тусгай зөвшөөрөл байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ирүүлсэн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай 22 ашиглалтын, 7 хайгуулын тусгай зөвшөөрөл байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн нотлох баримтад 53 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцалтай 97 түүх, соёлын дурсгалт газар, хайгуулын 115 тусгай зөвшөөрөлтэй давхцалтай 263 түүх соёлын дурсгалт газрууд байна.

Шинжлэх ухаан академийн археологийн хүрээлэнгээс нийтдээ 20 түүх, соёлын дурсгалт газрын 6 нь устсан, 6 нь дам эрсдэлд учруулсан, 8 нь нөлөөллийн бүсэд орсон баримтыг ирүүлсэн.

Соёлын яамнаас ирүүлсэн баримтаар 9 түүх, соёлын, үл хөдлөх дурсгалт газрын байришил нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан зөрчил байгааг түр сонсгол хороо илрүүлээ.

2.Тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх талаар:

Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь хуулиар эрх олгоогүй журам маягт баталж, Монгол Улсаас экспортолж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээг олгож байгаа үйл ажиллагааг таслан зогсоож, холбогдох мэргэжлийн байгууллагаас гэрчилгээг авах, түүнчлэн замын хуудас, тээвэрлэлтийн хуудсаар экспортолж байгаа ашигт малтмалын гарал үүсэлд хяналт тавих зайлиггүй шаардлагатай байна.

Хянан шалгах ажлын хүрээнд тогтоогдсон тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд үйл ажиллагаа явуулахгүй байгаа 1076 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нөөцгүй, нөөц дууссан, тодорхой ашиглалтын тусгай

зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа болон ашигт малтмал экспортолж буй этгээдүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтад уурхайн хаалтын асуудлыг байгаль орчны нөхөн сэргээлттэй холбон ойлгож ирсэн нь хаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хангалтгүй байна. Уурхайн хаалт, хаалтын дараах хяналт, хаасан уурхайг орон нутагт хүлээлгэж өгөх зэрэг асуудлуудыг цогц байдлаар зохицуулах ёстой. Тухайлбал, хаалтаа бүрэн хийсэн уурхайн талбайг ирээдүйд өөр зориулалтаар ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчин дутагдалтай байна.

3.Нийтийн захир нутгийн захиргааны байгууллагаас ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар олгож буй зөвшөөрөл, түүний хэрэгжилтийн талаар:

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу орон нутгаас олгосон нийт 498 тусгай зөвшөөрөл байгаагаас хайгуулын 359, ашиглалтын 139 тусгай зөвшөөрөл байна. Дундговь, Сэлэнгэ, Өмнөговь, Улаанбаатар хотуудад түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хамгийн их буюу нийт тусгай зөвшөөрлийн 44 хувийг эзэлж байна. Нотлох баримтаар ашигт малтмалын хайгуулын болон алт, нүүрс, жонш, төмөр зэрэг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн Дундговь аймагт 31, Өмнөговь аймагт 13, Сэлэнгэ аймагт 10, Төв аймагт 9 түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдсанаас хойш түгээмэл тархацтай ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн тоо

бүртгэл, түүний хөдөлгөөн баланс огт хийгдээгүй байна. Энэ нь Газрын хэвлийн тухай хуулийн 45.1 дэх хэсэгт ашигт малтмалын нөөц, орд, илрэлийг улсын нэгдсэн тоо бүртгэлд заавал бүртгэнэ гэж заасныг зөрчиж байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах нэрээр халхавчлан журамд зааснаас том оврын техник, хэрэгсэл ашиглах, нөхөн сэргээгдээгүй, эвдрэлд орсон талбайд үйл ажиллагаа явуулах ёстой байтал хөндөгдөөгүй эрүүл талбайд хөндөгдсөн гэх хуурамч материал бүрдүүлэн олборлох, санаатайгаар хууль бус олборлогч нарыг оруулж эвдрэлд оруулах зэрэг журмын хэрэгжилтэд нийтлэг алдаа, зөрчил нэмэгдэх хандлагатай байна.

Бичил уурхайн асуудлуудаар нотлох баримтыг шинжлэн судлахад бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалтууд нэгдсэн зохион байгуулалтад оруулж ажлын байр бий болгох, орон нутгийн төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх, бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах гэсэн анхны үзэл баримтлал нь дэвшиүүлсэн зорилтоо хангасан боловч цаг үе ач холбогдлоо алдсан байна. Иймд бичил уурхайн асуудлыг олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай байна.

4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлбөр, татвар ноогдуулах, тайлагнах, төлөх, хураах үйл ажиллагааны талаар:

Ашигт малтмалыг дотоодод борлуулахад баримтлах жишиг үнэ зарлагддаггүйгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн борлуулалтын орлогод үндэслэн АМНАТ ноогдуулж байгаа нь АМНАТ-тай холбоотой маргаан зөрчил үүсэх шалтгаан болж байна. Татварын ерөнхий хууль, Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу татвар төлөгч холбогдох хуулиар төлбөл зохих татварын ноогдлоо өөрөө тодорхойлж,

хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй. Гэвч 2022 онд 157, 2023 онд 129 аж ахуйн нэгж АМНАТ-ийн тайлангаа ирүүлээгүй байна. 2023 оны байдлаар бүтээгдэхүүн экспортлосон боловч Татварын албанд АМНАТ-ийн тайлан тайлагнаагүй 44 аж ахуйн нэгж байна. Үүнээс жоншны экспорт дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд нийтдээ 8,8 тэрбум төгрөгийн АМНАТ тайлагнах, төлөхөөс зайлсхийсэн үйлдэл гэж үзэхээр байна.

Ашигт малтмалын тухай хуулиар үүсмэл ордыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг байсныг аж ахуйн нэгж хоорондын гэрээгээр зохицуулдаг болсон нь үүсмэл ордын АМНАТ-ийг 2,5 хувиар ноогдуулж орлого буурах нөхцөлийг бий болгосон бөгөөд 6 аж хуйн нэгжид хуулиар давуу олгосон байна гэж үзэж байна.

Дагалдах ашигт малтмалын бүтээгдэхүүнд АМНАТ ноогдуулахдаа гаалийн лабораторийн дүгнэлтээр илэрсэн бүх төрлийн ашигт малтмалд ноогдуулж байгааг ашигт малтмалын хүдэр баяжмалын төрөл, ангиллаас хамааруулан эдийн засгийн хувьд үр ашигтай дагалдах ашигт малтмалыг тодорхойлж, түүнд АМНАТ ноогдуулах нь зүйтэй.

Татварын албанаас уул уурхайн компаниудад хийсэн хяналт шалгалтын 24,5 хувьд нь АМНАТ-тай холбоотой зөрчил илэрсэн байна. Сүүлийн жилүүдэд АМНАТ-тай холбоотой зөрчил нэмэгдэх хандлагатай байна. Тусгайлсан удирдамжтайгаар 85 татвар төлөгчид хяналт шалгалт хийхэд нийт төлбөр ноогдох суурь үнэлгээний 2,3 их наяд төгрөгийн зөрчил илрүүлсэн нь Татварын ерөнхий газраас ирүүлсэн нотлох баримтаар харагдаж байна. Өнөөгийн байдлаар татварын албанд хуримтлагдсануул уурхайн салбарын татварын нийт өр 3,3 их наяд, үүнээс 514 аж ахуйн нэгжид хамаарах АМНАТ-ийн өр 1,1 их наяд төгрөг байна.

5.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын ашиглалт эзэмшлийн талаар:

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 16 ордыг баталсан. Эдгээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудаас өнөөдрийн байдлаар 7 ордод үйл ажиллагаа явуулаагүй, 9 ордод олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого төвлөрүүлэх суурь бүтцийг бий болгох замаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш,, шударга хүртээх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцэхээр байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос хийсэн хянан шалгах ажил, түүний хүрээнд зохион байгуулсан нотлох баримт шинжлэн судлах сонсгол нь шударга ёсыг тогтоох, иргэдийн мэдэх эрхийг хангах, байгалийн баялгийг нийтийн эрх ашигт нийцүүлэн баялгийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх арга хэмжээ болсон.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2022 онд батлагдаж, тус хуулийн хүрээнд байгуулагдсан 5 дахь буюу отгон хянан шалгах түр хороо ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, бүртгэх үйл ажиллагааны хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн болон тусгай зөвшөөрлийн талбайн давхцал, ашигт малтмалын ордын зориулалтын дагуу ашиглалт, АМНАТ-ийн төлөлт, өртэй холбоотой олон зөрчлүүдийг илрүүлж, холбогдох хууль

хүчний байгууллагуудад шилжүүлэх, ард түмний өмч болох байгалийн баялгийг зүй бусаар ашигласан, хууль зөрчсөн олон үйл ажиллагааны нотлох баримт мэдээллийг иргэд олон нийтэд ил тод нээлттэй болголоо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо нь ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний эвлэлийг тусгай зөвшөөрлөө олгох, төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд хүргүүлсэн бөгөөд тогтоолын төсөлд дараах асуудлуудыг тусгасан болно. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгаж байна.

1.Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд ашигт малтмал эрх хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, бүртгэх, зориулалтын дагуу ашиглах, албан татвар, төлбөр, хураамж ноогдуулах, тайлагнах, хураах үйл ажиллагааг зохицуулсан хуулийн зүйл, хэсэг, заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, чиг үүргийн шинжилгээ хийж, холбогдох хуулийн төслийг боловсруулан 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийг одоо ба ирээдүйн үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зарчимд нийцүүлэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай давхиулан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон талбайд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлсэн асуудлыг шалгаж холбогдох арга хэмжээг авч хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх;

4.Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монголын ард түмний түүх, соёлын, дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна гэж заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан түүх, соёлын, үл хөдлөх дурсгалт газрыг хамгаалалтад авч бүртгэлийг сайжруулах;

5.Хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар Улсын тусгай хамгаалалттай газар нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан асуудлыг судалж, төрийн байгууллагын мэдээлэл зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, мэдээллийн сан хоорондын уялдааг хангах, орон зайн өгөгдөлд суурилсан мэдээллийн системийн нэгдмэл байдлыг хангахтай холбогдох арга хэмжээг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулах;

6.АМНАТ-ийн өр үүссэн шалтгааныг судалж, өрийн үлдэгдэл 1,1 их наяд төгрөгийг яаралтай барагдуулах арга хэмжээг авч, холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7.АМНАТ-ийн хувийг тооцох, төлбөр ноогдуулах, тайлагнах, төлөх журам, ашигт малтмалын хүдэр, баяжмал бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг шинэчлэн

боловсруулах, эдийн засгийн хувьд үр ашигтай дагалдах ашигт малтмалд АМНАТ ноогдуулах эрх зүйн орчныг бий болгох;

8.Үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ноогдох АМНАТ-ийг 2,5 хувиар ноогдуулж байгаа хуулийн холбогдох заалтад үр дагаврын үнэлгээ хийж, холбогдох саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

9.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч өмчлөгдөхөд төлөх татвар ноогдуулах суурийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох;

10.Хууль бусаар ашигт малтмал олборлогчийн үйл ажиллагааг таслан зогсоох, эвдрэлд орсон орхигдсон талбайн байгаль орчинд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх, нөхөн сэргээх төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоог сайжруулах;

11.Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, хаасны дараа орон нутагт хүлээлгэж өгөх асуудлыг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх;

12.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх зүйн зохицуулалтын талаар дүн шинжилгээ хийх, холбогдох саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

13.Монгол Улсын нийт газар нутгийн эрдэс баялгийн хэтийн төлөвийг тодорхойлж, үнэлэх, зохистой хэрэглээг хангах, хянах зорилгоор геологийн суурь судалгааны ажлыг эрчимжүүлэх;

14.Монгол Улсын ашигт малтмалын нөөц, орд илрэл болон газрын

хэвлийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хуульд заасны дагуу шинэчлэх, ордын ашигт малтмалын нөөцийн үнэн, зөв байдал, тоо хэмжээ, чанар, орших нөхцөл, судалгааны түвшин, эдийн засгийн ач холбогдол ордыг олборлолтод бэлтгэсэн байдалд магадлан шинжилгээ хийж, үнэмшлийг тогтоох;

15. Уул уурхайн биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

16. Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь хуулиар эрх олгоогүй журам маягт баталж, Монгол Улсаас экспортолж байгаа уур уурхайн бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээг олгож байгаа үйл ажиллагааг таслан зогсоож, холбогдох хуулийн төслийг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлээгүй хууль бусаар газрыг эвдрэлд оруулж, талбайн дүгнэлт гаргуулж, түүнд үндэслэн бичил уурхайгаар ашиглуулж байгаа асуудал илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох хуулийн дагуу шалгаж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газарт тус тус зөвлөж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд саад учруулсан албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд ирээгүй гэрчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалтын үр дүнд үндэслэн боловсруулсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Тодорхой, дэлгэрэнгүй танилцуулах санал, дүгнэлт, үүрэг даалгавар чиглэл өгсөн тогтоолын төслөөс танилцууллаа.

Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт болон тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Идэрбат гишүүнээр тасаллаа. Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Монгол Улсын Их Хурал Хяналт шалгалтын тухай хууль баталж, Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын төрийн бодлогын хүрээнд шийдэх шийдэл ирсэн асуудлуудыг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу энэ удаагийн Улсын Их Хурал хэд хэдэн сонсголуудаар хэлэлцлээ.

Улсын Их Хурлын дарга Занданшатарын зүгээс нэн ялангуяа байгалийн баялагт эзэн байх, байгалийн баялгаас хувь хүртэх, ашигт малтмалын ашиглалт, түүнтэй холбоотой асуудлууд дээр нэлээн хариуцлагатай, санаачилгатай ажилласныг энд би зориуд тэмдэглэж хэлье гэж бодож байна.

Миний бие Монгол Улсын Их Хурлын гишүүний хувьд нүүрсний хулгай луйврыг илрүүлэх Улсын Их Хурлын түр хороог байгуулж, 26 гишүүнээр гарын үсэг зуруулж, Улсын Их Хурлын даргад танилцуулахад энэ асуудлыг маш яаралтай шийдэж, Улсын Их Хурал,

төрийн эрх барих дээд байгууллагын хэмжээнд энэ асуудлыг шийдэх шийдэл зөв байна гэж ажилласан. Энэ түр хороо Монгол Улсын хэмжээнд байгаа нүүрстэй холбоотой, нүүрсний экспорттой холбоотой, гаднын хөрөнгө оруулалттай холбоотой, төрийн өмч, хөрөнгө дээр хулгай луйвар гарсан тухай асуудлыг хууль тогтоох дээд байгууллага дээр авч хэлэлцэж, энийг цаашид гаргахгүй байх, таслан зогсоож энэ үйл ажиллагааны талаар цаашид авах арга хэмжээний талаар тодорхой шийдэл гаргасан гэдгийг энд тэмдэглэж хэлье.

Түүнчлэн Монгол Улсад хамгийн их анхаарал татаж байгаа төрийн бодлогын хэмжээнд анхаарал татаж байгаа байгалийн баялагт эзэн байх, байгалийн баялгаас хувь хүртэх энэ асуудал өнөөдөр Монгол төрийн бодлогын хэмжээнд шийдэх ёстой асуудлын нэг байгаа.

Улсын Их Хурлын удирдлагын зүгээс Ашигт малтмалын тухай, энэ ашигт малтмалын олголтын тухай, Ашигт малтмалыг эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, Монгол Улсын үндсэн хуулийн 6.2-т заасан байгалийн баялагт эзэн байх энэ зарчмыг хэрэгжүүлэх, цаашид энэ асуудлыг төрийн бодлогын хэмжээнд шийдэх шийдлийн дагуу Улсын Их Хурлын энэ удаагийн түр хороог байгуулсан. Энэ түр хороонд Улсын Их Хурлын гишүүний хувьд миний бие орж ажиллаж, Монгол улсын энэ төрөөс цаашид энэ ашигт малтмалын ашиглалт, зарцуулалт, түүнчлэн уул уурхай, уугуул иргэдийн эрх ашгийн асуудлыг Монгол Улсын хэмжээнд, төрийн бодлогын хэмжээнд, хууль, тогтоомжийн хэмжээнд шийдэх ийм шийдлүүдийг гаргасан Улсын Их Хурлын тогтоолын төслийг бид өргөн барьсан. Энэ бол амаргүй байлаа.

Уул уурхайтай холбоотой асуудал, уул уурхай ашиглалттай холбоотой асуудал, уул уурхайг золиос болсон уугуул иргэдийн эрхийг хамгаалах асуудал бол өнөөдөр нийгэмд тулгамдсан асуудлын I

болж байгаа гэдгийг та бүхэн энд анхаарах ёстой. Энэ түр хороо отгон чуулганы үед энэ хийсэн ажлынхаа тайланг төр, түмэндээ тавилаа.

Энэ түр хорооноос санаачилж гаргасан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлж, байгалийн баялагт эзэн байх Үндсэн хуулийн зарчмаа хэрэгжүүлж ажиллах нь өнөөдрийн Монгол төрийн өмнө шийдэх ёстой асуудлын нэг гэж миний бие бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Адьшаа гишүүн үг хэллээ. Баярлалаа. Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Идэрбат: Энэ ашигт малтмалтай холбоотой асуудал дээр ер нь 2020-2024 оны Улсын Их Хурлын отгон хуралдаан хуралдаж байна. Тэгээд энэ 4 жилийн хугацаанд ер нь бидний амьдралын бас зовлон болсон энэ асуудлуудыг шийдвэрлэхэд гол эдийн засгийн гол тээг болж байсан энэ авлигын асуудалтай холбоотой олон чухал шийдвэрүүдийг гаргасан. Эрүүгийн хуулийг чангалсан, ашиг сонирхлын зөрчилгүй болгосон. Тэгээд Засгийн газраас өргөн барьсан энэ Үндэсний баялгийн сангийн хууль гээд ингээд батлагдсан. Тэгээд энэ болгон бол манай ахмад Ерөнхий сайдын хэлж байсан Монгол бол баян улс юм. Монголын төрийн толгойд гарчихсан хүмүүс нь ханаж цадахгүй шуналтай байгаа учраас монголчууд ядуу амьдраад байгаа юм гэж хэлсэн үгний тайлал гэж ингэж бас харж байгаа. Үнэхээр энэ Улсын Их Хурлаас батлагдсан энэ хууль, энэ хяналт шалгалтын олон сонсголудаар өнгөрсөн 30 жил ямар замбараагүй явж ирсэн, ард түмний боломжууд хаашаа алга болж байсан гээд олон зүйлүүд ер нь ил боллоо шүү дээ.

Ард түмнийгээ тэжээж байсан Эрдэнэтийн үйлдвэрийн талыг нь 5 гэр бүл хувааж идэх хүртлээ ийм замбараагүй байдалд орж байсан юм

билээ. Тэгээд энэ бүхэн бол өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас явуулж байгаа бодлогын хүрээнд ил тод боллоо гэж ингэж бас харж байгаа. Ард түмэн бас энийг бол харж байгаа болов уу гэж ингэж бас бодож байгаа.

Тэгээд энэ Улсын Их Хурлаар батлагдсан энэ сонсголын хүрээнд бас нэлээдгүй зүйлүүд хийгдэж энэ ашигт малтмалын салбар дээр гарсан алдаа оноо олон зүйлүүдийг л бас ил болгож, ингээд шийдвэр тогтоол батлагдах гэж байна.

Тэгээд би ажлын хэсгээс энэ хяналт шалгалтын хорооныхноос бас нэг зүйлийг асуух гэж байгаа юм. Монгол Улсын эрдэс баялгийн салбарын үүц болсон 16 орд байдаг гэж ингэж ярьдаг. Сая сонсгол дээр бол 9 нь ашиглалтад ороод, 6 нь бол ашиглалтад ороогүй байгаа гэж. Энэ 16 гэдэг бол үүнээс илүү байж болохгүй гэхчхэн тоо бол биш юм билээ. 16-аас илүү олон байх боломжтой байсан. Харамсалтай нь стратегийн ордод оруулахгүйгээр тухайн ордыг олон жижиг хэсэг болгож хувааж авсан барьсан гээд энэ зүйл Улсын Их Хурал дээр яригдаж байсан.

Тэгэхээр энэ хяналтын сонсгол дээр энэ 16 ордтой асуудал энэ тогтоол дээр бол зөвхөн 2 өгүүлбэр болоод л орж ирж байна. 1 өгүүлбэр болоод л орж ирж байна л даа. Яг энэ 16 ордтой холбоотой асуудал, 16 ордоос цааш нь хувааж явуулсан гэдэг тэр яригддаг тэр зүйлүүд рүү бас та бүхэн орж чадсан болов уу гэж би 1 дүгээрт асуух гэж байна.

2 дугаарт ер нь Монгол Улсын эдийн засгийн гол томоохон орлогын эх үүсвэр бол уул уурхай гэдэг нь хэний ч маргаангүй үнэн. Гэхдээ уул уурхай эдийн засгийг бүрдүүлж байгаа гэдэг утгаараа бас уул уурхай хэтэрхий бас сул замбараагүй явж ирсэн юм болов уу гэж ингэж бас харагддаг. Яг эдийн засгийн энэ экспортын орлогыг оруулж байгаа уул уурхайн орлогоос Эрдэнэт, Тавантолгой энэ тэр гэсэн энэ

томоохонууд нь яг хэдэн хувийг нь оруулаад, яг ард иргэдийн дунд малчдад, хөдөө орон нутагт тэр бөөн хар асуудал тарьдаг тэр жижиг уурхайнууд ер нь улсын төсөв дээр хэдий хэр юм оруулдаг юм бол. Энэ тал дээр бас ер нь судалж үзсэн юм байгаа юу. Миний хувьд бол яг үйл ажиллагаагаа явуулж байгаа ордын талаар судлаад үзэхэд иймхэн юм төлөхийн төлөө тэр уурхай тэнд газар ухаад байж байх, ингэж ганц нэгхэн, хоёрхон хүн ажиллуулаад нийгмийн даатгалдаа өөрийгөө эхнэртэйгээ оруулж төлөөд, тэрийгээ улсад тайлагнаад явж байгаа уурхай байх шаардлага байдаг юм болов уу, үгүй юм болов уу. Энэ нь улсын төсөв дээр тэгж их нөлөө үзүүлээд байдаг юм болов уу, үгүй юм болов уу гэсэн ийм эргэлзээ төрөөд байгаа юм. Тэгэхээр үүц болсон энэ 16 түүнээс дээш байх бололцоо байсан болов уу. 2 дугаарт энэ орон нутагт энд тэндгүй жижиг сажиг ийм уурхайнууд эдийн засагт ямархуу нөлөө үзүүлдэг юм. Энэ тал дээр ер нь ямархуу дүн.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би эхлээд Идэрбат гишүүний асуултад хариулъя. Дараа нь манай шинжээч нар, хянан шалгагч нараас нэмж хариулна биз. Идэрбат гишүүний 1 дүгээр асуулт бол стратегийн ач холбогдол бүхий ордуудын асуудлыг асууж байна.

Улсын Их Хурлаас 2007 оны 27 дугаар тогтоолыг гаргасан юм билээ. Энэ тогтоолоор өнөөдрийн ярьж байгаа стратегийн 16 ордыг улсын стратегийн орд гэж ингэж тогтоосон юм байна. Энэ тогтоолын бас дугаар заалтаар ахиад 39 ордыг стратегийн ордод бүртгэж авах асуудлыг судалж, Улсын Их Хуралд танилцуул гэдэг ийм үүрэг тогтоол шийдвэр гарсан юм байна лээ. Харамсалтай нь энэ тогтоолын энэ заалт өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байна. Тэгэхээр ахиад 16-аас гадна 39

ордыг стратегийн ордод бүртгээж авах асуудлыг цаашидаа бас Улсын Их Хурлыг хөндөж, асуудлыг тавих ёстой юм байна лээ гэдгийг нэгд хэлье.

Дараагийн асуудал нь бол энэ бичил уурхайн асуудлыг хөндөж байна. Яг үнэнээ хэлэхэд бичил уурхайнууд маань өнөөдөр хэлэлцүүлэг нотлох баримтыг шинэжлэн судлах түр хорооны нээлттэй сонсголын үеэр бол орон нутгийн удирдлагууд бол хэлж байгаа нь бичил уурхайнууд бол яг үнэнээ хэлэхэд орон нутгийн төсөвт ямар нэг татвар хураамж төлөхгүй байгаа гэдэг асуудлыг ярьж байна. Ярьж байна. Бичил уурхай гэсэн боловч хэдийгээр бичил уурхай маань өмнө нь ашиглагдчихсан, эвдэрсэн ийм талбай дээр олборлолт, ашиглалт хийх ёстой боловч, харамсалтай нь сонсголын үеэр эрүүл газрыг эвдсэн болгож, хуурамч нотлох баримт бүрдүүлж байгаад ингэж ашиглалтын хайгуулын ажил хийдэг ийм асуудлууд хүртэл амьдрал дээр байна.

Нөгөө талаар орон нутгийн төсөвт дорвитой татвар хураамж төлж байгаа зүйл ер нь бол байхгүй байна шүү гэдгийг хэлж байгаа. Тийм учраас зүгээр АМГТГ-аас бол цаашидаа энэ бичил уурхайтай холбоотой асуудал дээр ер нь нэгэнт улс, орон нутгийн төсөвт татвар хураамжаа өгдөггүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг гол мөрөн, ойн ус, газруудыг эвдэн сүйтгэдэг ийм байгаа учраас цаашидаа бас энэ тал дээр хязгаарлах асуудлуудыг хуулийн хүрээнд чангатгах ёстой гэдэг ийм байр сууриа бол сонсголын хүрээнд бас холбогдох Ашигт малтмалын газрынхан болоод хууль хяналтын байгууллагууд хэлсэн гэдгийг л хариулъя. Тэгээд нэмж тайлбар хэлэх манай Хянан шалгагч нараас 1 номер дээр хэлэх үү.

Г.Занданшатар: 1 номер. Өөрийг танилцуулаад.

С.Ган-Очир: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Хянан шалгагч байна. Стратегийн ордыг хэсэгчилж аваад

нөөцийнх нь хэмжээг бага харагдуулах байдлаар стратегид хамруулах боломжоос зайлсхийдэг гэж ойлгодог юм байна. Энэ ойлголтыг залруулъя. Мэргэжлийн хувьд ордын геологийн хилийн зааг гэдэг бол тусдаа ойлголт байдаг. Тусгай зөвшөөрлөөр тэр ордыг хэдэн ч удаа тасалж хувааж авлаа гэсэн тухайн стратегийн гэж хэлэгдэх ашигт малтмалын ордын маань нөөц 1 тоотой явж байдаг. Тийм учраас тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах нөөцөөр халхавч хийж, тэр ордыг жижиг харагдуулна гэсэн ойлголт байдаггүй юм.

2 дугаарт Эрдэс баялгийн салбараас нийт орох орлогын 90 хувийг нь стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордуудын уурхайгаас төвлөрүүлдэг. Тодруулах юм бол АМНАТ-ийн 87 хувийг саяын 27 дугаар тогтоолд дурдагдсан 16 ордоос ажиллаж байгаа 9 ордоос нь төвлөрүүлдэг гэсэн үг. Бусад жижиг уурхайнуудыг ажиллуулах шаардлага байдаг уу гэж та асуулаа. Энд бол бид нар хэт том уурхайнууддаа анхаарал тавиад эд нарын орлогод ач холбогдол өгөөд байх юм салбарын суурь ганхана гэж үздэг. Мэргэжлийн салбар бол. Бусад эдгээр уурхайд өнөөдөр жижиг гэгдэж байгаа уурхайнууд дотор ирээдүйн Оюу толгой, ирээдүйн Эрдэнэт байж байдаг. Тийм учраас эдгээр жижиг гэгдэж байгаа уурхайнуудыг ч мөн дэмжиж, энэ хэмжээнд орлого борлуулалтыг нь хүргэх чиглэлд л анхаарах ёстой гэж салбарын хүний хувьд боддог.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууна.

Ц.Идэрбат: Тийм. Энэ 16 орцтой холбоотой асуудал дээр би таны тайлбарыг бол сонслоо. Тэгээд протоколд тэмдэглэгдэж байгаа байх. Тэгэхээр энэ дээр илүү анхаарал хандуулах нь зүйтэй байх гэсэн ийм бодолтой байдаг. Их хурлын гишүүнийхээ хувьд. Дээрээс нь сая Сандаг-Очир гишүүний хэлж байгаа энэ тогтоолын

төсөл дээр бид дараагийн 39 ордынхоо асуудлыг тусгаж өгөх нь зүйтэй юм шүү гэдэг ийм саналтай байгаа. Энэ 39 гэдгийг бид мартаж болохгүй, орхиж болохгүй. Аль 2017 онд яригдсан юм өнөөдөр 10 хэдэн жилийн дараа гэхэд тусгаадаагүй байна. Ажил хэрэг болоогүй байна гэдэг чинь өөрөө бас харамсалтай тоо. Харин тэрний ар дээр хувийн хэвшилтэйгээ төр яаж хамтрах вэ гэдэг асуудал бол жичдээ асуудал шүү дээ. Тэр бол нээлттэй байж болох байх. Гэхдээ ямар ч байсан энэ 16 дээр нэмэх нь 39 гэдэг энэ процесс энэ талаар энэ тогтоол дээр би тусгаасай гэж ингэж хүсэж байгаа юм. Бичил уурхайн асуудал дээр бол бас сая би бол яг бичил уурхай биш. Саяын.../минут дуусав/

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: 2020-2024 оны Улсын Их Хурлын бүрдсэн Улсын Их Хурал отгон чуулганаа хийж байна. Энэ хугацаанд Улсын Их Хурал өнөөдөр 830 орчим хууль Монгол Улсад хэрэгжиж байгаа. Хууль ер нь бүх салбарын хийх ёстой хуулийг хуульчилсан гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг хангах асуудал манайд их хангалтгүй байгаа. Энийг дараагийн Улсын Их Хурал анхаарч шийдэх ёстой гэж ингэж бодож байгаа юм. Энэ өнгөрсөн 4 жилийн хугацаанд миний бас нэг яриад, ажил болгож чадаагүй нэг асуудал байгаа юм.

Энэ Монгол Улсын хөгжлийн бодлого загварын асуудал байгаа юм. Яаж хөгжих юм бэ нэг улсууд манай Ардчилсан намынхан болохоор либерал загвар ярьж байгаа юм. Бүгдийг нь хувьд өг, төрд юу ч байх хэрэггүй. Манай намын хувьд социал демократ үзэл баримтлалтай нам гэдэг. Тэгэхээр ерөөсөө улс болгон дэлхийн 212 улсын улс болгон хөгжлийн үеийн загвартай. Тэр тусмаа Монгол Улсын хувьд хөгжлийн загвараа их тодорхой болгох ийм шаардлага үүссэн байгаа юм л даа. Тэгээд энийг бол зарим хүмүүс

ойлгодоггүй ч хүмүүс байдаг, ойлгосон мөртөө ойшоодоггүй ч хүмүүс байдаг юм. Тийм учраас хөгжлийн загвараа маш тодорхой болгох ёстой. Энэ бол юу вэ гэхээр ашигт малтмал дээр суурилсан хөгжлийн бодлого загвар байна гэж одоо би өнөөдөр хэлэх гээд байгаа юм. Харамсалтай нь яг энэ ашигт малтмалаараа суурилсан, баялаг дээрээ суурилсан энэ бодлого маань ажил болохгүй л яваад байгаа юм л даа. Яах вэ энэ сонсгол бол их зүйл хийсэн байх. Би энийг сайн мэдээгүй.

Баялгийн санг ахалж хийсэн хүний хувьд бол сая энэ Идэрбат гишүүний яриад байгаа тэр 16 орд, 39 ордын асуудлыг бол Улсын Их Хуралд танилцуулах үүргийг та нарт өгчихсөн байгаа шүү. Энэ баялаг дээрээ суурилсан бодлогоо л их тодорхой болгох шаардлагатай шүү дээ. Нэг үе 6200 лиценз хүмүүст тараагаад өгчихсөн. Наймааны хэрэгсэл болдог. Монголчууд чинь яаж байна гэхээр зэрэг ерөөсөө баялаг бүтээж амьдардаггүй, газар худалддаг, ашигт малтмалын лиценз худалддаг, юм зуучилдаг нэг тийм хялбар байдлаар амьдардаг болчихсон байна шүү дээ. Яг жинхэнэ энэ лицензийг ямар хүмүүст өгдөг вэ гэхээр ашиглалтын лицензийг өөрөөр хэлбэл санхүүгийн чадвартай, хөрөнгийн биржид бүртгэлтэй, мэргэжлийн компаниуд олгодог. Тэгтэл тийм юм байдаггүй ингээд л яваад байгаа байхгүй юу.

Монгол Улс баялгийн асар их нөөцтэй. Менделевийн үелэх систем тэр чигээрээ байна гэж байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр ядуурал 42 хувь болчихсон байдаг. Энэ уул уурхайн салбар чинь ядуурал дэвэргээд байна гэж байгаа шүү дээ. Уул уурхайн салбар маань авлигыг дэвэргэж байна гэж байгаа байхгүй юу. Лиценз асар их худалдагдсан. Тэгээд ийм байдалтай л энэ салбарын үйл ажиллагаа явагдаж байна л даа. Тэгээд энэ уул уурхайн биржийг Бат-Эрдэнэ гишүүн бид нар хамтарч хийсэн. Төрийн өмчтэй компаниудын бүтээгдэхүүнийг худалдана гэсэн. Монголоос гарч байгаа бүх

бүтээгдэхүүн нь үүгээр гарах ёстой. Тэгж байж тэр маргаантай АМНАТ гээд юмнуудаа авдаг байх ёстой.

1,2 их наяд төгрөгийн АМНАТ-ийн төлбөр байна гэж байгаа шүү дээ. Тэгтэл нийт татварын ч бараг хэчнээн хувь юм 4,0 хэдэн их наяд төгрөг нь энэ АМНАТ байж байгаа шүү дээ. Тийм учраас энэ уул уурхайн яам, мэргэжлийн яам бол Монгол Улсыг хөгжүүлж л байвал бидэнд өөр их бодоод байх юм байхгүй. Ерөөсөө л энэ баялгийнхаа менежментийг л зөв хийх ёстой тэр. Энэ баялгийн сангийн хууль дээр дагалдаж гарсан Улсын Их Хурлын тогтоол дээр энэ стратегийн ордуудтай холбоотой 39, 16-гаар тодорхой үүргүүд өгөгдсөн байж байгаа. Засгийн газар энэ дээр ямар юм болж байна. Энэ бараг энэ чуулганы хугацаанд танилцуул гээд үүрэг өгчихсөн байгаа шүү дээ.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Ер нь бол Баттөмөр гишүүний асуултад хэлэхэд саяын миний хэлдэг тэр 2007 оны Улсын Их Хурлын 27 дугаар тогтоол өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй яваа. Тэрний тэр 3 дугаар заалт бол яг таны хэлээд байгаа 16-аас гадна 39 ордыг стратегийн ордод бүртгэж авах асуудал өнөөдрийг хүртэл хийгдээгүй байна. Улсын Их Хуралд өнгөрсөн өмнөх парламентын үед 1, 2 удаа орж ирж байсан юм шиг байна лээ. Тэгээд эцэслэн шийдэгдээгүй байна. Тийм учраас сая Идэрбат гишүүн ч бас хэлж байна. Асуултад нь хариулж яасангүй. Ер нь бол энэ тогтоолын төсөл цаашидаа энэ Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах заалтыг бас тусгайлан оруулъя гэж, оруулахад болохгүй юм байхгүй гэж ингэж үзэж байна. Тэгээд нэмэлт хариулт нь манай ажлын хэсгээс хариулна.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. 1 номер. Өөрийгөө танилцуулаарай. Ажил, албан тушаал.

С.Ган-Очир: Түр хороонд ажилласан хянан шалгагч байна. Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Үндэсний баялгийн сангийн суурь болсон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувийг тогтоох, хил заагийг мөн тогтоох чиглэлээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Мөн таны хэлсэн шинээр хамруулах ордын буюу 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан 39 орд, шинээр нөөц нь тогтоогдсон томоохон ордуудыг судалж хамруулах талаар мөн 2 дахь ажлын хэсэг бас байгуулагдаад ажиллаж байгаа. Энэ чиглэлээр ажиллаж байгаа гэсэн үг.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.Хянан шалгах түр хорооны саналаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг нэгдсэн журмаар санал хураалтын цагт явуулна.

Байнгын хороодын хурал дууссан уу. Байнгын хороодын хурал дуусаад, гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Хянан шалгах шинжээчээр ажилласан нэр бүхий 8 хүн оролцож байна. Ажлын шаардлагаар нэр усыг нь зарлах бололцоогүй байгаа учраас жич талархал илэрхийлж, түр хорооноос бас сайн ажилласан хүмүүст талархал илэрхийлнэ.

Ер нь бас энэ сонсгол хийх ажил бол бас хүнд суртал чирэгдлээс гадна дарамт шахалт ихтэй ийм ажил байна гэж манай ажлын хэсгийн гишүүд мэдэгдэж байгаа. Бас тийм учраас энэ хүмүүсийн эрх зүйн баталгааг хангах талаар холбогдох байгууллагууд анхаарч байгаа. Сайн ажилласан ажлын хэсгийн гишүүд баярлалаа.

Тэгэхдээ энэ ажил үргэлжлэхээр сая олон тогтоол чиглэл, үүрэг өгөгдсөн. Тэр үүргүүдийг, чиглэлүүдийг, даалгавруудыг бодитой хэрэгжүүлж

ажиллахад холбогдох албан тушаалтнууд анхаарах шаардлагатай. Иигээд санал хураалтыг хойшлууллаа. Тогтоолын төслийг батлах санал хураалт жич энэ асуудлын дараа явуулна. Гишүүд чуулганы танхимд цугларъя. Ажлын хэсгийн гишүүд, хянан шалгах шинжээч нарт баярлалаа. Гишүүдийг дууд. Санал хураалт явуулна.

14.04 цаг.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Энэ манай Сандаг-Очир гишүүнтэй л өдөр байна даа.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн

хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг эцэслэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

14.08 цаг.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд танилцуулна. Дараа нь санал хураалттай. Гишүүдийг чуулганы танхимд цуглуулъя.

Ш.Раднаасэд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын зарим гишүүдээс хууль хоорондын нийцлийг хангах, өрийн удирдлагыг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн “Хууль баталсантай холбогдуулан арга хэмжээний тухай” тогтоолын төслийг боловсруулсан.

Энэхүү тогтоолын төслийг 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдаанаар Байнгын хороо хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Байнгын хороо “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасан байна. Энэ горимын саналыг дэмжих санал хураалт явуулна. Санал хураалтын цагт явуулъя. Гишүүдээ цуглуулаач.

14.10 цаг.

Дараагийн асуудалд орно.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглая. Цагаан алт хөтөлбөрийг батлах тухай санал хураалт явуулна. Гишүүд цуглаарай.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засваруудыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийг танилцуулъя. Янзугийн Содбаатар, Ерөнхийлөгчийн

Эдийн засгийн бодлогын зөвлөх Батсуурийн Даваадалай, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Жаргалсайханы Мөнхболд, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Чойжилсүрэнгийн Эрдэнэбат, Арьс, шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Түгжжэжавын Баярсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мэндбаярын Дондогдорж, тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Цэрэнпунцагийн Амгалан, тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Батбаярын Эрхэмбаяр.

Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хураалт. Байнгын хороо дууссан уу. Гишүүдийг дуудъя. Санал хураалтыг түр хойшлуулж байна. Гишүүдийг дуудна.

14.14 цаг.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна. Зам, тээврийн хөгжлийн сайд.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд ишлэжүүлсэн.

Байнгын хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримтлан явуулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

2001 оноос хойш хэрэгжихгүй байсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэцэн ишидвэрлэж, төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Зарчмын зөрүүтэй санал байхгүй. Тийм ээ. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг санал хураалтын нэгдсэн цаг эхлэхээр санал хураалт явуулна.

Дараагийн асуудлыг хэлэлцэнэ. Ажлын хэсэгт баярлалаа. Санал хураалтыг нэгдсэн журмаар явуулна. Энэ асуултын дараа санал хураалт явуулна.

Гишүүд чуулганы танхимд цугларна. Сайд нар холбогдох асуудлууд нь батлагдах гэж байгаа сайд нарыг дууд. Энэ асуудлыг хэлэлцээд, дараа нь санал хураалт явуулна. Дараа нь санал хураалт явуулна.

Монгол улсын хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэгдээгүй, энэ үлдэж байна.

14.16 цаг.

Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэх шаардлагын хүрээнд 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцэнэ.

Үүний дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Хяналт шалгалтын түр хорооны тайлан болон санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хянан шалгах түр хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор байгуулагдсан нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хороо 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр хуралдаж Хянан шалгах түр хорооны тайланг гаргасныг та бүхэнд танилцуулж байна.

Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Д.Батлут, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн, Ж.Батсуурь, Н.Ганибал, С.Одонтуяа, Т.Доржханд нар орж ажиллалаа.

Хянан шалгах түр хорооноос нотлох баримтыг шинжлэн шалгах сонсголыг 2024 оны 5 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгууллаа. Энэ нь Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хууль хэрэгжсэнээс хойш 4 дэх удаагийн сонсгол юм.

Нийслэлийн нийтийн тээврийн автобус худалдан авах үйл ажиллагаанд хамаарах баримт бичиг, материалыг иж бүрэн зохих шаардлага хангуулан шуурхай гаргуулах ажлын хүрээнд хянан шалгагч, шинжээчдийн баг нийт 20 гаруй байгууллага, албан газарт хандаж шаардлагатай баримт материалыг нотлох баримтын шаардлага хангуулан нийт 6729 хуудас баримт материалыг нотлох баримтаар бүрдүүлэн ажиллалаа.

Мөн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Тээвэр хөгжлийн банк, МҮОНРТ, Нийслэлийн нийтийн тээврийн газар, Тэнүүн-Огоо компаниудад орж ажилласан болно.

Хяналт шалгах түр хорооноос баталсан нотлох баримт гардуулах тухай 2024 оны 02, 04 дүгээр тогтоолын хүрээнд нотлох баримтууд цуглуулах, хяналт шалгалт дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргуулахаар хянан шалгагчаар З.Баярбилэг Үндэсний Аудитын газрын нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитор, Л.Амгалан Сангийн яамны ахлах шинжээч, Э.Цолмонбаяр Монголбанкны ахлах хянан шалгагч, А.Отгонбаяр Технологийн багш, электораникийн инженер, З.Чүнсэрээ Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, шинжээчээр Д.Дариймаа Үндэсний аудитын газрын ахлах аудитор, Э.Эрдэнэбилиг Монголбанкны хянан шалгагч, Д.Төрмөнх Стандартчилал хэмжилзүйн газарт ахлах мэргэжилтэн зэрэг нийт 8 хянан

шалгагч, шинжээчийг томилон ажиллууллаа.

Сонсголд Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг хууль хяналтын байгууллагаас гадна, урилгаар Үндэсний Аудитын газар, Зам, тээвэр хөгжлийн яам, Сангийн яам, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Гаалийн ерөнхий газар, Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг төрийн байгууллагын төлөөллүүд оролцсон болно.

Сонсголыг худалдан авах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулсан үндэслэл шалтгаан, автобус нийлүүлэх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилт, худалдан авсан автобусны техникийн үзүүлэлт гэсэн үндсэн 3 сэдвийн хүрээнд нийт 6 асуудлаар явуулсан бөгөөд мэдэгдэх хуудас хүргүүлсэн ийт 96 гэрчээс 66,7 хувь нь оролцож, телевиз, сайтаар шууд дамжуулан иргэдэд бодит мэдээллийг хүргэн олон нийтийн мэдэх эрхийг хангах үйл ажиллагаа амжилттай явсан.

2 өдрийн турш үргэлжилсэн сонсголд Хянан шалгах түр хорооны гишүүд 81,8 хувийн ирцтэй оролцож, нийслэлийн нийтийн тээврийн автобус худалдан авах ажиллагааны талаар гэрч, хянан шалгагч, шинжээч, албаны хүмүүсээс асуулт асууж, хариулт авч, гарц шийдэл илэрхийллээ.

Энэ сонсгол бол Монгол Улсын Засгийн газрын явуулж байгаа “5Ш” ажиллагааны үндэслэл боллоо. Бид танил тал, харилцаа хамаарал, сайд, удирдах албан тушаалтнуудын түвшинд төрийн худалдан авах ажиллагааны нөхцөл байдал ямар байгааг ард иргэддээ ойлгуулж, авлига, албан тушаалын гэмт хэрэг болохгүй, бүтэхгүй байгаа бүхнийг үүд хаалгыг хаах, иргэд олон нийттэй хамтран төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, асуудлыг үнэн бодит

байдлаар тодорхойлж, тухай бүр шуурхай шийдвэрлэхийн төлөө ажилласан.

Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголоор иргэдийн мэдэх эрхийг хангаж, иргэдийн төрд тавих хяналтын тогтолцоог бэхжүүлж томоохон өөрчлөлт гарна гэдэгт бид итгэлтэй байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороонд холбогдох хуулийн дагуу цуглуулсан нотлох баримтад үндэслэсэн дараах дүгнэлтийг гаргаж та бүхэнд танилцуулж байна.

1.Төсвийн ерөнхийлөн захирагч, Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргаас худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж заасан заалттай нийцээгүй болно.

2.Монгол Улсын 2023 оны улсын төсөв батлагдсанаас хойш нээлттэй тендер шалгаруулалтын журмаар тус төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг холбогдох хуульд нийцүүлэн ил тод, нээлттэй, тэгш, өрсөлдөх боломжоор ханган шуурхай зохион байгуулах боломжтой байжээ. Гэвч Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нь тус төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг үндэслэн захирамжилсан нь Төрийн төрийн болон албаны нууцын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хуультай нийцэхгүй байна.

3.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч Г.Энхтайван нь төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулах шийдвэр гаргахдаа төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг мөрдөөгүй байна.

4.Захиалагч нийтийн тээврийн автобус худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч сонгохдоо төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль журмыг дагаж мөрдөөгүйгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагаа нь ил тод нээлттэй бус зохион байгуулагджээ. Тухайлбал, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд оролцох тэгш боломжийг олгоогүй, урилга хүргүүлсэн этгээдүүдэд баримт бичиг ирүүлэх хугацааг харилцан адилгүй зааж өгсөн нь өрсөлдөх тэгш боломжийг бүрдүүлээгүйгээс гадна тендерт оролцох баримт бичиг бэлтгэх хангалттай хугацааг олгоогүй. Захиалагч, гүйцэтгэгч талуудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж үр ашиггүй худалдан авалт болжээ гэсэн дүгнэлтийг хийж байна.

5.Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн Нийслэлийн Нийтийн тээврийн газрын 23001 дүгээр гэрээг байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан нөхцөл шаардлагыг харгалзан үзэлгүйгээр Агаар орчныг бууруулах үндэсний хорооны 2019 оны 1903 дугаар тогтоолыг зөрчин үндсэн гэрээг байгуулсан гэж дүгнэлтэд гарч байна.

Түүнчлэн нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан 2023 оны 2 дугаар сарын 10-ны

өдрийн Нийслэлийн Нийтийн тээврийн газрын 23000101 дүгээр гэрээний 2.1 дэх хэсэгт их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус 606 ширхгийг 600 болгон өөрчилж, гэрээний үнэд өөрчлөлт ороогүй, хөдөлгүүрийн багтаамж өөрчлөгдсөнтэй холбоотой тооцоо судалгааг хэрхэн хийсэн нь тодорхойгүй байна.

7.Хянан шалгах түр хороонд ирүүлсэн нотлох баримтын хүрээнд шинжилж үзэхэд Голомт банк Банкны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гуравдагч этгээдэд баталгаа гаргасан байна.

8.Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд нийтийн тээврийн автобус худалдан авах 272,2 тэрбум төгрөгийн батлагдсан санхүүжилтээс 2023 оны 3 дугаар сарын 9-ний өдрөөс 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд нийт 5 удаагийн санхүүжилтээр Тэнүүн-Огоо ХХК-д 134,5 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна. Энэ нь 2023 онд ноогдох нийт санхүүжилтийн 49,4 хувийг эзэлж байна.

9.Улсын төсвийн санхүүжилтээр 134,5 тэрбум төгрөгөөс Тэнүүн-Огоо ХХК нь автобус нийлүүлэх БНСУ-ын Иктаеэ компанид 21 сая 948 мянга 600 ам.доллар, Ачаа тээврийн Воннам компанид 838 мянга 200 ам доллар, БНХАУ-ын цахилгаан автобус үйлдвэрлэгч Нинжин Голден Драгон Басс компанид 62 сая 39 мянга 954 юань, автобусны дагалдах хэрэгсэл үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч БНХАУ-ын 3 компанид 882 мянга 992 юань буюу нийт 111 тэрбум төгрөгтэй тэнцэх мөнгөн хөрөнгийг шилжүүлсэн нь баримтаар нотлогдож байна. Дээрх шилжүүлгийн дараах байдлаар Монгол улсын хилээр Дайво 100 ширхэг, Хьюндай каунтри 50 ширхэг, Скай Велл 55 ширхэг, нийт 205 ширхэг автобус орж ирсэн бол 94 ширхэг Дайво автобус орж ирээгүй. Төлбөрийг урьдчилж шилжүүлсэн байдалтай байна.

Кассаас өндөр мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний зарлагын үйлчилгээ хийгдсэн байна. Үүнд: Ц.Болортуяа 3,7 тэрбум, Т.Жавхлансүрэн 1,7 тэрбум төгрөг, Н.Түвшинжаргал 1,6 тэрбум, Б.Энхжаргал 724,5 сая, С.Рэгмаа 350 сая төгрөг ноогдож байгаа бөгөөд Тэнүүн-Огоо компанийн итгэмжлэл бүхий ажилтнууд 3,7 тэрбум төгрөг, Эм Эс Пи Партнерс компанийн эрх бүхий ажилтан нь 3,6 тэрбум төгрөг, Грийн Энерджи Моторс ХХК-ийн ажилтан 724,5 сая төгрөгийг тус тус бэлэн мөнгөөр авсан нь баримтаар нотлогдож байна. Дээрх бэлэн мөнгөний гүйлгээнээс данс хөөх аргаар шалган үзэхэд Тэнүүн-Огоо ХХК-ийн ажилтан Н.Түвшинжаргал 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр компанийн америк долларын данснаас 724,5 сая төгрөгтэй тэнцэх 203 мянга 600 амдолларыг бэлнээр авч, Ваннам Жи Эл Си компанийн Монгол Улс дахь төлөөлөгч Жанг Су Ли Ли-ийн Голомт банк дахь дансанд 80 автобусны тээврийн хөлс утгатайгаар тушаасан бол, 199 мянга 200 ам.долларыг 2023 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр дансыг хамтран эзэмшигч Б.Номинд бэлнээр гаргаж авсан байна.

11.Техникийн тодорхойлолт боловсруулж батлуулахдаа бодлогын баримт бичгүүдийг шаардлагатай эрх зүйн актуудыг дутуу судалсан гэж үзэх үндэслэлтэй байна. Мөн ажлын хэсэг автобуснуудыг хүлээн авахдаа техникийн тодорхойлолтод заасны дагуу нэг бүрчлэн үзүүлэлт бүрээр тулган шалган аваагүй бөгөөд тухайлбал дунд багтаамжийн Хюндай каунтри маркийн автобус их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Дайво Би эс 106 маркийн автобусны үйлдвэрлэгчийн техникийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна. Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Дайво Би Эс 106 маркийн автобусны хөдөлгүүрийн экологийн ангилал нь Евро 5 байхаар техникийн тодорхойлолт, худалдан авах гэрээнд тусгагдсан боловч бодит байдал дээр Евро 2 ангилалд хамаарч байна. Дайво Би Эс 106 маркийн дизель хөдөлгүүртэй

автобусны үйлдвэрлэгчийн таних тэмдэг нь арал дээр байришил, найз бичигдсэн мэдээлэл нь засвартай байна. Будалтын хувьд үйлдвэрлэлийн нөхцөл техникийн шаардлагын дагуу хийгдээгүй.

12. Монголын Үндэсний Олон Нийтийн радио, телевизийн Монголын мэдээ сувгаар 2023 онд нийлүүлсэн нийтийн тээврийн автобусыг Төв талбайгаас шууд эфирийн дамжуулалтаар хуучин автобус оруулж ирж байгаа гэх мэдээлэл ташаа гэх утгатай мэдээллийг хуучин автобус орж ирж байгаа нь ташаа гэх мэдээллийг цацсан байна. Энэ талаар тайлбар тодруулгыг авахад сурвалжлагч баг тухайн мэдээг сурвалжлах үед пост текстийн алдаа гаргасан. Өөрөөр хэлбэл бэлтгэсэн мэдээ мэдээлэл нь эх сурвалжтай гэсэн тайлбар өгсөн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дээрх асуудал нь хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа тул хууль хяналтын байгууллагаар шалгах саналыг тусгаагүй бөгөөд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Төрийн байгууллагын үйл ажиллагаа сахилга хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд дараах саналуудыг танилцуулж байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль шинэчлэн батлагдаж 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж ажилласан. Цаашид энэ хуулийн хүрээнд төрийн худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, тэгш өрсөлдөх боломжоор хангаж, хуулийн дагуу хуульд нийцүүлэн зохион байгуулж, үндэслэл бүхий тооцоолол, судалгаанд тулгуурлаж, хүрэх түвшинийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Сонголд гэрчээр дуудагдсан Нийслэлийн нийтийн тээврийн газрын дарга асан С.Жавхланбаатарын өмгөөлөгч Г.Ганбат нь Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, уг хэлэхэд гишүүний бүрэн

эрх, халдашгүй байдалд халдаж зүй бус үг хэллэг хэрэглэж, сонсголын дэг зөрчсөн тул Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцуулах саналыг хууль хяналтын байгууллагад хүргүүлэх болно.

Аливаа худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль дээдлэх зарчмыг баримталж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөх, эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж чиглэлийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байх бөгөөд төрийн захиргааны байгууллагууд шат шатын үүрэг хариуцлагын тогтолцоог сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Техникийн тодорхойлолт боловсруулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн хурлын тэмдэглэлээс харахад авто тээврийн салбарт бодлогын түвшинд шийдвэр боловсруулах чадвартай инженер техникийн ажилтнууд дутмаг байх тул хүний нөөцийг бэлтгэх асуудлыг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны авто тээврийн хэрэгслийг техникийн хяналт үзлэгт оруулах давтамж оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай 2013 дугаар тогтоолын 2-т авто тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн оноос хойших 2 жил техникийн хяналтын үзлэг оруулахгүйгээр зөвхөн тээврийн хэрэгслийн тооллогод хамруулж байсугай заалтыг өөрчлөх, шаардлагатай тохиолдлууд хүчингүй болгох.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх парк шинэчлэлийн дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийж Улсын Их Хурлын хянан шалгах Түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг та

бүхэнд танилцууллаа. Хянан шалгах түр хорооны дэлгэрэнгүй тайланг та бүхэнд хүргүүлсэн болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Баярлалаа. Түр хорооны санал, дүгнэлт танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд алга байна.

Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлт, танилцуулгатай танилцлаа. Ингэснээрээ Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 33.8-д заасны дагуу Хянан шалгах түр хороо тайлан, санал дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулснаар уг хороо татан буугдсанд тооцно гэж заасны дагуу Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлийн шаардлагын хүрээнд 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хянан шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хороо татан буугдсанд тооцлоо. Санал, дүгнэлт, нотлох баримтуудаа холбогдох байгууллагад шилжүүлнэ.

14.33 цаг.

Ингээд санал хураалтууд явна. Нийтдээ 15 төсөл. Ажлын хэсэгт баярлалаа. 15 асуудлаар санал хураалт явуулна. 15 санал хураалт явуулна. Санал хураалт байгаа. Ердийн горимоор явах санал хураалтууд байгаа. Ердийн горимоор явах санал хураалтад Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн төсөл чинь эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар явуулчихсан. Баяр наадмын тухай хууль эцэслэн батлах бэлтгэл хангахаар шилжчихсэн. Хот, тосгон дараа нь хэлэлцэнэ. Ирц бүрдэхээр хэлэлцэнэ.

Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа.

Шүүхийн тухай хуулийн зарчмын зөрүүтэй 2 саналаар санал хураалт

явуулъя. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.6 дахь заалтын “шүүгч болон” гэснийг хассугай.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 56,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Доржжанд, Дэлгэрсайхан гишүүд байсан. Дуудаарай. Раднаасэд гишүүнийг дуудаарай.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор хураалт явуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “үндсэн эрхэд” гэснийг “амь нас, эрүүл мэндэд” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 56,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

14.37 цаг.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай

хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

Байнгын хороо Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журм тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлжээ.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулж, санал асууж, асуулт хариулт авч дууссан. Байнгын хороонд шилжүүлчихсэн.

“Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалт явуулна.

128. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

129. Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиуд байна.

130. Аж ахуйн нэгжгийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

131. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

132. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

133. Ул хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

134. Биеийн тамир спортын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

135. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

136. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиуд байна.

137. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр

саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

138. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

139. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

140. Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

141. Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

142. Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

143. Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

144. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

145. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай

гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

146. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

147. Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

148. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор боловсруулсан хуулийн төслүүд байна.

149. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

150. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

151. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

152. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр

саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

153. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

154. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

155. Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

156. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

157. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

158. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр санал саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй

байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

159. “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

160. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

161. Мал, амьтны эм, тэжээлийн нэм нэмэлтийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиудыг танилцуулъя.

162. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

163. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

164. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

165. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

166. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг нь сонссонд тооцлоо.

167. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

168. Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

169. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан хуулиудыг танилцуулъя.

170. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

171. Малчны тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

172. Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

173.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

174.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

175.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол хэлэлцэгдээгүй учраас энэ эцсийн найруулгад бол хийгдээгүй гэдгийг протоколд тэмдэглэн үлдээе.

176.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиуд байна.

177.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

178.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

179.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

180.Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

181.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уубайхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

182.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

183.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

184.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонслоо.

185.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

186.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

187.Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй

байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

188.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

189.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

190.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

191.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

192.Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

193.Ул хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

194.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

195.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр

саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

196.Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

197.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

198.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

199.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

200.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

201.Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

202.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

203. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

204. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

205. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

206. Хотын албан татварын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

207. Нийслэл хотын албан татварын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

208. “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

209. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

210. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

211. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

212. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан хуулиуд байна.

213. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

214. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиуд байна.

215. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

216. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

217. Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

218. Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

219.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

220.Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

221.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

222.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

223.“Хот байгуулах тухай. Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

224.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиуд нь байна.

225.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

226.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

227.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

228.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

229.“Цалингийн хэмжээ тогтоох, итгэлцэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

230.“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан хуулиуд байна.

231.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

232.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиуд байна.

233.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

234.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

235.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

236.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

237.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

238.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

239.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

240. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан хуулиуд байна.

241.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

242. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд дуусаж байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

243. “Хуулийн төсөл буцаах тухай “Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо болчихсон уу. Хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсож дууслаа.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын даргын захирамжийг танилцуулъя.

Улсын Их Хурлын чуулганыг түр завсарлуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.18 дахь хэсэг, Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн саналыг харгалзан захирамжлах нь.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу “сонгуулийн жилд ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулж чуулганыг 1 сар хүртэл хугацаагаар түр завсарлуулж болно.” гэж заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ажиллагаатай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганыг 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл түр завсарлуулсугай.

Энэ захирамжийг 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм захирамжийг даргын дэргэдэх зөвлөлийн саналаар гаргаж, танилцуулж байна.

Ингээд Улсын Их Хурлын чуулган түр завсарлахтай холбогдуулж Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ үг хэлнэ.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд та бүхэндээ би өнөөдөр өнгөрсөн 3 жилийн хугацаанд олон зүйл дээр хамт ажилласанд талархаж байгаагаа илэрхийлэх гэсэн юм. Баярлалаа.

Энэ Улсын Их Хурал бол маш онцлогтой Улсын Их Хурал байлаа. Миний хувьд ч гэсэн дөнгөж Ерөнхий сайдаар томилогдох үед танхим яг ингээж хуралдаж бас чадахгүй байсан цаг хугацаа. Бүгдээрээ масктай, бүгдээрээ ишлэн хоргоны цаанаас хоорондоо харьцдаг, бас хоорондоо уулзаж чадахгүй байсан ийм цаг хугацаа. Тухайн үед хил хэзээ нээгдэх нь тодорхойгүй, эрх зүйн орчин маш хүнд, эдийн засаг -4,7% болчихсон, улсын төсөв 30 орчим хувиар тасарсан байсан ийм цаг хугацаа. Өнөөдрийг хүртэл би парламентын гишүүддээ энэ хүндрэлтэй нөхцөл байдлын талаар бас талархал илэрхийлж амжаагүй л өнөөдрийг хүрлээ.

Та бүхэн маань цар тахалыг даван туулах Засгийн газрын багц бодлогыг дэмжиж чадсан. Энэ агуулгаараа боловсролын салбарт хэмнэгдэж байсан

төсвөөр улсын төсөв явж, вакцинжуулалтыг бид нар цаг алдахгүй татан авчирч, тэр түүхтэй, хүндрэлтэй, мөн улс төр дөхчихсөн ийм үед манай парламентын гишүүд хэдийгээр намын хувьд өөр өөр үзэл баримтлалтай ч гэсэн улсынхаа хувьд бүгд нэгдмэл, том зургаар харж байсанд би талархах учиртай. Ингээж чадсанаараа бид нар цар тахлын давж чадсан. 2 сарын 14-ний өдөр байсан. Бид нар 2 сарын 14-ний өдөр цар тахлын хамгийн сүүлчийн хязгаарлалтуудыг цуцалж, нэг үгээр хэлбэл олон нийтийн олон үйл ажиллагаанууд бас нээгдэж байсан. Тэгээд тэр өдөр бид нар хамтдаа бас баярлаж Ази Номхон Далайн бүсэд анх удаа бас цар тахалыг цуцалсан улс орнуудын нэг боллоо гэж хамтдаа уулзаж байсан.

Харамсалтай нь яг 14 хоногийн дараа 2 сарын 24-нд ОХУ, Украйны дайн эхэлсэн. Залгаад бензин шатахуунаас эхлээд, мөн манай уур уурхайн салбарын гол тэсрэх дэлбэрэх бодисуудаас эхлээд бүгд тасарсан. Наран цэцгийн тосноос эхлээд бүгд хомсдол үүссэн. Энэ үед Засгийн газраас мөн л үнэ тогтворжуулахтай холбоотой ийм багц хуулийн төслийг оруулж ирсэн. Улсын Их Хурал дэмжсэн. Ингэснээр бид нар шатахууны хүртээмжийг дээшлүүлэх, мөн боомт гээд олон зүйлүүдийг хамтад нь авч явах ийм боломжийг гаргасан.

Засгийн газар шинэ сэргэлтийн бодлогыг дэвшүүлж боомтуудаа нээх, энэ дээр хувийн хэвшилтэйгээ хамтарч ажиллах ийм бодлогыг гаргаж, тухайн үед бид нар валютын нөөц маш хүнд болчихсон олон жилийн хувьд бас талцан маргасан Оюутолгойн гүний уурхайг эхлүүлэх 2,3 тэрбум орчим долларын өр хуримтлагдчихсан байсан. Энэ дээр манай Улсын Их Хурлын түр хороо, манай парламентын гишүүд онцгойлон би бас Ардчилсан намынхандаа талархал илэрхийлэх учиртай. Яагаад гэхлээр тэр үед бүгд надтай орж ирж уулзаж байсан. Улс төржих, улс төржихгүй юм гэж байна. Яг энэ гүний уурхайтай

холбоотой, эдийн засагтай холбоотой энэ том асуудал дээр бид нар Засгийн газрын бодлогыг дэмжинэ. Бас ХҮН намын дарга Доржханд дарга бас танд талархаж байгаагаа илэрхийлье. Ингээд бид нар нэгдмэл байдлаар олон жилийн хувьд гацсан төслөө урагшлуулсанаар валютын нөөц эргэж нэмэгдэх ийм том боломж бол бас бид нарт гарсан.

Мэдээж бид нар хамтдаа бас ярилцаж байсан зүйл бол эн олон жил бугширсан бас ийм авлигын асуудалтай нам харгалзахгүй тэмцэх, олон бугширсан асуудлуудыг бас бид нар ил тод болгох ийм асуудлууд гарсан. Энэ дээр манай парламентын нэр бүхий гишүүд маань ч гэсэн хүнд байдалд орсон. Гэхдээ л дараалсан олон сонсголдуудыг хийж, бид нар олон сангуудыг ил тод болгож, эрх зүйн орчноо маш чанга болгож Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд өөрсдөө төрийн тендерт оролцохгүй гэдэг ийм том улс төрийн шийдвэрийг манай парламент гаргаж чадсан. Мэдээж тухайн үед саналын хувьд зөрүүтэй олон зүйл байсан боловч үүнийг бас хийж чадсан.

Цар тахал, дайн давхацсан энэ үед цаашилаад Монгол Улс илүү бодлогын хувьд тогтвортой, олон ургалч үзэл санаатай олон намын төлөөлөлтэй парламент байхын тулд бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх ийм улс төрийн зөвшилцөл рүү хамтдаа явсан. Тухайн үед инфляц маш өндөр болчихсон. Олон жагсаал цуглаантай байсан. Улсын Их Хурлын гишүүд тойрогт очоод парламентын гишүүдийн тоог нэмэх тухай асуудлыг ярихад бүгд бараг маш том шүүмжлэл дундуур явж, ийм хүнд зүйлтэй бид нар хамтдаа тулгарч байсан. Гэхдээ дэлхийн 2 том гүрний дунд оришин тогтнодог парламентын ардчилсан засаглалтай Монгол Улсын хувьд бид нар илүү олон ургалч үзэлтэй, илүү төлөөллөө хангаж, илүү нийгмийн сегментийн төлөөллийг, нийгмийн удирдагчдынхаа төлөөллийг

хангаж чадах энэ гарцыг хийж чадах нь бидний хувьд туйлын их чухал байсан.

Яг энэ цаг үед Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Гутариш Монголд айлчилж, дэлхийн геополитикт заримдаа том хүндрэл гардаг. Заримдаа том шуурга дэгддэг. Энэ шуурга дунд далай хад 2 заримдаа зодолдож байгаа юм шиг харагддаг, гэхдээ өглөө болоод үүр цайхад далай ч хэвээрээ хад ч хэвээрээ, харин усан дунд байгаа амьтад далай мөргөж амь насаа алдсан байх нь олонтой. Дэлхийн том геополитикийн их гүрнүүдийн сөргөлдөөн дунд хөгжиж байгаа улс л хамгийн их зовлон үздэг гэдэг үгийг хэлж байсан. Энэ агуулгаараа бид нар зөвшилцлийн парламент руу энэ сонгуулийн тогтолцооны реформ руу явахаас өөр ямар ч гарц байгаагүй. Энийг бид нар хийж чадсан. Ингээд бид нар 76-тай парламентыг түүх болгон үлдээж, нэн шинэ 126 парламенттай бас холимог тогтолцоотой, үүгээр нийгмийн экспертүүд, эрдэмтэн судлаачдын дуу хоолой парламентад цус сэлбэн орж ирэх ийм тогтолцооны реформыг бид нар Үндсэн хуулиараа бас амилуулж чадсан. Үүнд би бас талархах ёстой.

Эрдэнэт, Оюутолгой гээд олон бас асуудал дээр бидний хувьд эрх зүйн хувьд бас цэг тавьж чадсан. И-монгол цахим платформыг анхны цахим Байнгын хороотой, анх удаа Эдийн засаг, хөгжлийн яам буюу үндэсний бодлого тодорхойлдог институцээ Шадар сайдын статустай гаргаж ирсэн парламент. Мөн анх удаа цахимаар хуралдсан парламент. Мөн Цахимжилтын байнгын хороо байгуулж, цахим яам байгуулахыг дэмжсэн парламент бас байж чадсан.

Олон жил ярьсан Үндэсний баялгийн сангийн хуулийг бид нар баталсан. Ингэснээрээ илүү хөрөнгө оруулалтын орчин тогтворжиж, илүү байгалийн баялагтаа иргэд маань хувь хүртэх, байгалийн баялгаа ашиглуулж байгаа орон нутаг илүү түрүүлж хөгжих, мөн орон сууц болон боловсрол, эрүүл мэнд

гээд олон салбар дээр илүү байгалийн баялгаас дэмжих ийм боломжтой тогтолцооны реформыг бид нар Сингапурын хуримтлалын сан болон Норвегийн баялгийн сангийн загвараар ийм эрх зүйн суурийг бүрдүүлж чадсан нь бол туйлын чухал. Мөн аялал жуулчлалын багц хуулийг парламент баталсан. Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих Ерөнхийлөгчийн том реформыг бас энэ парламент дэмжсэн. Ингэснээрээ зөвхөн уурхай тулгууртаа биш нэмэх нь аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбар бодитоор хөгжих бас ийм боломжтой эрх зүйн орчныг бас бүрдүүлж чадсан. Ингэснээрээ өнөөдөр эдийн засаг маань - 4,7 хувиас 6-7 орчим хувьтай болж, валютын нөөц тогтворжиж, ДНБ 2 дахин бас тэлж чадсан.

Мөн бид нар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг өнөөдөр хамтдаа ярилцаж баталлаа. Ингэснээрээ бид нар илүү нийслэл Улаанбаатар хотыг нэг тулгууртаа биш зөвхөн энэ 700 га дунд байдаг биш, илүү олон тулгууртай төрийн захиргааны байгууллагууд ч гэсэн бас өөрсдөө манлайлж нүүх ийм боломжийг бас та хэд маань бүрдүүлж бас чадлаа.

Мэдээж ингээд дурдаад байвал олон зүйл байгаа. Өнөөдөр би ямар нэгэн байдлаар ийм зүйл ингэлээ, тийм зүйл ингэлээ гэдэг тайлбар хийхийг хүсэхгүй байна. Мэдээж чадсан, чадаагүй маш их олон зүйл байгаа. Чадаагүй бүх зүйлийнхээ төлөө би та бүхнээс уучлалт хүсье.

Дэмжиж ажилласан эрхэм парламентын гишүүддээ, нийт Засгийн газрынхаа гишүүдийн нэрийн өмнөөс энэ төвөгтэй, хүнд сорилттой 3 жилийг туулахад хамт байсанд маш их баярлалаа.

Тэгээд амьдрал бол зөвхөн өнгөрсөн цаг хугацаа биш, харин амьдрал бол өнгөрсөн цаг хугацаан дотор үлдсэн дурсамж гэдэг үг байдаг. Энэ удаагийн парламент Монгол Улсын эрх зүйн

орчинд, Монгол Улсын тогтолцооны түвшинд цоо шинэ реформыг хийсэн гэдэг түүх болж үлдэнэ гэдэгт миний бие огт эргэлзэхгүй байгаа.

Ингээд удахгүй бас улс төрийн сонгууль болж байна. Үүнд шударга сайхан өрсөлдөгчөө. Илүү мэтгэлцээнээр, илүү бодлогоор өрсөлдөх энэ боломжийг бас бид нар бүрдүүлэх нь зүйтэй. Ингээд дэвшиж байгаа бүх парламентын гишүүддээ бас ёс зүйн манлайлал гаргаж манай Бат-Эрдэнэ гишүүнээс эхлээд өөрсдөө санал тавьж бас энэ үе солих процессыг эхлүүлэхэд тус болсон манай Нямаагийн Энхболд даргаас эхлээд олон парламентын гишүүддээ манай Мөнх-Оргил гишүүн байна, Баттөмөр гишүүн байна. Бүгдэд нь энэ том Үндсэн хуулийн реформыг дэмжиж, зориг өгч хамт байсанд бас чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье. Та бүгдийн дэмжлэг байхгүйгээр би юуг ч хийж чадахгүй байсан гэдгээ хүлээн зөвшөөрч байна.

Тэгээд Монгол Улс маань мандан бадрах болтугай.

Монгол Улсын ардчилсан парламентын хөгжил илүү их хөгжин дэвшихийн сайхан ерөөлийг өргөн дэвшүүлээд, чин сэтгэлээсээ та бүхэндээ талархаж байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танд. Үнэхээр Улсын Их Хурал, Засгийн газрын нэг зүгт харсан нэгдмэл хүч ардчиллын гажуудлыг засаж, авлигын үндсийг тасалж, тогтолцооны томоохон өөрчлөлтийг хийж, бид бол үнэхээр энэ Улсын Их Хурал, Засгийн газрын ажил бож өнгөрсөн 4 жил бол шинэчлэлт, өөрчлөлтийн 4 жил байж чадлаа.

Өнөөгийн энэ бүх тэмцэл, ажил хэргийн үр дүнд, реформуудын үр дүнд, өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд төр,

түмний үйл хэрэг, төрийн эрх мэдэл, үйл хэрэг, түмэн олны санал бодол 2 1 талдаа гарч ард түмэн ялах, ардчиллын гажуудлын засах, эргэлт буцалтгүй хөдөлгөөн эрч хүчээ аван урагшилж байна. Тэгээд энэ үйлсийг манлайлж хамтран зүтгэсэн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайддаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе. Талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгууль болох гэж байгаатай холбогдуулаад 2024 оны хаврын ээлжит чуулган түр завсарлах гэж байна. Сая чуулганыг завсарлуулах тухай Улсын Их Хурлын даргын захирамжийг уншиж танилцуулсан. Хаврын ээлжит чуулган бол 58 өдөр чуулж, 247 хууль, тогтоомжийг хэлэлцэн баталсан байна. Тэдгээрийн зарим онцлог хуулиудыг дурдвал Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулсантай уялдуулаад Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн найруулж, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг шинэчилж, дараагийн парламент үйл ажиллагаагаа явуулах, хэвийн ажиллах нөхцөл суурийг бүгдийг нь бүрдүүлээ.

Энд Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайдад бас нэг чиглэлийг анхааруулмаар байна. Шинэ Улсын Их Хурлын 126 гишүүний өрөөг 6 дугаар сарын 28 гэхэд бэлэн болгосон байхыг Засгийн газарт анхааруулья.

Энэ онцлог хуулиудаас тогтмол ер нь энэ 126 гишүүнтэй Улсын Их Хурлын бүрэн эрх, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, хуралдааны дэг ёсыг мэтгэлцээний зарчмаар шинэ мэтгэлцээний зарчимд бол шинэчилж өөрчилсөн 126 хүн бол ажил хэрэгч мэтгэлцээн өрнүүлдэг ийм дэг ёсыг олон улсын жишгээр баталлаа. Түүнчлэн Монгол хүн Монгол газартаа Монголын баялагтаа эзэн байх, түүний үр шимийг

иргэн бүхэнд тэгш, шуударга, хүртээмжтэй байх эрх зүйн үндсийг баталгаажуулсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталсан. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан өөрчлөлт баялагтаа Эзэн Монгол гэсэн үзэл баримтлал бодитой хэрэгжих үндэс суурь, эрх зүйн орчныг бүрдүүлээ.

Мөн Монгол Улсын тусгаар тогтнолын нэг баталгаа болсон тулгуур нь болсон Монгол малчин, Монгол мал, Монголын газар нутаг бэлчээрийн харилцан шүтэлцээг хангах шинэ эрх зүйн орчныг тогтоолоо. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиудаар, Малчдын эрх зүйн байдлын тухай хуулиудаар, мал аж ахуйн салбар бол зүгээр хэрэглээний амиа аргацаасан салбар биш. Үйлдвэрлэгч, бүтээгч хөгжлийн салбар болох шинэ замд шилжинэ. Малчдынхаа ахуй амьдрал үйл ажиллагааг төрөөс дэмжих шинэ бодлого эдгээр хуулиудаар тодорхойлогдсон. Энэ хуулиудаар хөдөө аж ахуйг хөгжүүлэх, мал аж ахуйг хөгжүүлэх урт хугацааны, дунд хугацааны, богино хугацааны шийдлүүдийг тодорхойлсон. Үр дүн эхнээсээ гарч малчид зээлээ хойшлуулж, хоршоод хөнгөлөлттэй зээл авч эхэлж байна. Цаашидаа жигдэрч цэгцрээд улам эрчимжүүлэхэд бол дээр дооргүй анхаарах хэрэгтэй байна.

Энэ чуулганаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн найрууллаа. Шүүх байгуулах тухай хуулийг баталлаа. Авлигатай тэмцэх, баялгийн хулгайг илчилж, төр ард түмний хяналтад авах, гэмт үйлдэлд нь тохирсон ял хариуцлага оногдуулах шуударга ёсны зарчмууд эдгээр хуулиар баталгаажлаа.

Бидний санаачилсан хуулиар авлига, албан тушаалын гэмт хэргийг ард түмний нүдэн дээр ил тодоор шүүх процессыг хуульчиллаа. Хуульчлан

баталлаа. Ингэснээрээ бид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр бодитой хэрэгжих үндсийг бас ялын бодлого, шүүхийн ил тод байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлсэн ийм томоохон өөрчлөлтийг хийж чадлаа. Энэ бол цэгцрэх хөдөлгөөний нэг том алхам юм.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний үндэсний төлөвлөгөөг баталлаа. Монгол Улсын хөгжлийн ирээдүй болсон бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинээр томъёолж баталлаа. Бүхэлдээ энэ хаврын чуулган тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлсэн гэж дүгнэж болохоор байна.

Энэ чуулганы хугацаанд 2 томоохон сонсголыг бас зохион байгууллаа. Энэ баялагтаа эзэн Монгол, Үндэсний Баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Ашигт малтмалын газар тусгай зөвшөөрлийн олголт, АМНАТ нийгэмд байгаа энэ асуудлуудыг ил тод болгож, цаашидаа энэ чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас баримтлах бодлогын чиглэлийг баталсан Улсын Их Хурлын тогтоолыг баталлаа. Ингэснээрээ Монголын баялаг Монгол хүн бүрд ирээдүй ба одоо үеийн ирээдүй иргэн бүрд хүртээмжтэй байх эрх зүйн үндсийг тодорхойлсон Үндэсний баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх томоохон алхмыг энэ Ашигт малтмалын сонсголоор хийж чадлаа. Энэ ажлыг тууштай зоригтой хийсэн Эдийн засгийн байнгын хороондоо талархаж байна. Баяр хүргэе. Бүхэлдээ энэ хаврын чуулган бол тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлсэн гэж хэлж болно.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурал ээлжит болон ээлжит бус 12 чуулган, хүндэтгэлийн 5 хуралдаан хийсэн. Нийт өнгөрсөн 4 жилийн хугацаанд 157 бие даасан хууль, 2116 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Улсын

Их Хурлын 436 тогтоолыг баталсан байна. Энэ бол бас түүхэн дээд амжилт гэж хэлж болно.

Тэгэхдээ манай парламент батлан гаргасан хууль тогтоомжийн тооноосоо гадна чанарын үзүүлэлтээрээ амжилт тогтоосон. Хууль батлаад үйлдвэрлээд байдаг биш хуулийнхаа биелэлтийг хянан шалгадаг тогтолцоог ард түмний нүдэн дээр нээлттэй ил сонсголоор хэлэлцдэг ийм ажлуудыг амжилттай хэрэгжүүлээ. Энэ хянан шалгалтын сонсголуудыг зохион байгуулсан, манлайлсан нийт гишүүддээ талархал илэрхийлж, баяр хүргэе ээ. Парламентын гишүүд бүгдээрээ шинэчлэгч парламентын гишүүд байж чадлаа.

Манай парламент батлан гаргасан хууль, тогтоомжийн тооноосоо гадна ийм бодит амжилт тогтоосон ажил хэрэгч парламент байж чадлаа. Ажил хэрэгч гишүүддээ талархаж байна. Та бүхэндээ.

Манай парламент ард түмний засаглах эрхийг хангах, шударга ёс, хуулийн засаглалыг тогтоох шинэчлэлүүдийг хийж, шударга ёсны төлөөх нийгмийн давлагааг эрх зүйн шинэчлэлээр дэмжсэн нь цэгцрэх хөдөлгөөнийг түрж, түүчээлсэн манлайлал болж чадсан. Тиймээс энэ парламентыг шинэтгэгч парламент, шинэчлэл, өөрчлөлтийн парламент гэж түүхэнд үлдэнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Төрийн үйл хэрэг, эрх мэдэл, түмэн олны санал бодол 2 1 зүгтээ нэг талдаа гарахыг цэгцрэх хөдөлгөөн гэж бид нэрлэж байгаа юм. Ийм учраас ард түмнийхээ санал хүсэлт тулгуурласан шийдлүүдийг бид шийдэж чадлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд, 2023 онд гүйцээн боловсруулсан нэмэлт, өөрчлөлтүүдээр эхлүүлсэн эрх зүйн хувьсгалыг та бид амжилттай хэрэгжүүлж дуусгах шатад хүргэж чадлаа. Одоо хэрэгжилтийг хангахын төлөө хичээн зүтгэх цаг ирлээ. Төрөө

цэгцлэх, шударга ёс тогтоох, авлигатай тэмцэх, салхитын мөнгөний ордыг төр, ард түмний мэдэлд буцаан авснаас эхэлсэн баялгийн хулгайг таслан зогсооход бидний үйл ажиллагаа бүрэн чиглэсэн. Үүний үр дүнд эдийн засаг сэргээж, нийгэм сэргээж, улс төр цэвэршиж эхэллээ.

Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлсэн тогтолцооны реформ эдийн засгаа сэргээх шат дараалсан арга хэмжээ баялгийн реформыг хэрэгжүүлж, далд эдийн засгийг ил болгосон системийн авлигатай хийсэн тэмцлийн үр дүнд 2016 онд 1,2 хувьтай байсан эдийн засгийн өсөлт өнөөдөр 7 хувьд хүрлээ. 1 хүнд оногдох ДНБ 2016 онд 3681 доллар байсан бол 2023 оны эцэст 5875 доллар боллоо. 13,5 их наяд төгрөгийн гадаад өрийг төлж, Монгол Улсаа дампууруулах эрсдэлээс гаргалаа.

Зөвхөн төв банк гэхэд Хятадын ардын банкнаас зээлэн авсан 2 тэрбум доллар орчмын свопын өртэй байсан бол дөнгөж саяхан 6 тэрбумын юанийн өрийг төлснөөр нийтдээ талыг нь төлж барагдууллаа. Хятадын свопын өрийг. Энэ бүхэн бол валютын цэвэр нөөцөлсний үр дүн. Энэ бүх эдийн засгийн сэргэлт төсвийн орлого нэмэгдсэн өрөөсөө салсны үр дүнд төрийн албан хаагчийн цалин 2016 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдлээ. Тэтгэврийн доод хэмжээг нэмснээр дундаж тэтгэвэр 785 мянган төгрөг боллоо. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталснаар стратегийн ордуудын 34 хувийг иргэдийн нэрийн дансанд төвлөрүүлж, баялгийг хараал биш ерөөл болгох, хөгжлийн хөтөч болгох, үржүүлэхийн хүрд болгох томоохон алхмыг бид хийж чадсан.

Төрийн дээр гарсан олигарх бүлэглэл, ард түмний боломжийг тоносон гэмт үйлдэл, авлига албан тушаалын гэмт хэрэг, цэгцрэх хөдөлгөөн эрчилсэн цаг үеийн шахалтад орж өдөр тутам илчлэгдсээр байна. Энэ хөдөлгөөн тасралтгүй үргэлжилж, авлигын үндсийг тасалсан, шударга ёс тогтсон

шинэ нийгмийн шинэ эрин үеийг эхлүүлж байна.

Парламентын хянан шалгах чиг үүргийг цоо шатад гаргаж, Хөгжлийн банкны нүүрсний, эмийн чанарын, ашигт малтмалын, ногоон автобусны гэх мэт дуулиант хэргүүдийг илчилж, иргэдийн засаглах эрх, ил тод байдал энгийн хэм хэмжээ боллоо. Иргэдийн мэдэх эрхийг хангаж, ил тод байдлыг бий болгож байгаа нь парламентын хяналтын мөн чанар бодит ажил боллоо. Энэ ажлуудыг санаачилж хэрэгжүүлсэн нийт гишүүддээ бас халуун талархал илэрхийлж, баяр хүргэж байна. Эдгээр сонсголыг зохион байгуулсан гишүүддээ, санаачилсан гишүүддээ баяр хүргэж байна.

Олон жил бугшсан тогтолцооны авлигууд ил болж, шударга ёсны цоо шинэ хэм хэмжээ тогтоож буйд энэ парламент чухал хувь нэмрээ оруулсан. Нийт нийгмийг сэргээсэн энэ сайн үйлсийг идэвхжүүлэн дэмжигч, хамтран зүтгэгч, шүгэл үлээгч нь манай парламент, манай парламентын гишүүд байж чадсан гэж үзэж байна.

Монгол төр төрийн албанд сахилга хариуцлага, ёс зүйг төлөвшүүлэх хүрээнд Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчилсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай анхдагч хуулийг баталсан. Иргэнээ дээдэлдэг төр оршин байх, иргэнээ дээдэлдэг төр, ард түмнээ хүндэлдэг байх шалгуур нь төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй мөн гэж бид үзэж эдгээр өөрчлөлтүүдийг хуульчилсан.

Хүний эрхийг дээдэлсэн парламент байхаа 2021 оны хаврын чуулганаар зарлаж авлигын эсрэг эрс шийдвэртэй тэмцэхээ 2023 оны хаврын чуулганаараа тунхаглаж эрх зүйн шинэчлэлүүдийг хийлээ. Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг Ази тивдээ анх удаа баталж, ОУПХ-той хамтран хүний эрхийн өөрийн үнэлгээг дэлхийн парламентын дотроос анх удаа хийлээ.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн баталж, авлига, албан тушаалын гэмт хэрэгт ногдуулах ялын бодлогыг чангатгаж, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж, хэрэг хянан шалгах, хөрөнгө хураах процессуудыг хялбарчилж тод болгосноор зөвхөн 2022 онд гэхэд 2 их наяд 347 тэрбум авлигачдын хөрөнгийг хурааж улсын байгууллага, улсын төсвийн орлого болгосон байна. Энэ бол зөвхөн 1 жилийн бодит эдийн засгийн үр дүн юм.

Нийгмийн бодлогын хүрээнд олон чухал хуулиудыг батлан мөрдүүлсний дотор Нийгмийн даатгалын багц хууль, Боловсролын багц хууль, Эрүүл мэндийн багц хуулиудыг онцолж болно.

Монголын боловсрол, ахмад настны тэтгэвэр, халамж шаардлагатай иргэдэд чиглэсэн халамжийн бодлогын реформыг эдгээр хуулиудаараа та бид эхлүүлж чадсан. Хамгийн сүүлд сая гэхэд бид ахмад настныхаа хуулийг баталлаа. Бид бас 3 ди буюу дижитал, делибритив, демократик парламент болох шинэчлэлийн зорилтыг дэвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах талаар мэдэгдэхүйц үр дүнд хүрлээ.

Хууль тогтоох, төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж ард түмний засаглах эрхийг цахимаар хэрэгжүүлэх үйл явц амжилтад хүрсэн. Үүнд Улсын Их Хурлаас нэвтрүүлсэн ди-парламент, ди-өргөдөл, цахим системүүд чухал үүрэг гүйцэтгэж И-монголиа цахимжилтын цахим шилжилтийн нэг салиггүй хэсэг боллоо.

Хамгийн сүүлд гэхэд бид бас манай Учрал сайдын санаачилсан Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг баталлаа. Ингэснээрээ бол технологийн 4 дүгээр хувьсгалыг дэмжигч парламент бид байж чадлаа.

Эрхэм нөхөд өө,

Улсын Их Хурал, Засгийн газрын нэг зүгт харсан нэгдмэл хүч өнгөрсөн жилүүдийн буруу муу бүхнийг засан өөрчлөх тууштай тэмцлийн үр дүнд Монголын нийгэмд турхагисан утаа, манан сэмэрч байна. Энэ бол зөвхөн эхлэл. Сэмэрсэн мананг хөөж Монголын тэнгэрийг цэлмэх ёстой. Ард түмэн ялах ёстой. Энэ бол ардчиллын мөн чанар юм.

Хэдхэн хоногийн дараа болох Улсын Их Хурлын ээлжит сонгуульд авлигачид, ард түмний боломжийг цөлмөгчид, ашигт малтмалын лицензээр Монголын газар шороо Монголын баялгийг зарж худалдагчид ялах сонголт болох ёсгүй.

Монголын газар нутаг Монголын баялаг ард түмэндээ үлдэж, баялгийн өгөөжийг Монгол хүн бүр хүртэх, улмаар улс маань сэргэн мандах, ард түмэн ялах сонголт болох ёстой. Юунаас ч үнэтэй энэ эрхэм үүрэг, хариуцлагын төлөө сонгуульдаа ёс зүйтэй, өндөр хариуцлагатай оролцохыг та бүхнээсээ хүсье.

Төрийн эрх барих дээд байгууллагад түмнээ төлөөлөх, ард түмнээсээ авсан бидний томилолтын хугацаа өндөрлөх дөхөж байна. Намчирхал, талцалыг хойш тавьж, Монголоо сэргээн мандуулах, Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцоог эрүүлжүүлэх эрхэм зорилгын төлөө гар сэтгэл нийлж ажилласан эрхэм гишүүддээ гүн талархал илэрхийлье.

Та бүхэнтэй бид энэ 4 жил ажилласан ажил бол шинэчлэлт өөрчлөлтийн 4 жилд байлаа. Та бүхэнтэй хамтран ажиллах нь бидний хувьд нэр төрийн хэрэг байлаа. Та бүхний хурц ухаан, эх оронч сэтгэл, боловсрол, чадвараар бид бас бахархаж байна. Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бүхэндээ болон Монголын нийт ард түмэндээ амжилт, ялалт, баяр бахархалыг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын тухай хуулийн 22.18-д заасны дагуу 2024 оны хаврын ээлжит чуулганыг завсарлуулж байгааг мэдэгдье.

Ингээд Улсын Их Хурлын хаврын чуулганыг түр завсарлуулсан учир хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

17.28 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ